МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар 3

Нэг. Үндэсний статистикийн салбарын 2018 оны үйл ажиллагааны тайлангийн хураангуй 5

Хоёр. Улсын их хурлын эдийн засгийн байнгын хорооноос өгсөн үүргийн хэрэгжилт 9

Гурав. Монгол улсын статистикийн салбарын 2018 оны зорилго, зорилтын хэрэгжилт, үр дүн 18

3.1 Алба ёсны статистикийн мэдээлэл, тооллого, судалгаа 18

3.2 Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүд 21

3.3 Анхан шатны мэдээний чанар, шуурхай байдлыг дээшлүүлэх 22

3.4 Арга аргачлал, ангиллыг боловсронгуй болгох 25

3.5 Үндэсний тооцооны систем, шинжилгээ судалгаа 26

3.6 Мэдээллийн технологи 29

3.7 Мэдээлэл тархаалт 33

3.8 Удирдлага, зохион байгуулалт 37

3.9 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа 38

3.10 Хүний нөөц, статистикийн сургалт 39

3.11 Санхүүгийн үйл ажиллагаа 43

Дөрөв. Монгол улсын статистикийн салбарын 2019 оны зорилго, зорилт 44

Тав. Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээний тайлан 45

Удиртгал 46

Хураангуй 46

1. Анхан шатны нэгжээс цуглуулж буй мэдээ, тайлан 47

2. Хүний нөөцийн чадавх бэхжүүлэх, давтан сургах үйл ажиллагаа, хүний нөөцийн хэрэгцээ 50

Дүгнэлт 52

ХАВСРАЛТ. ҮСХ-ноос 2018 онд шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлсэн аргачлал, маягт, асуулга, нөхөх зааврын жагсаалт 53

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНБТ	Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого
АЗБЗ	Арга зүйн байнгын зөвлөл
АНДБ	Ази, Номхон далайн байгууллага
АНДОЭЗНК	Ази, Номхон далайн орнуудын Эдийн засаг, нийгмийн комисс
ANCSDAAP	Ази, Америк, Номхон далайн орнуудын Үндэсний тооллого, Статистикийн байгууллагын дарга нарын нийгэмлэг
АҮ	Аж үйлдвэр
АХБ	Азийн хөгжлийн банк
АХС	Ажиллах хүчний судалгаа
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОЭЗД	Байгаль орчин, эдийн засгийн данс
БОЭЗДС	Байгаль орчин, эдийн засгийн дансны систем
БНСЭЗС	Байгалийн нөөцөд суурилсан эдийн засгийн судалгаа
БНУУ	Бүгд Найрамдах Унгар Улс
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газар
ДЗХ	Даргын зөвлөлийн хурал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
НАХ	Нөөц ашиглалтын хүснэгт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХС	Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сан
НҮБСК	Нэгдсэн үндэстний байгууллагын Статистикийн комисс
НҮБЕЭЗК	НҮБ-ын Европын Эдийн засгийн комисс
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОУВС	Олон улсын валютын сан
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ӨҮАББ	Өрхөд үйлчлэх ашгийн бус байгууллага

ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
СИНФОНИКА	Япон Улсын Статистик мэдээллийн зөвлөгөө, дүн шинжилгээний хүрээлэн
СХТ	Салбар хоорондын тэнцэл
СЯ	Сангийн яам
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
УИХ	Улсын Их Хурал
ҮДТ	Үндэсний дата төв
ҮНО	Үндэсний нийт орлого
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮТС	Үндэсний тооцооны систем
ХАА	Хөдөө аж ахуй
ХАОСТТ	Хүн ам, орон сууцны тооллогын товчоо
ХАӨМС	Хүн ам, өрхийн мэдээллийн сан
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХОСБ	Харилцан ойлголцлын санамж бичиг
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦАС	Цаг ашиглалтын судалгаа
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЦГ	Эрүүгийн цагдаагийн газар
ЭЗҮАСА	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал

НЭГ. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН САЛБАРЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Үндэсний статистикийн хороо 2018 онд статистикийн хууль эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн уялдааг хангаж, хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг хөгжүүлэх хүрээнд 6 зорилго, 25 зорилт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 онд бүрэн хэрэгжүүлэв.

Статистикийн тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалж, Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Аргачлал батлах тухай” журмын дагуу хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар, удирдамж, гарын авлагыг нэвтрүүлэх хүрээнд хүн ам, нийгэм, эдийн засаг, үндэсний тооцооны 67 тооллого, судалгаа, мэдээнд статистикийн үйл ажиллагааны загварыг боловсруулаа. Үүний үр дүнд статистикийн мэдээллийг бий болгох үйл ажиллагааны тогтолцоо, нөөцийг оновчтой тодорхойлж, уялдуулан зохион байгуулах асуудлаар илүү үр дүнтэй шийдвэр гаргах боломж улам бүр нэмэгдэж байна.

Олон улсад нийтлэг мөрдөгдөж буй нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистикийн арга зүйг судалж, үндэсний онцлогт тохируулсан арга зүйг боловсруулах ажлын хүрээнд нийт 39 аргачлал, арга зүй, маягт зааврыг боловсруулж, шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлсэн байна.

Үндэсний статистикийн хороо 2018 онд Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлтийг тооцох мэдээллийг анхан шатны бүртгэл, захиргааны болон албан ёсны мэдээ, мөн тооллого, түүвэр судалгаагаар долоо хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтай цуглуулав.

Үүнд:

- УСХ-ноос 2018 онд зохион байгуулсан статистикийн улсын хэмжээний нэг тооллого, 6 түүвэр судалгаанд өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг бүрэн хамруулж, мэдээллийг хугацаанд нь цуглуулж боловсруулав.
- УСХ нь хүн ам, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааны албан ёсны статистикийн 53 төрлийн мэдээг долоо хоног, сар, улирал, хагас жилийн давтамжаар графикт хугацаанд нь аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газруудаас төвлөрүүлэн авч, боловсруулсан байна.
- Мөнгө, зээл, санхүү, даатгал, гааль, татвар, байгаль орчин, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан техник, технологи, хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүнсний аюулгүй байдал, шүүхийн статистикийн мэдээллийг холбогдох яам, төрийн захиргааны нийт 27 байгууллага УСХ-ноос баталсан болон зөвшөөрсөн 206 маягтаар цуглуулан авч нэгтгэн УСХ-нд сар, улирал, жилийн давтамжтай мэдээлсэн байна.
- Дээр дурдсан албан ёсны статистикийн мэдээллээс гадна 2018 онд нийт 15 мэдээ, түүвэр судалгаа, үзлэг тооллогын мэдээллийг цуглуулж, үр дүнг боловсруулсан.
- Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн хүрээнд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллээс шинээр 45 үзүүлэлтийг нэмж тооцон, нийт 118 үзүүлэлтийн мэдээллийг 2015-2017 оны гүйцэтгэлээр гарган, мэдээллийн санд байршуулан тархааж байна.

Статистикийн шинжилгээ, судалгааны 12 танилцуулгыг бэлтгэж, статистикийн мэдээллийн нэгдсэн санд байршуулан олон нийтэд хүргэсэн. Статистикийн шинжилгээ, судалгаанд өргөн ашиглагддаг STATA13, EView9 программ ашиглах гарын авлагыг боловсруулж, цахим хэлбэрээр 1212.mn цахим хуудсанд байршуулж, нийтэд тархаасан.

Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгаа, НҮБ-ын Хүн амын сантай хамтран 2017 онд зохион байгуулсан “Жендерт суурилсан хүчирхийллийн судалгаа”-ны, 2018 онд зохион байгуулсан “Хөрөнгийн эзэмшил, аж ахуй эрхлэлтийг жендерийн төлөв байдлаар тодорхойлох нь” туршилтын судалгааны үр дүнг тархаах, олон нийтэд танилцуулах семинарыг тус тус зохион байгуулсан.

Олон улсын валютын сангийн сайжруулсан мэдээлэл тархаах ерөнхий стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Монгол банк, Сангийн яамтай хамтран Үндэсний нэгдсэн мэдээллийн цахим санг байгуулж нийгэм, эдийн засгийн 22

салбарын (бодит сектор, төсвийн сектор, санхүүгийн сектор) мэдээний баяжуулалтыг сар бүр шинэчлэн, салбаруудын мэдээллийг олон нийтэд тархааж байна.

УСХ нь мэдээллийн нууцлалын болон мэргэжлийн хараат бус, бие даасан байдлын зарчмыг баримтлан мэдээлэл тархаалтын нэгдсэн хуваарийн дагуу албан ёсны статистикийн мэдээллийг цаг хугацаанд нь шуурхай тархаалаа.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn, байгууллагын цахим хуудас www.nso.mn, 1900-1212 лавлах утас, цахим (information@nso.mn) хаяг болон бусад хэлбэрээр хэрэглэгчдэд мэдээллээр үйлчилж байна.

Монгол Улсын Нийгэм, эдийн засгийн танилцуулгыг англи, монгол хэлээр 2760 ширхэг, сар бүрийн нугалбарыг 2800 ширхэг, улирал бүрийн дундаж цалингийн инфографикийг 1200 ширхэг, “Статистикийн өврийн дэвтэр-2017”-ийг 1200 ширхэг, “Монгол улсын Статистикийн жилийн эмхэтгэл-2017” номыг 1500 ширхэг бэлтгэн УИХ, Яам, Агентлагууд, Элчин сайдын яамд, орон нутгийн Статистикийн газар, хэлтэс, Олон улсын байгууллагуудад хүргүүлсэн.

УСХ-ноос тархаах мэдээллийн хүрээг нэмэгдүүлж, цахим хуудасны дизайн, бүтцийг хэрэглэгчид ашиглахад хялбар байдлаар боловсронгуй болгон шинэчилснээр статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn цахим хуудасны хандалт 2017 оноос 81.2 хувиар өссөн байна.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбон аюулгүй байдлыг ханган тус сүлжээгээр төрийн 9 байгууллагатай мэдээлэл харилцан солилцон ажиллаж байна. Тооллого судалгаа, мэдээг цуглуулах үйл ажиллагаанд шинээр 14 программ, таблетаар мэдээлэл цуглуулахад зориулан 5 программыг шинээр боловсруулсан.

УСХ-ноос статистикийн үйл ажиллагааны бүх үе шатанд чанарын хяналтыг тухай бүрд нь тогтмол хийж байна. УСХ-ноос 2018 онд албан ёсны болон захиргааны мэдээллийг бодит байдалд нийцүүлэх зорилгоор анхан шатны мэдээллийг биечлэн үзэж шалгах болон мэдээллийн технологийг ашиглан мэдээллийн санг тулган шалгах гэсэн үндсэн 2 хэлбэрийн чанарын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулав.

Орон нутагт анхан шатны статистикийн мэдээ хариуцдаг байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээний чанарыг сайжруулах зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамтай хамтран 2018 онд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөө гарган Нийслэлийн 5 дүүрэг, 11 аймгийн 53 сум, 307 баг, 284 байгууллагад хяналт үнэлгээ хийсэн.

УСХ-ны “Хүн ам, өрхийн мэдээллийн сан” болон “Бизнес регистрийн мэдээллийн сан”-г төрийн бусад байгууллагын 10 сантай тулган шалгаж сайжруулав.

УСХ нь 2018 оны сургалтын хөтөлбөрийг үндэсний статистикийн салбарын төв болон орон нутгийн статистикийн байгууллагуудад болон төрийн захиргааны бусад байгууллагуудад зориулсан, статистикийн мэдээлэгч, хэрэглэгчид төдийгүй ерөнхий боловсролын сургуулийн сурагч, их дээд сургуулийн оюутанд гэсэн олон төрлийн түвшин, модулиудыг дотроо агуулсан байдлаар боловсруулсан.

Статистикийн мэргэжлийн мэдлэг, чадварыг ахиулах, бусад орны туршлагаас судлуулах зорилгоор статистикийн салбарын 67 ажилтныг олон улс болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан 72 удаагийн семинар, сургалтад хамруулав.

Монгол Улсын статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд мэргэжлийн 4 шатлалт сургалтыг зохион байгуулж, статистикийн онол, нийгэм, эдийн засгийн салбарын статистик, эконометрик, статистикийн программ хангамж, үндэсний тооцоо, түүврийн дизайн, салбарын хууль, эрх зүйн мэдлэгийг олгож байна. Мэргэжлийн дөрвөн шатны сургалтад 2018 онд нийт 81 ажилтан суралцсан.

Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлагад үндэслэн төрийн байгууллагын албан хаагчид, хэвлэл мэдээллийн болон аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнууд, их дээд сургуулиудын оюутнууд, ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад сургалтуудыг зохион байгуулж нийт 4900 орчим хүнийг хамруулаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 1-11 дүгээр ангийн сурагчдын математик, статистикийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан “Статистикийн арга зүйн гарын авлага”-ыг Боловсролын хүрээлэнтэй хамтран боловсруулан гаргасан.

Үндэсний статистикийн хорооны санхүүгийн баримт болон НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан зэрэг төслүүдийн 2017 оны санхүүгийн баримтад аудит хийлгэж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн дүнгээр зөрчилгүй дүгнэлттэй гарсан.

Дэлхийн 178 улс орны статистикийн байгууллагуудын мэдээллийн хүртээмж болон нээлттэй байдлыг үнэлсэн тайланг Open Data Watch байгууллагаас жил бүр зарладаг. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо 2018 оны үнэлгээгээр 75.6 оноо авч дэлхий хэмжээнд 13 байраар урагшилж 11 дүгээрт, зүүн өмнөд Азийн бүсэд нэгдүгээрт бичигдсэн байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 25 өдөр Дугаар 08 Улаанбаатар хот

Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний статистикийн хорооны бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх, төсөв, санхүүжилтийн хүрэлцээг нэмэгдүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах чиглэлээр идэвхтэй дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Үндэсний статистикийн хороо /А.Ариунзаяа/-нд чиглэл болгосугай:

1/Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгж байгуулах асуудлыг шуурхай шийдвэрлэх;

2/албан ёсны статистикийн тогтолцоог анхан шатны нэгжид бэхжүүлэх, эдийн засаг, нийгмийн суурь судалгааны үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэх, мэдээллийн бодит байдлыг хангахад шаардагдах төсөв, санхүүгийн тооцоо, судалгааг хийж, эх үүсвэрийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

3/үндэсний статистикийн тооллого судалгаа, мэдээний чанар, хамралт анхан шатны нэгжээс шууд хамааралтайг үндэслэн Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу статистикийн үйл ажиллагааг анхан шатанд эрхлэн гүйцэтгэдэг сумын Засаг даргын Тамгын газрын тухайн асуудал хариуцсан ажилтан, баг, хорооны Засаг даргын ажиллах нөхцөлийг сайжруулах, тэднийг орчин үеийн техник, хэрэгслээр шат дараалалтай хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4/Монгол Улсын боловсролын салбарт статистикийн үйл ажиллагааг дэмжсэн бодлого хэрэгжүүлж, статистикийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг сургах, давтан сургаж мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох.

2.Статистикийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Үндэсний статистикийн хороо /А.Ариунзаяа/-нд чиглэл болгосугай.

1/Монгол Улсыг хөгжүүлэх дунд болон урт хугацааны бодлого чиглэл, Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх хөтөлбөртэй уялдуулан

Статистикийн тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулах;

2/төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах;

3/төрийн захиргааны холбогдох байгууллагатай хамтран статистикийн мэдээллийн чанар, үнэн зөв байдалд хяналт шалгалт хийх, шат шатны хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах;

4/албан ёсны статистикийн үйл ажиллагааг мэргэжлийн төвлөрсөн удирдлагаар хангаж, мөрдөгдөж байгаа арга зүй, аргачлалд үнэлгээ хийж, тэдгээрийг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

5/хөгжлийн төлөвлөлт, төрийн бодлого шийдвэрийн боловсруулалт, удирдлага зохицуулалт, хяналт шалгалтын ажилд шаардлагатай статистик мэдээлэл, судалгааны нэр төрлийг нэмэгдүүлэх, статистикийн судалгаа шинжилгээний чанарын түвшинг дээшлүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан нэгтгэн гаргаж, Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Үндэсний статистикийн хороо /А.Ариунзаяа/-нд үүрэг болгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНООС ӨГСӨН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 8 дугаар тогтоолоор өгсөн чиглэлийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. **Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд салбарын үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгж байгуулах асуудлыг шуурхай шийдвэрлэх чиглэлийн хүрээнд;**

Яам, агентлагуудын болон орон нутгийн бүх түвшний төрийн байгууллагууд өөрийн дотоод удирдлагын зориулалтаар захиргааны мэдээлэл цуглуулж, боловсруулж, хадгалдаг. Гэвч төрийн бусад байгууллагуудад ашиглаж буй эдгээр захиргааны бүртгэл мэдээлэл нь тэр бүр статистикийн мэдээлэл болгож ашиглах чанарын шаардлагыг хангадаггүй, мөн тухайн байгууллага нь цуглуулсан их хэмжээний мэдээллээ бараг ашигладаггүй шахуу байна. Энэ нь тухайн төрийн байгууллагад статистикийн мэргэжлийн нэгж байхгүйтэй шууд холбоотой юм. 2018 оны байдлаар төрийн 26 байгууллагаас Монгол банк (Судалгаа, статистикийн газар), Гаалийн ерөнхий газар (Статистикийн хэлтэс), Татварын ерөнхий газар (Мэдээлэл, технологи, статистикийн төв), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Эрүүл мэндийн мэдээллийн алба), Цагдаагийн ерөнхий газар (Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба), Авлигатай тэмцэх газар (Судалгаа шинжилгээний алба), Шүүхийн ерөнхий зөвлөл (Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн) зэрэг байгууллагууд бүтцэдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна. Бусад байгууллагуудын хувьд 1-2 ажилтан статистикийн мэдээлэл хариуцан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хороо захиргааны нийт 206 багц мэдээллийн 70 орчим хувийг албан ёсны статистикийн мэдээллийг нэгтгэн гаргахад ашиглаж байна. Өөрөөр хэлбэл захиргааны мэдээлэл нь албан ёсны статистикийн үйл ажиллагааны шат дамжлага, зардлыг хэмнэх боломжтой томоохон мэдээллийн нэг эх үүсвэр юм.

Статистикийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, төрийн захиргааны төв байгууллагууд бүтцэдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжийг зайлшгүй бий болгох шаардлага, үндэслэлийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгийн талаар санал бэлтгэн танилцуулсан. УСХ-ны саналыг Монгол Улсын Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын даргад 2018 оны 7-р сарын 17-ны өдөр "Яам, төрийн захиргааны төв байгууллага бүтцэдээ салбарын статистикийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байх хуулийн заалтыг хэрэгжүүлэх тухай" 01/559 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

2. **Албан ёсны статистикийн тогтолцоог анхан шатны нэгжид бэхжүүлэх, эдийн засаг, нийгмийн суурь судалгааны үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэх, мэдээллийн бодит байдлыг хангахад шаардагдах төсөв, санхүүгийн тооцоо, судалгааг хийж, эх үүсвэрийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд:**

Сумдад статистикийн асуудал хариуцсан ажилтны орон тоог бий болгох шаардлага, тооцоо судалгааг боловсруулан "Суманд статистикийн асуудал хариуцсан бие даасан орон тоог бий болгох тухай" 2018 оны 4 сарын 13 өдрийн 01/325 болон 2018 оны 7 сарын 17 өдрийн 01/560 тоот албан бичгүүдийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо болон Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын даргад тус тус хүргүүлсэн.

Сум болон нийслэлийн хороо бүрд статистикийн асуудал хариуцсан бие даасан орон тоог бий болгох нь зөвхөн албан ёсны статистикийн мэдээллийн бодит байдалд эергээр нөлөөлөхөөс гадна тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн байдлын талаарх статистик мэдээлэлтэй болж, хөгжлийн бодлогыг боловсруулахад ч ач холбогдолтой юм. Иймд засаг захиргааны энэ шатанд статистикийн асуудал хариуцсан бие даасан орон тоог бий болгосон байхыг Статистикийн тухай болон холбогдох хууль тогтоомжид тусгаж шийдвэрлүүлэхээр УСХ-ноос анхаарч ажиллаж байна.

УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагын хувьд ЭЗБХ-ны хурлаар Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн зургаан удаагийн хуралдааны тэмдэглэлд “Үндэсний статистикийн салбарын ажилтнуудын нийгмийн асуудал, түүний дотор цалин хөлс, орон сууцны хангамж хангалтгүй, суурь судалгааны үзүүлэлтийг нэмэгдүүлэх болон мэдээллийн чанарт хяналт мониторинг хийх зардал хомс, мэдээлэл цуглуулах, боловсруулахад техник, тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ дутмаг байгааг онцлон тэмдэглэж, шаардлагатай арга хэмжээ авах”-ыг тусгайлан заасан боловч тодорхой үр дүн гарахгүй байгаа билээ.

ҮСХ-нд 2013 оноос хойш хөрөнгө оруулалтын зардал огт тусгагдаагүй бөгөөд үүнтэй холбоотойгоор салбарын хэмжээнд компьютер, принтер, ширээ, сандлын хомсдол үүсэж цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэл учирч байна.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос 2018 онд статистикийн байгууллагын бие даасан хараат бус байдлыг бэхжүүлэх, түүний үйл ажиллагаанд хүрэлцээтэй төсөв, санхүү мэргэжлийн боловсон хүчний чиглэлээр идэвхтэй дэмжин ажиллах талаар холбогдох байгууллагуудад үүрэг даалгаврыг дахин өгсөн.

3. Үндэсний статистикийн тооллого, судалгаа, мэдээний чанар, хамралт, анхан шатны нэгжээс шууд хамааралтайг үндэслэн Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу статистикийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг сумын ЗДТГ-ын тухайн асуудал хариуцсан ажилтан, баг, хорооны засаг даргын ажиллах нөхцөлийг сайжруулах, тэднийг орчин үеийн техник хэрэгслээр шат дараалалтай хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах чиглэлээр:

“Статистикийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх”, “Өрхөд суурилсан судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх”, “Анхан шатны баримт бүрдүүлэлт, өмчийн бүртгэл, ашиглалт”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын арга зүй, зохион байгуулалт”, “Статистикийн мэдээллээр инфографик хийх, статистикийн SPSS, E-Views, MS-Excel, MS-Access программын”, “Орон нутгийн салбарын мэдээллийн технологи хариуцсан ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх” зэрэг сургалтыг салбарын төв, орон нутгийн албан хаагчдад тус тус зохион байгуулсан. Энэ сургалтад хамрагдсан аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын ажилтнууд өөрийн баг, хороо, сумын статистикийн асуудал хариуцсан ажилтнуудад зориулж, тусгайлсан сэдвээр сургалтуудыг байнга явуулж байна.

Нийслэлийн 9 дүүргийн 152 хорооны Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт зориулсан “Нээлттэй мэдээллийг бий болгох чадавхыг бэхжүүлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулж 1530 албан хаагчид хамрагдсан.

Аймгийн статистикийн хэлтэс ҮСХ-ны ажилтнуудтай хамтран сумын статистикийн асуудал хариуцсан ажилтнуудад анхан шатны мэдээллийг цуглуулах, цуглуулсан мэдээллийг хянаж шалгах, статистикийн аргачлалаар боловсруулалт хийх шат дараалсан буюу ахисан түвшний сургалтыг 2018 онд зохион байгуулсан.

ҮСХ, БСШУСЯ, ЭМЯ-тай хамтран 11 аймгийн 52 сум, нийслэлийн 4 дүүрэг, 302 баг, 430 байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөн тусалж ажилласан нь анхан шатнаас цуглуулж байгаа болон тооллого, судалгааны анхдагч мэдээллийн чанарт тавих нэгжийн дотоод хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх, арга зүйн нэгдмэл байдлыг хангах, статистикийн төв, орон нутгийн байгууллага болон албан ёсны статистикийн анхдагч мэдээллийг гаргадаг анхан шатны нэгжийн хамтын ажиллагаа, эргэх холбоог улам сайжруулах ач холбогдолтой ажил болсон.

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас нийт 1410 багийн Засаг дарга нарт олгосон зөөврийн компьютерт “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”, “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ын программ хангамжуудыг суулган, ашиглах сургалтыг зохион байгуулсан.

Монгол Улсын хэмжээнд бүх сумдын статистик хариуцсан ажилтнуудад төрийн албаны и-мэйл хаяг нээж, нууц үг, ашиглах зааврыг орон нутгийн статистикийн хэлтсээр дамжуулан хүргүүлж ажилласан. Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хариуцан ажиллаж байна.

4. Монгол Улсын боловсролын салбарт статистикийн үйл ажиллагааг дэмжсэн бодлого хэрэгжүүлж, статистикийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг сургах, давтан мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:

Статистикийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор Монгол Улсын Их Сургуульд Статистикийн тэнхимийг сэргээн байгуулахад Засгийн газраас үзүүлэх дэмжлэгийн талаар санал бэлтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд тус тус хүргүүлсэн.

Статистикийн боловсрол нь манай үндэсний хэрэгцээ тул жил бүр статистикийн өдрийг тохиолдуулан улс даяар статистикийн байгууллага, мэргэжлийг сурталчилсан танилцуулах хичээлийг ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад заадаг уламжлалын дагуу сургалтыг хийлээ.

ҮСХ, Боловсролын хүрээлэнтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн 1-11-р ангийн сурагчдын математик, статистикийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх зорилгоор математикийн багшийн “Статистикийн арга зүйн гарын авлага”-ыг боловсруулан 8000 хувь хэвлүүлж, ерөнхий боловсролын 798 сургуульд хүргүүлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт Багшийн боловсрол дээшлүүлэх институттэй хамтран сургалт зохион байгуулсан.

Монгол Улсад дээд боловсролтой Статистикийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 50 жилийн ойг тохиолдуулан МУИС-ийн Шинжлэх Ухааны сургууль, Мандах Их сургууль болон Монголын Математикийн багш нарын академитай хамтран статистикийн улсын 2 олимпиад, уралдааныг статистикийн үндэс түвшний хичээл судалж буй их, дээд сургуулийн I, II дамжааны оюутнууд, ЕБС-ын сурагчдын дунд тус тус зохион байгуулсан.

Монголын Математикийн багш нарын академитай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Тогтвортой хөгжлийн зорилго-2030 ба хуванцар хог хаягдлын аюул" сэдэвт улсын анхдугаар уралдааныг зохион байгуулж 740 сурагч оролцсон.

5. Монгол Улсыг хөгжүүлэх дунд болон урт хугацааны бодлого чиглэл, Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх хөтөлбөртэй уялдуулан Статистикийн тухай хуульд зохих нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд:

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, тайланг боловсруулав. Мөн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг дэлгэрэнгүй болон хураангуй байдлаар боловсруулсан.

Хуулийн төслийг боловсруулахад НҮБ-ын Албан ёсны статистикийн үндсэн зарчим, НҮБ-ын Албан ёсны статистикийн ерөнхий хууль, Финланд, Турк, Молдав улсын Статистикийн хууль болон Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Гааль, Татвар, Нийгмийн даатгалын ерөнхий хууль зэрэг хуулиудыг судлан, салбарын албан хаагчдад танилцуулж, гарсан саналыг нэгтгэн тусгасан.

6. Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах ажлын хүрээнд:

Төрийн мэдээлэл солилцооны систем буюу ХУР системд холбогдох гэрээг байгуулан, мэдээлэл солилцох хуудсыг шинэчлэн, төрийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан нууцлал хангасан техникийн тохиргоог хийсэн. ҮСХ-ноос 2018 онд төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн сангийн уялдаа, мэдээллийн технологийг ашиглах, хангах чиглэлд ахиц дэвшил гарлаа.

Төрийн байгууллагуудын мэдээллийн нээлттэй байдал, ялангуяа захиргааны бүртгэл, статистикийн мэдээллийг технологийн хөгжлөөр дамжуулан ашиглах боломж өсөж байна. Түүнчлэн мэдээллийн технологи нь хамгийн бага зардлаар мэдээллийг цуглуулах, тархаах боломжийг олгож байна. Статистикийн зарим мэдээллийг мэдээлэл цуглуулах шат дамжлага цөөрч, мэдээллийн давхардалгүй болж, мэдээлэл боловсруулах хугацаа багасаж, мэдээллийн ашиглалт нэмэгдэж, мэдээллийн бодит байдал эрс сайжирч байна. **Тухайлбал:**

- Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас "Хуулийн этгээдийн тухай мэдээлэл, шинээр байгуулагдсан, татан буугдсан, өөрчлөгдөн зохион байгуулагдсан 4 төрлийн мэдээллийг авч ашиглах боломжийг бүрдүүлсэн.
- Хил хамгаалах ерөнхий газраас Монгол Улсын иргэдийн хил нэвтрэлтийн тухай мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн сервисийг Хил хамгаалах ерөнхий газар, Үндэсний дата төвтэй хамтран хийж, Гадаадад суугаа Монгол Улсын иргэдийн бүртгэлийн системд ашиглаж байна.
- Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн сарын мэдээг онлайн системээс файл серверээр дамжуулан авч байна.
- Эрүүл мэндийн даатгалын газартай хамтран өрхийн эмнэлгүүдэд тулгуурласан шинэ цахим системийг хөгжүүлж, хөнгөлөлттэй эм олгох мэдээллийн санг Хүн ам, өрхийн мэдээллийн сантай холбон ашиглалтыг сайжруулсан.
- Эрүүл мэндийн яамнаас төрөлт, нас баралтын мэдээллийг хугацааны давтамжийн дагуу ашиглах боломжийг бүрдүүлж нууцлал, аюулгүй байдлыг ханган ашиглуулж байна.
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран мэдээллийн сантай холбогдсон нь орон зайн мэдээллийн сангийн чанарыг сайжруулахад төдийгүй мэдээллийн бусад сангийн бодит байдлыг эрс сайжруулж байна.
- ҮСХ, Эрүүл мэндийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар хамтран шинээр төрсөн хүүхдийг 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийслэлийн бүх шатлалын эмнэлэгт, 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс аймгийн төрөх эмнэлэгт цахимаар бүртгэж эхэлсэн. Ингэснээрээ Эрүүл мэндийн яамны бүртгэл болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын төрөлт, нас баралтын бүртгэлийн дунд нэг ч иргэн орхигдохгүй байх боломжийг бүрдүүлж байна. Ингэснээр хүн ам зүйн

үндсэн үзүүлэлтээр гаргаж буй эрүүл мэндийн статистикийн үзүүлэлтийг өрхийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлттэй холбох, хүн амын ердийн хөдөлгөөний талаарх тоо мэдээг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргаж, олон улсын жишигт нийцсэн статистикийг шинээр бий болгох, төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн уялдаа холбоог сайжруулах, мэдээлэл харилцан солилцох, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах нөхцөл бүрдсэн.

7. Төрийн захиргааны холбогдох байгууллагатай хамтран статистикийн мэдээллийн чанар, үнэн зөв байдалд хяналт хийх, шат шатны хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагааг явуулах хүрээнд:

УСХ-ноос 2018 онд албан ёсны болон захиргааны мэдээллийг бодит байдалд нийцүүлэх зорилгоор анхан шатны мэдээллийг биечлэн үзэж шалгах болон мэдээллийн технологийг ашиглан мэдээллийг тулган шалгах гэсэн үндсэн 2 хэлбэрийн чанарын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулав.

Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн хяналтыг сайжруулахад статистикийн салбарт ажиллаж буй ажилтнуудын чанарын удирдлагын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлж ажилласан. Ялангуяа анхдагч мэдээллийг гаргах үе шатанд ажиллагчдын ажлын уялдааг хангах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор мэдээллийн чанарт тавих дотоодын хяналтыг хамтран хийв.

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яамтай хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, удирдамжийг 2017 онд баталсан билээ. Энэ ажлыг өнгөрсөн онд үргэлжлүүлж Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Хэнтий аймгийн 53 сум, 307 баг, 284 байгууллага, Нийслэлийн Статистикийн газар, Налайх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн байгууллага, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн боловсролын байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.
- Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын хяналтын ажлыг ХХААХҮЯ-тай хамтран 12 аймаг, нийслэлд зохион байгуулсан.
- БОАЖЯ, ЗТХЯ, ХНХЯ, ЭМЯ, БСШУСЯ зэрэг яам, төрийн захиргааны байгууллагуудын статистикийн асуудал хариуцсан ажилтнуудтай тухайн салбарын статистикийн мэдээллийн чанарыг хэрхэн сайжруулах, мэдээллийн урсгалыг оновчтой болгох, мэдээллийн сан байгуулах, бусад мэдээллийн эх үүсвэрүүдтэй уялдуулах талаар уулзалт ярилцлага зохион байгуулав. Мөн статистикийн мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх талаар санал солилцож, заавар, зөвлөмж өгч, мэдээний график гарган батлуулж, үндсэн нэгжид хүргүүлэх, статистикийн мэдээллийг хариуцсан ажилтантай болох ажлыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэн ажилласан.
- ХЗДХЯ-ны харьяа байгууллагуудтай хамтран ажиллах ажлын удирдамжийн хүрээнд Хил хамгаалах ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт ажиллаж, анхан шатны мэдээллийн чанар, статистик мэдээлэл гаргахад тулгамдаж буй асуудалтай танилцах, мэргэжил арга, зүйн зөвлөгөө өгч ажиллав.

УСХ-ноос 2018 онд мэдээллийн технологийг ашиглан төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн сангийн уялдаа холбоог сайжруулж, мэдээллийн зөрүүг арилгах ажлыг зохион байгуулсан. Тухайлбал:

УСХ-ны “Хүн ам, өрхийн мэдээллийн сан” (ХАӨМС)-гийн чанарыг сайжруулах, бусад мэдээллийн сантай уялдуулж, мэдээллийн зөрүүг арилгах зорилгоор дараах ажлыг хийв. Тухайлбал:

- ХАӨМС-ийн аймаг, нийслэлийн засаг захиргааны нэгжийн санд гарсан хүндрэлийг цаг тухай бүрд шийдвэрлэж, засварууд тусгаж мэдээллийн санг сайжруулж байна.
- Монгол Улсын 330 сумын Засаг даргад "Хүн ам, өрхийн мэдээллийн сан"-ын харах эрхийг үүсгэж ашиглалтыг нэмэгдүүлсэн.
- Нийгмийн даатгал, халамж үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн санг ХӨАМС-ийн мэдээллийн сантай тулгалт хийсэн.
- БСШУСЯ-ны мэдээллийн санг ХӨАМС-ийн мэдээллийн сантай тулгалт хийж сайжруулсан.
- Эрүүл мэндийн яамны төрөлт, нас баралтын мэдээллийг “Хүн ам, өрхийн мэдээллийн сан” (ХАӨМС)- тай тулган шалгаж баяжуулсан.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын өрхийн мэдээллийн санг 2017 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын мэдээлэлтэй 3 удаагийн тулган шалгалт хийсэн.
- Байшин орон сууцны туршилтын тооллогын нэгжийн хаягийн мэдээллийг ГЗБГЗЗГ-аас хүлээн авч, шинэ хуучин хаягийн мэдээллийг давхцуулан, мэдээлэл цуглуулалтад ашиглан,

туршилтын тооллогын үр дүнд үндэслэн хаягийн мэдээллийг ХАӨМС-ийн өрхтэй тулгах ажлыг гүйцэтгэж сайжруулсан.

- ҮСХ-ны “Бизнес регистрийн мэдээллийн сан”-гийн мэдээллийг дараах төрийн байгууллагуудын мэдээллийн сантай уялдуулж, мэдээллийн зөрүүг арилгасан. Тухайлбал:
- Сангийн яамны санхүүгийн тайлангийн 2014-2016 оны хөрөнгийн хуримтлалын мэдээлэл;
- Татварын ерөнхий газрын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын мэдээллийн сангийн мэдээлэл;
- Эрүүл мэндийн яамны мэдээллийн санд бүртгэлтэй 1900 эрүүл мэндийн байгууллага;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны мэдээллийн санд бүртгэлтэй 2337 сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл;
- Төрийн өмчийн бодлогыг зохицуулах газрын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 104 хуулийн этгээдийн 2017 оны жилийн эцсийн мэдээлэлтэй тулган шалгаж, холбогдох мэдээллийн уялдааг хангаж ажилласан.

8. **Албан ёсны статистикийн үйл ажиллагааг мэргэжлийн төвлөрсөн удирдлагаар хангаж, мөрдөгдөж байгаа арга зүй, аргачлалд үнэлгээ хийж, тэдгээрийг боловсронгуй болгох арга хэмжээ авах чиглэлээр:**

Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (GSBPM), удирдамж, гарын авлагыг нэвтрүүлэх хүрээнд хүн ам, нийгэм, эдийн засаг, үндэсний тооцооны 67 тооллого, судалгаа, мэдээнд статистикийн үйл ажиллагааны загварыг боловсруулаа.

Олон улсын валютын сангийн сайжруулсан мэдээлэл тархаах ерөнхий стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Монголбанк, Сангийн яамтай хамтран Үндэсний нэгдсэн мэдээллийн цахим санг байгуулж нийгэм, эдийн засгийн 22 салбарын (бодит сектор, төсвийн сектор, санхүүгийн сектор) мэдээний баяжуулалтыг сар бүр шинэчлэн, салбаруудын мэдээллийг олон нийтэд тархааж байна.

Олон улсад нийтлэг мөрдөгдөж буй нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистикийн арга зүйг судалж, үндэсний онцлогт тохируулсан арга зүйг боловсруулах ажлын хүрээнд нийт 39, үүнээс 18 аргачлал, арга зүй, 21 багц маягт, нөхөх зааврыг шинээр болон шинэчлэн боловсруулан баталж, мөрдүүлсэн. Эдгээрийн 9 аргачлал, 19 багц маягт, нөхөх зааврыг шинээр боловсруулсан байна.

9. **Хөгжлийн төлөвлөлт, төрийн бодлого шийдвэрийн боловсруулалт, удирдлага зохицуулалт, хяналт шалгалтын ажилд шаардлагатай статистик мэдээлэл, судалгааны нэр төрлийг нэмэгдүүлэх, статистикийн судалгаа шинжилгээний чанарын түвшинг дээшлүүлэх чиглэлийн хүрээнд:**

Сүүлийн жилүүдэд хүн ам, нийгэм, байгаль орчин, эдийн засгийн хөгжлийн шинэ чиг хандлагыг судлан илэрхийлэх статистикийн мэдээллийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдсээр байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бодлогыг тодорхойлох, үүсэж буй асуудлыг шуурхай, үр дүнтэй шийдвэрлэхэд шаардлагатай эдийн засгийн үйл ажиллагаа, нийгмийн байдлын статистик үзүүлэлт, мэдээллийн хэрэгцээ маш хурдацтай нэмэгдэж байна.

Бид бодит байдлыг илтгэж чадах статистик үзүүлэлтүүдийг шинээр тооцох, арга аргачлалыг сайжруулах, мэдээллийн урсгал, давтамжийг оновчтой тогтоох, чанарыг сайжруулах, мэдээллийг шуурхай цуглуулж, боловсруулж, тархаах талаар үйл ажиллагаагаа төлөвлөж, хэрэгжүүлж байна.

ҮСХ-ны даргын 2017 оны А\203 тоот тушаалаар баталсан “ҮСХ-нд нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсээс 2018 онд цахим шуудангаар ирүүлэх мэдээ, тайлангийн график” болон “ҮСХ-нд яам, газруудаас 2018 онд ирүүлэх мэдээ тайлангийн график”-ын дагуу дээр дурдсан албан ёсны статистикийн мэдээллээс гадна 2018 онд дараах мэдээ, түүвэр судалгааны мэдээллийг цуглуулж, үр дүнг боловсруулсан. **Үүнд:**

- “Ардчилсан засаглал” судалгааны асуулга, зааврыг 2018 онд шинэчлэн боловсруулж, батлуулсан. Уг судалгааны мэдээлэл цуглуулалтад ажиллах Улаанбаатар хотын судлаач нарт танхимын сургалт, орон нутгийн судлаач нарт online сургалт зохион байгуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны 4-р улирлын судалгаанд нэмэлт модуль хэлбэрээр зохион явуулсан.
- “Ардчилсан засаглал” судалгааны мэдээллээр 2009-2017 оны динамик үүсгэн, танилцуулга бичиж тархаасан.
- Дэлхийн 190 гаруй улс орныг хамарсан “Олон улсын өртгийн зэрэгцүүлэлт 2017” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд машин, тоног төхөөрөмжийн үнийн судалгаа, барилгын материалын бүтээгдэхүүний үнийн судалгааг 2017-2018 оны байдлаар, өрхийн хэрэглээ бараа, үйлчилгээний үнийн судалгааг 2018 оны 1-4 дүгээр сарыг

хамруулан зохион байгуулж, үр дүнг гарган АХБ-д тухай бүр хугацаанд нь хүргүүлсэн.

- Орон сууцны тоо, хэмжээ болон чанарын мэдээлэл цуглуулах асуулга, орон сууцны мета мэдээлэл, мэдээллийн боломжит байдал зэргийг АХБ-наас ирүүлсэн асуулга, маягтын дагуу 2015 оны хүн ам, орон сууцны завсрын тооллогын мэдээлэл болон орон сууцны түрээсийн мета мэдээлэл, үндэсний тооцооны орон сууцны түрээстэй холбоотой асуулгыг бэлтгэн үр дүнг тооцсон.
- Орон сууцны түрээсийн үнийн каталог, судалгааны маягт зааврыг боловсруулж, мэдээлэл цуглуулалтыг бүх аймагт нэг удаа зохион байгуулан явуулж, орон сууцны түрээсийн үнийн мэдээллийг боловсруулсан.
- Хангамж, хэрэглээний данс /Хүнсний балансыг туршилтаар байгуулахад шаардлагатай 2015-2017 оноор мэдээллийг цуглуулав.
- Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 308 дугаар тушаалын дагуу Налайх дүүрэгт далд аргаар болон хууль бусаар нүүрс олборлосны улмаас иргэдийн эрүүл, аюулгүй ажиллах амьдрах үндсэн эрх зөрчигдөж байгаатай холбогдуулан дүүргийн иргэдийн дунд Зөвлөлдөх санал асуулгыг хоёр үе шаттайгаар зохион байгуулж үр дүн, тайланг 48 цагийн дотор боловсруулж Зөвлөлдөх зөвлөлд хүргүүлсэн.
- Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хүн амын сан, Оюу толгой ХХК хамтран үндэслэлтэй бодит статистикийн мэдээлэлд тулгуурлан үнэлэлт, дүгнэлт өгөх нотолгоонд суурилсан бодлогын зөвлөмж гаргах зорилгоор "Өмнөговь аймагт нийгэм, эдийн засаг, байгаль орчны судалгаа" хийх төслийг 4-р сараас нэг жилийн хугацаанд хэрэгжүүлж байна. Төслийн үр дүнд Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны загвар суурь судалгаа гаргаж, цаашид бусад аймагт жишиг болгон хэрэгжүүлэх юм.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх анхдагч мэдээллийн сан байгуулах, үзлэг тооллогыг зохион байгуулахаар төлөвлөж, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар үзлэг тооллогыг зохион байгуулах ажлын хэсэг, ажлын удирдамжийг баталж 11 байгууллагын 22 гишүүн ажиллаж байна. Туршилт үзлэг, тооллогыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Эрүүл мэндийн яамтай хамтран Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сум, Сэлэнгэ аймгийн Орхон сумдад зохион байгуулсан.
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик, нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор малын бүртгэлийн мэдээллийн санг сайжруулах, шинээр маягт, заавар боловсруулах, малчин өрхийн мэдээллийн сангийн мэдээг тулган нягтлах, цаашлаад төрийн мэдээлэл солилцооны "Хур" системд холбох зэрэг ажлыг ХХААХҮЯ-тай хамтран хийж байна.
- Жендэрийн статистикийн мэдээллийг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулж хуулиар үүрэг хүлээгчдэд хүргүүлэх, жендэрийн статистикийг нэгтгэн боловсруулах программ хангамжийг нэвтрүүлэх, мэдээллийн санг бүрдүүлэхээр Жендэрийн үндэсний хороотой хамтран ажиллаж байна.
- Хуульчдын талаарх албан ёсны мэдээлэлтэй болох, цаашид НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын холбогдох үзүүлэлтүүдийг дүгнэхэд шаардлагатай хуульчдын нас, хүйс, боловсролын зэрэг, ажилласан жилийн туршлага, шинээр олгогдсон эрх, эрх хасагдсан, мэргэжлийн хариуцлагын хороонд ирүүлсэн гомдлын шийдвэрлэлт зэрэг болон хуульчдын талаарх албан ёсны мэдээлэлтэй болох зорилгоор Монголын Хуульчдын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд аргачлал, маягт, заавар, мета мэдээллийн санг боловсронгуй болгох, статистик мэдээллийг албан ёсоор 2019 оноос олон нийтэд хүргэхээр хамтран ажилласан.
- БСШУСЯ, Биеийн тамир, спортын газартай хамтран 2017 онд анх удаа зохион байгуулсан Биеийн тамир, спортын улсын үзлэг, тооллогын нэгдсэн дүн спортын цол, зэрэгтэй тамирчин, дасгалжуулагч, шүүгч, спорт заал, гадна талбай зэрэг олон үзүүлэлтийг гаргасан тайланг 2018 онд нийтэд танилцуулсан.
- Ногоон хөгжлийн 33 үзүүлэлтийг 2013 он болон 2017 оны байдлаар тооцож, динамикийг шинэчилж, статистикийн мэдээллийн санг баяжуулав. ҮСХ, яам, төрийн төв байгууллагын 70 ажилтанд зориулсан "Ногоон хөгжлийн үзүүлэлт, ногоон ажлын байр" сургалтыг 2018 оны 3-р сарын 15, 16-нд зохион байгуулав.
- "Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлага" судалгааны үндсэн үр дүнгийн тайланг НҮБ-ийн Хүн амын сангийн Ази Номхон Далайн Бүсийн Орнуудын бүсийн зөвлөхтэй хамтран Англи, Монгол хэлээр боловсруулан тархаав.
- "Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны үр дүнд үндэслэн хүчирхийлэлд өртөх эрсдэлийн шинжилгээ" судалгаа,

шинжилгээний ажлыг хийсэн.

- Үндэсний статистикийн хороо Азийн хөгжлийн банктай хамтран зохион байгуулсан “Хөрөнгийн эзэмшил, аж ахуй эрхлэлтийг жендерийн төлөв байдлаар тодорхойлох нь” туршилтын судалгааны үр дүнг танилцуулсан. Туршилтын судалгааг 3 үе шаттайгаар 3008 өрхийн 5592 гишүүнээс ярилцлага хэлбэрээр авсан бөгөөд хөрөнгө эзэмших, аж ахуй эрхлэлт нь жендерийн түвшинд ямар байгаа талаарх мэдээлэл бий болгосон.
- "Албан ёсны статистикт их өгөгдлийг ашиглах боломж ба сорилт" танилцуулгыг боловсруулав.
- “Хууль бус үйл ажиллагаа” судалгааны ажлын хүрээнд “Хар тамхи, мансууруулах бодисын худалдааны өнөөгийн нөхцөл байдал”, “Хүн худалдаалах гэмт хэрэг болон биеэ үнэлэх үйл ажиллагааны өнөөгийн байдал” сэдэвтэй цуврал хэлэлцүүлгийн холбогдох төрийн болон төрийн бус байгууллагыг оролцуулан зохион байгуулсан. Биеэ үнэлэгчдийн зорилтот бүлэгт хяналтын судалгааг зохион байгуулсан. ЦЕГ-ын ЭЦГ-аас авсан мэдээлэл болон Глобал сангаас явуулсан тандалтын судалгааны үр дүнд үндэслэн хууль бус үйл ажиллагааны нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртгийн тооцооллыг хийж байна.
- Аж үйлдвэр, барилга, тээвэр, хөдөө аж ахуй, гадаад худалдаа, хэрэглээний үнэ, хүнсний аюулгүй байдал, зам тээврийн осол, худалдаа үйлчилгээний салбаруудын танилцуулгыг 2017 оноор хийж, хэрэглэгчдэд тархаасан.

Статистикийн арга аргачлал, ангилал, түүврийн арга зүйг сайжруулан боловсруулснаар албан ёсны статистикийн тооллого, судалгаа, мэдээг олон улсын стандартад нийцсэн аргачлал, арга зүйгээр тооцож, үр дүнг хэрэглэгчдэд тархаах, Тогтвортой хөгжлийн зорилго /ТХЗ/-ын гарах боломжгүй зарим үзүүлэлтүүдийг тооцож, хэрэгжилтийг үнэлэх боломж бүрдсэн.

Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн хүрээнд ҮСХ-ны холбогдох газар, нэгж болон төрийн бусад байгууллагуудтай хамтран шалгуур үзүүлэлтийн тоон мэдээллийг гаргах боломжийг судалж, дахин үнэлгээ хийн, албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллээс 2018 оны 1-р сард гарах боломжтой байсан 73 шалгуур үзүүлэлт дээр 45 үзүүлэлтийг нэмж тооцон, 12-р сарын байдлаар нийт 118 үзүүлэлтийн мэдээллийг 2015-2017 оны гүйцэтгэлээр гаргаж, ТХЗ-ын цахим хуудсанд байршуулан, тухай бүр баяжилтыг хийж, хэрэглэгчдэд тархаасан.

ҮСХ-ноос нийгэм, эдийн засгийн олон жилийн динамик мэдээлэлд үндэслэн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, цаашид бодлогын түвшинд анхаарах асуудлыг тавьсан нийт 12 сэдвээр тусгайлсан шинжилгээ, судалгааны ажил боловсруулж, хэрэглэгчдэд тархаасан. **Тухайлбал:**

- “Эдийн засгийн өсөлт, ажилгүйдэл, ядуурлын хамаарал” судалгаа”
- “Хэрэглээний үнийн индексийн жингийн өөрчлөлтийн нөлөөлөл”
- “Монгол Улсын малын тоо толгой, бэлчээрийн даац хүрэлцээ"
- "Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн харьцуулсан судалгаа"
- “Хүний хөгжлийн индексийн олон улсын харьцуулсан судалгаа”
- “Инфляц ба төсвийн алдагдлын хамаарал судалгаа”
- “Ахмад настны нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа”
- “Гаднын шалтгаант нас баралт, түүнээс амиа хорлолтын өнөөгийн байдал”
- “Хүн амын өсөлт, өөрчлөлт, хандлага” насны бүтэц,” танилцуулга
- “Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд” танилцуулга.
- “Төрийн албан хаагчдын тоо, бүтэц, өөрчлөлт” танилцуулга.
- “Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлага” судалгаа

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn цахим хуудасны файлын сан болон газарзүйн мэдээллийн сан гэсэн цэсийг сар бүр болон тухай бүрд баяжуулах, боловсронгуй болгосноор статистикийн мэдээллийн хэрэглээ ашиглалт 2018 онд өмнөх оноос нэмэгдсэн байна. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn цахим хуудасны дизайн, бүтцийг боловсронгуй болгон, шинэчилж 1921-2018 оноор жил, улирал, сарын давтамжтай, улс, бүс, аймаг, сум, багийн түвшний 36 салбарын 774 гаруй статистик үзүүлэлтийг хамарсан байдлаар монгол, англи хэлээр баяжуулснаар сайтын хандалт 612.5 мянга гаруй болж өнгөрсөн оныхоос 81.2 хувиар өссөн.

ҮСХ-ны фейсбүүк хуудсанд 2018 онд цаг үеийн үйл явдлын мэдээ болон видео шторк, инфографик зэрэг 464 мэдээллийг байршуулснаар мэдээлэл авагчдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 22.6 хувиар нэмэгдэж, хэрэглэгчийн хандалт 33.5 мянга болов. Твиттер хуудсанд 400 мэдээлэл байршуулсан нь үзсэн дагагчийн тоо 23.3 мянга болж, өнгөрсөн оныхоос 10.9 хувиар нэмэгдсэн.

ҮСХ нь хэрэглэгчидтэй харилцах харилцаагаа үр дүнтэй болгон улам сайжруулж байна. Ялангуяа хэрэглэгч статистикийн бүтээгдэхүүнийг

хэрэглэхэд илүү хялбар болгох, статистикийн бүх бүтээгдэхүүнд зориулсан нэгдсэн загвар боловсруулан түүнийгээ ашиглахын зэрэгцээ хэрэглэгчдийн авч буй статистик мэдээллийг сайжруулах зорилгоор тэдэнд зориулсан семинар зохион байгуулсан зэрэг олон үйл ажиллагааг 2018 онд амжилттай хэрэгжүүлэв.

Статистикийн салбарын (ДНБ, төсөв, гадаад худалдаа, мөнгө, хүн ам, эрүүл мэнд, боловсрол, дундаж цалин, ажиллах хүч, гэмт хэрэг, тээвэр, холбоо, аж үйлдвэр, барилга, худалдаа үйлчилгээний салбар, өрхийн орлого зарлагын салбарын мэдээлэл) мэдээллээр сар, улирал, жилээр тусгайлсан (Монгол улсын нийт зээлийн дансны тоо, Монголын цагаан сар, Монгол улсын 100 ба түүнээс дээш настан, Цусны донорууд статистикийн нүдээр, 2 сарын 14 ба гэрлэлтийн статистик, 3 сарын 8 ба Монгол эмэгтэйчүүд, 3 сарын 18 ба Монгол эрэгтэйчүүд, 6 сарын 1 ба Монгол хүүхдүүд, 7 сарын 11 ба Монгол наадам, 10 сарын 1 буюу Ахмадын баяр, 11 сарын 26-ны Улс тунхагласны өдөр гэх мэт) сэдвээр тухай бүр инфографик бэлтгэн тархааж байна. Хэрэглэгчдэд хамгийн өндөр хүрсэн нь 2018 оны 3 сарын 8-ны өдөр тархаасан "Монгол эмэгтэйчүүд" инфографикийг нийт 121.0 мянга гаруй хүн сонирхож, 444 хэрэглэгч татан авсан байв.

Статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүний нэгдсэн стандартыг боловсруулан мөрдөж, хэрэглэгчдийн дунд явуулсан судалгаа, ирүүлсэн санал хүсэлтийн дагуу статистикийн сарын танилцуулга, өврийн дэвтэр, жилийн эмхэтгэл зэрэг хэвлэмэл бүтээгдэхүүний агуулга, чанар, тархаах хэлбэрийг 2018 онд өргөжүүлэн сайжруулав.

Статистикийн газар зүйн мэдээллийн санг баяжуулах, сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангаж, тооллого судалгааны үр дүнг газар зүйн мэдээллийн санд оруулж, бусад сантай байршлаар холбон, газрын зургаар үр дүнг тархааж байгаа нь мэдээллийн бодит байдлыг сайжруулах хөшүүрэг болохоос гадна хэрэглэгчдийн хүрээг тэлж, тоог өсгөж байна. **Энэ ажлын хүрээнд:**

- Хөдөө аж ахуйн завсрын тооллогын үр дүнгээр мал аж ахуй, газар тариалангийн салбарын 661 газрын зургийг аймаг, сумын түвшинд боловсруулж, үр дүнг тархаасан.
- Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний 2018 оны болон сүүлийн 7 хоногийн үнийн мэдээг байршлаар, Шатахууны 2018 оны болон сүүлийн 7 хоногийн үнийн мэдээг байршлаар буюу орон зайн мэдээллийн тогтмол гаргадаг болсон.
- Цас зудтай байгаа сумдын мэдээллийг 2018 оны хаврын байдлаар нэг удаа боловсруулан тархаасан. 2018 оны сүүлээс эхлэн, малчдын байршил, малын тоог мал тооллогын үр дүнгээр, Монгол орны цасны зузааныг 10 хоног бүр тогтмол, зудын эрсдэлийн зураглалыг тухай бүр Цаг уур, орчны шинжилгээний газраас авч тархааж эхэлсэн.

"Монгол Улсын Статистикийн жилийн эмхэтгэл-2017" номыг 1990-2017 он хүртэл 28 жилийн үзүүлэлтээр бэлтгэж, бүлэг бүрийн үзүүлэлтийг тооцох аргачлал, нэр томьёоны тайлбар оруулж, тухайн салбарын онцлох үзүүлэлтийг инфографикаар харуулсан байдлаар 1500 ширхэг хэвлүүлж УИХ, холбогдох яам, агентлаг, орон нутгийн статистикийн газар нэгж, олон улсын байгууллагуудад хүргүүлсэн. Мөн эмхэтгэлд тухайн бүлгийн гол үзүүлэлтүүдийг аймаг тус бүрээр газрын зургаар харуулсан нь шинэлэг ажил болсон.

Өмнөх 2 жилээс эхлэн баримталж буй зарчмаар шинэ эмхэтгэл бэлтгэхийн өмнө буюу 2019 оны эхний сард "Монгол Улсын Статистикийн жилийн эмхэтгэл-2017" номыг цахим хэлбэрээр УСХ-ны статистикийн нэгдсэн мэдээллийн санд байршуулав. Энэ нь хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэхээс гадна тэдний мэдээллийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн тархаалтын шийдэл болсон.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн сарын танилцуулга, бюллетенийг англи, монгол хэлээр 2760 ширхэг, нугалбарыг 2800 ширхэг, улирал бүрийн дундаж цалингийн инфографикийг 1200 ширхэг, "Статистикийн өврийн дэвтэр-2017" эмхэтгэлийг 1200 ширхэг тус тус хэвлэн олон нийтэд хүргэсэн.

"Статистикийн өврийн дэвтэр"-ийг жилийн эмхэтгэл гарахаас өмнө, урьдчилсан гүйцэтгэлээр боловсруулсан статистикийн мэдээллээр англи, монгол хэлээр бэлтгэж, ялангуяа улсын түвшний мэдээллийн агуулгыг нэмж, бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшингээр задалж, үнэ төлбөргүй тархаасан нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангаж, тэдний тоо, хүрээг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.

Зарим статистикийн мэдээллээр УСХ-ны ажилтнууд хэвлэл, мэдээллийнхэнд тодруулга, ярилцлага өгөх, телевизийн шууд нэвтрүүлэгт (MNB TV, Eagle TV, V TV, MNC, Эх орон TV) ажилтнуудыг оролцох зэргээр мэдээлэл тархаалтын боломжит бүх хэлбэрийг ашиглаж байна. Монголын үндэсний телевизийн "Өглөө хөтөлбөр"-өөр УСХ-ны дарга болон ажилтнууд статистикийн үзүүлэлтийг тооцож буй аргачлал, арга зүй түүнд оруулсан өөрчлөлтийг тухай бүр хэрэглэгчдэд тайлбарлах таниулах 15 цуврал нэвтрүүлгийг бэлтгэн тархаасан.

Хэрэглэгчдэд "масс и-мэйл" илгээж байнга шинэ мэдээллээр хангаж ажлын хүрээнд https://mailchimp.com/ тусламжтайгаар хэрэглэгчийн бүртгэлд бүртгүүлсэн нийт 7000 орчим бүртгэлтэй и-мэйл хаяг руу сар бүрийн сарын мэдээний

танилцуулгыг, судалгааны үр дүнгийн тайланг тухай бүр хэрэглэгчдэд шуурхай илгээв.

Статистикийн тоо мэдээлэл авахаар байгууллагын information@nso.mn хаягаар 2018 онд ирүүлсэн 420 хүсэлтийн хариуг өгч, ажиллалаа.

УСХ-ны номын сангаар 2018 онд номын санд хандсан статистикийн мэдээлэл хэрэглэгч 1800 хүнд хүссэн мэдээллийг нь боловсруулан өгөх, ном товхимлоор үйлчилсэн байна.

Статистикийн мэдээллийн 1900-1212 лавлах утсанд хандсан 2500 хүнд статистик мэдээллийн үйлчилгээг үзүүлэв.

Онлайн чатыг шинэчилснээр 2018 онд 2500 гаруй хэрэглэгч мэдээлэл авсан бөгөөд масс и-мэйлд бүртгэлтэй 7000 гаруй хэрэглэгчдэд сар бүр статистикийн мэдээллийг тогтмол хүргүүлж байна. Статистикийн мэдээлэл хэрэглэгчдийн бүртгэлийн сан байгуулж, бүртгэлтэй хэрэглэгчдэд сар бүр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын талаарх танилцуулга зэргийг цахим хэлбэрээр хүргэлээ.

УСХ-ноос 2018 онд өөрийн тархааж буй бүх мэдээллийг задаргаа бүрээр нарийвчлан судалж өөрийн үнэлгээг зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд УСХ-ны статистикийн нэгдсэн мэдээллийн сангаас 736 хүснэгтээр тархааж буй олон жилийн динамикийг дахин 234 хүснэгтээр аймаг, нийслэлийн түвшинд дэлгэрүүлж тооцох боломжтой байна. УСХ-ноос захиргааны бүртгэл, мэдээллийг ашиглах боломжийг судалж, шинээр мэдээллийн эх үүсвэрийг бий болгох ажлыг хийж байна.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН САЛБАРЫН 2018 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

3.1 АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ, ТООЛЛОГО, СУДАЛГАА

Үндэсний статистикийн хороо 2018 онд Монгол Улсын Статистикийн тухай хууль, Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлт (макро эдийн засгийн статистикийн 9, хүн ам, нийгмийн статистикийн 16, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн статистикийн 13, шүүхийн статистикийн 5, хүрээлэн байгаа орчны статистикийн 5)-ийг тооцох мэдээллийг анхан шатны бүртгэл, захиргааны болон албан ёсны мэдээ, мөн тооллого, түүвэр судалгаагаар долоо хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтай цуглуулав.

Аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрууд ҮСХ-ноос баталсан мэдээний хамрах хүрээ, маягт, нөхөх зааврын дагуу хүн ам, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааны албан ёсны статистикийн 53 төрлийн мэдээг долоо хоног, сар, улирал, хагас жилийн давтамжаар өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас авч, графикт хугацаанд нь ҮСХ-нд ирүүлсэн байна.

Мөнгө, зээл, санхүү, гааль, даатгал, татвар, байгаль орчин, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан техник, технологи, хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүнсний аюулгүй байдал, шүүхийн статистикийн мэдээллийг холбогдох яам, төрийн захиргааны нийт 27 байгууллага ҮСХ-ноос баталсан болон зөвшөөрсөн 206 маягтаар цуглуулан авч нэгтгэн ҮСХ-нд сар, улирал, жилийн давтамжтай мэдээлсэн байна.

ҮСХ-ноос 2018 онд зохион байгуулсан статистикийн улсын хэмжээний нэг тооллого, 6 түүвэр судалгаанд өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг бүрэн хамруулж, мэдээллийг хугацаанд нь цуглуулж боловсруулав. **Тухайлбал:**

Мал, тэжээвэр амьтдын тооллого

Мал, тэжээвэр амьтдын болон хашаа худгийн 2018 оны жилийн эцсийн тооллогыг улс даяар 12 дугаар сард зохион байгуулж, урьдчилсан дүнг баг, сум, аймгийн түвшинд хүлээн авч, нэгтгэв. Улсын дүнгээр нийт малын тоо 66.5 сая хүрч, өнгөрсөн оныхоос 0.4 хувиар өссөнөөс адуу 3.9 сая, үхэр 4.4 сая, тэмээ 459.7 мянган, хонь 30.6 сая, ямаа 27.1 сая тоологдсоныг баг, сум, аймгийн түвшинд нэгтгэн олон нийтэд тархаасан.

Түүвэр судалгаа

- Малын хагас жилийн түүвэр судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг батлагдсан түүврийн загварын дагуу 2018 оны 6 сарын 4-11-ний өдрүүдэд 21 аймаг, Улаанбаатар хотод зохион байгуулж, үр дүнг хүлээн авч шалган, боловсруулж, нэгтгэсэн. Түүвэр судалгааны үр дүнгээр бэлтгэсэн танилцуулгыг Монгол улсын нийгэм эдийн засгийн байдлын 7 дугаар сарын танилцуулгаар олон нийтэд хүргэлээ.Энэ түүвэр судалгааны мэдээлэл нь даатгалын нөхөн төлбөр олгох суурь мэдээлэл болдог тул холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэдээллийг даатгалын компанид хүргүүлдэг.
- Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллийг сар бүр цуглуулж, үр дүнг улирлаар гаргадаг. Сар бүр 21 аймаг, 9 дүүргийн нийт 1374 өрх, улиралд 4122 өрх, жилдээ 16488 өрхөөс аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын 75 судлаач мэдээлэл цуглуулав. ӨНЭЗС-ны боловсруулалтыг хийж, 2017 оны 4 дүгээр улирал болон 2018 оны 1-3-р улирлын үр дүнгээс нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага, нэг хүнд сард ногдох бодит орлого, хэрэглээний тэнцүү 5 бүлэг, жини коэффициент, тейлийн индекс зэрэг үзүүлэлтүүдийг байршлаар тооцож, улирал бүр 22 хүснэгт, 12 хуудас танилцуулга бүхий бюллетень, танилцуулгыг бэлтгэн тархаав.
- Хүн амын амьжиргаа, ядуурлын түвшинг өөрийн орны онцлогт тохирсон олон хэмжээст үзүүлэлтээр тооцох арга зүйг судалж, туршилт тооцооллыг хийсэн. Уг ажлын хүрээнд сумын түвшинд өрхийн амьжиргааг тогтоох, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийг тооцох аргачлалыг бий болгох зорилгоор явуулсан туршилтын судалгааны асуулгад олон хэмжээст үзүүлэлтүүдийг тооцох боломжтой асуултуудыг оруулсан. Цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн 3 сумын түвшинд олон хэмжээст ядуурлын индексийг тооцож, туршсан. ҮСХ-ноос "Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа"-г цаашид боловсронгуй болгох чиглэлээр Дэлхийн банкнаас техникийн туслалцаа хүссэн төсөл боловсруулан Дэлхийн банканд хүргүүлсэн.
- Ажиллах хүчний судалгааны мэдээллийг сар бүр цуглуулж, үр дүнг улирлаар гаргав. Сар бүр 21 аймаг, 9 дүүргийн нийт 1068 өрх, улиралд 3204 өрх, жилдээ 12816 өрхөөс аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын 75

судлаач мэдээлэл цуглуулдаг
Энэ судалгаагаар хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн талаарх мэдээллийг улсын хэмжээнд болон бус нутаг, аймаг, нийслэлийн түвшинд гаргадаг. Ажиллах хүчний судалгааны 2017 оны 4 дүгээр улирал болон 2018 оны 1-3-р улирлын мэдээг гаргаж, улирал бүр 10 хүснэгт, 1 хуудас бюллетень, танилцуулгын материал бэлтгэн тархаав. Мөн улирал бүр тусгайлсан танилцуулга бэлтгэж, холбогдох байгууллагуудад тухай бүр хүргэж байв.

- Барилгын өртгийн индекс тооцох судалгааг барилга, байгууламжийн өртгийн индекс тооцох, ДНБ-ийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэх тооцоонд ашиглах, барилгын салбарын өртгийн болон үнийн өсөлтийг харьцуулах зорилгоор явуулав. Улирал бүр 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт барилга угсралтын ажил гүйцэтгэж буй ААНБ-аас мэдээллийг цуглуулав.
- Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын улирлын судалгааг ДНБ-ий улирлын тооцоог хийх зорилгоор улирал бүр ААНБ-аас хөрөнгө, хөрөнгө оруулалтын мэдээллийг цуглуулав.
- Цаг ашиглалтын түүвэр судалгааг 2019 онд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, судалгааны үзэл баримтлал, түүврийн загварыг боловсруулж баталсан.
  ЦАС-ны зорилго нь хүн амын эрхэлж байгаа үйл ажиллагааг тодорхойлж, тэдгээрт зарцуулж буй цагийг хэмжих бөгөөд хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийг хүйсээр гаргаж, хүн амын амьдралын хэв маягийг тодорхойлох, түүнд гарч байгаа өөрчлөлтийг судалдаг. Судалгааны гол ач холбогдол нь хөлсгүй хөдөлмөрт өрхийн гишүүдийн зарцуулж байгаа цагийг тодорхойлж гаргах, хүн амын цаг зарцуулалтын ерөнхий дүр зургийг гаргах, өрхийн түвшинд бий болж байгаа нэмэгдэл өртгийг тооцох, ҮТС-д шаардлагатай тоо мэдээллийг гаргах түүнчлэн бодлого боловсруулахад хэрэгцээтэй тоо мэдээллээр хангахад оршино. Түүнчлэн судалгааг зохион байгуулж явуулснаар Монгол улсын хүн амын амьдралын хэв маяг, амьдралын чанарын талаарх мэдээллийг бий болгох, дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээний хангамж, хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалт хийх, бодлого хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээлэл, Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг хянах, хөлсгүй хөдөлмөрийн талаарх мэдээллийг үндэсний тооцооны данснуудтай зэрэгцүүлэн байгуулдаг туслах дансанд тооцож оруулах боломж бүрдэх төдийгүй жендэрийн статистикийн мэдээллийн санд баяжилт хийгдэнэ.
- Нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгаа нь 5 жил тутам Тогтвортой хөгжлийн зорилт, Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал, НҮБ-ын ерөнхий Ассамблейн ХДХВ/ДОХ-ын асуудлаар тусгай чуулганы тунхаглал болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр зэрэг үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийн тоо мэдээллийн санг бүрдүүлэх үндсэн зорилготой.
  Мэдээлэл цуглуулалтын бэлтгэл ажлыг ханган Улаанбаатар хотод 2018 оны 9 дүгээр сарын 21-нээс, орон нутагт 10 дугаар сарын 3-наас эхлэн улс орон даяр нийт 19 багийн 114 хүн 14500 өрхөөс мэдээлэл цуглуулсан. Судалгааны мэдээллийг таблетаар цуглуулж, ҮСХ-ны төв серверт ирүүлсэн мэдээлэл болон чанарын хүснэгтийг тухай бүр хүлээн авч шалган, 7 хоног тутамд НҮБХС-гийн олон улсын судалгааны төв багт хүргүүлж давхар шалгуулж байв.
  Судалгааны анхан шатны мэдээлэл, судалгаанд ашигласан асуулга, багийн ахлагч, ярилцлага авагчийн хяналтын хуудас, зардлын тооцоо, өндөр, жин хэмжигч, усны чанарын туршилтын материалыг 19 багаас хүлээн авч шалган 225 үр дүнгийн хүснэгтийн программыг боловсруулсан.

ҮСХ-ны даргын 2017 оны А\203 тоот тушаалаар баталсан “ҮСХ-нд нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсээс 2018 онд цахим шуудангаар ирүүлэх мэдээ, тайлангийн график” болон “ҮСХ-нд яам, газруудаас 2018 онд ирүүлэх мэдээ тайлангийн график”-ын дагуу дээр дурдсан албан ёсны статистикийн мэдээллээс гадна 2018 онд дараах мэдээ, түүвэр судалгааны мэдээллийг цуглуулж, үр дүнг боловсруулсан. **Үүнд:**

- “Ардчилсан засаглал” судалгааны асуулга, зааврыг 2018 онд шинэчлэн боловсруулж, батлуулсан. Уг судалгааны мэдээлэл цуглуулалтад ажиллах Улаанбаатар хотын судлаач нарт танхимын сургалт, орон нутгийн судлаач нарт online сургалт зохион байгуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны 4-р улирлын судалгаанд хавсарган зохион явуулсан. “Ардчилсан засаглал” судалгааны мэдээллээр 2009-2017 оны динамик үүсгэн, танилцуулга бичиж тархаасан.
- Дэлхийн 190 гаруй улс орныг хамарсан

"Олон улсын өртгийн зэрэгцүүлэлт 2017" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд машин, тоног төхөөрөмжийн үнийн судалгаа, барилгын материалын бүтээгдэхүүний үнийн судалгааг 2017-2018 оны байдлаар, өрхийн хэрэглээ бараа, үйлчилгээний үнийн судалгааг 2018 оны 1-4 дүгээр сарыг хамруулан зохион байгуулж, үр дүнг гарган АХБ-д тухай бүр хугацаанд нь хүргүүлсэн.

- Орон сууцны тоо, хэмжээ болон чанарын мэдээлэл цуглуулах асуулга, орон сууцны мета мэдээлэл, мэдээллийн боломжит байдал зэргийг АХБ-наас ирүүлсэн асуулга, маягтын дагуу 2015 оны хүн ам, орон сууцны завсрын тооллогын мэдээлэл болон орон сууцны түрээсийн мета мэдээлэл, үндэсний тооцооны орон сууцны түрээстэй холбоотой асуулгыг бэлтгэн үр дүнг АХБ-нд хүргүүлэв.
- Орон сууцны түрээсийн үнийн каталог, судалгааны маягт зааврыг боловсруулж, мэдээлэл цуглуулалтыг бүх аймагт нэг удаа зохион байгуулан явуулж, орон сууцны түрээсийн үнийн мэдээллийг боловсруулсан.
- Хангамж, хэрэглээний данс /Хүнсний балансыг туршилтаар байгуулахад шаардлагатай 2015-2017 оноор мэдээллийг цуглуулав.
- Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 308 дугаар тушаалын дагуу Налайх дүүрэгт далд аргаар болон хууль бусаар нүүрс олборлосны улмаас иргэдийн эрүүл, аюулгүй ажиллах амьдрах үндсэн эрх зөрчигдөж байгаатай холбогдуулан дүүргийн иргэдийн дунд Зөвлөлдөх санал асуулгыг хоёр үе шаттайгаар зохион байгуулж үр дүн, тайланг 48 цагийн дотор боловсруулж Зөвлөлдөх зөвлөлд хүргүүлсэн.
- Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хүн амын сан, Оюу толгой ХХК хамтран үндэслэлтэй бодит статистикийн мэдээлэлд тулгуурлан үнэлэлт, дүгнэлт өгөх нотолгоонд суурилсан бодлогын зөвлөмж гаргах зорилгоор "Өмнөговь аймагт нийгэм, эдийн засаг, байгаль орчны судалгаа" хийх төслийг 4-р сараас нэг жилийн хугацаанд хэрэгжүүлж байна. Төслийн үр дүнд Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны загвар суурь судалгаа гаргаж, цаашид бусад аймагт жишиг болгон хэрэгжүүлэх юм.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх анхдагч мэдээллийн сан байгуулах, үзлэг тооллогыг зохион байгуулахаар төлөвлөж, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар үзлэг тооллогыг зохион байгуулах ажлын хэсэг, ажлын удирдамжийг баталж 11 байгууллагын 22 гишүүн ажиллаж байна.
- Туршилт үзлэг, тооллогыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Эрүүл мэндийн яамтай хамтран Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сум, Сэлэнгэ аймгийн Орхон сумдад зохион байгуулсан.
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик, нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор малын бүртгэлийн мэдээллийн санг сайжруулах, шинээр маягт, заавар боловсруулах, малчин өрхийн мэдээллийн сангийн мэдээг тулган нягтлах, цаашлаад төрийн мэдээлэл солилцооны "Хур" системд холбох зэрэг ажлыг ХХААХҮЯ-тай хамтран хийж байна.
- Жендэрийн статистикийг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулж хуулиар үүрэг хүлээгчдэд хүргүүлэх, жендэрийн статистикийг нэгтгэн боловсруулах программ хангамжийг нэвтрүүлэх, мэдээллийн санг бүрдүүлэхээр Жендэрийн үндэсний хороотой хамтран ажиллаж байна.
- Хуульчдын талаарх албан ёсны мэдээлэлтэй болох, цаашид НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын холбогдох үзүүлэлтүүдийг дүгнэхэд шаардлагатай хуульчдын нас, хүйс, боловсролын зэрэг, ажилласан жилийн туршлага, шинээр олгогдсон эрх, эрх хасагдсан, мэргэжлийн хариуцлагын хороонд ирүүлсэн гомдлын шийдвэрлэлт зэрэг болон хуульчдын талаарх албан ёсны мэдээлэлтэй болох зорилгоор Монголын Хуульчдын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд аргачлал, маягт, заавар, мета мэдээллийн санг боловсронгуй болгох, статистик мэдээллийг албан ёсоор 2019 оноос олон нийтэд хүргэхээр хамтран ажилласан.
- БСШУСЯ, Биеийн тамир, спортын газартай хамтран 2017 онд анх удаа зохион байгуулсан "Биеийн тамир, спортын улсын үзлэг, тооллого"-оор цуглуулсан мэдээллийг спортын цол, зэрэгтэй тамирчин, дасгалжуулагч, шүүгч, спорт заал, гадна талбай зэрэг олон үзүүлэлтээр боловсруулан гаргав.
- Ногоон хөгжлийн 33 үзүүлэлтийг 2013 он болон 2017 оны байдлаар тооцож, динамикийг шинэчилж, статистикийн мэдээллийн санг баяжуулав.
- Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого явуулах бэлтгэл ажлын хүрээнд тооллогын

улсын комиссын анхдугаар хуралдааныг зохион байгуулж, аймаг, нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүн, улсын комиссын үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийн тооцоо, мастер төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг 2020 оны 1 дүгээр сарын 8-наас 9-нд шилжих шөнийн 00:00 цагаас эхлэн 7 хоногийн турш явуулах товыг тогтлоо.

Тооллогод ашиглах ангилал кодуудыг шинэчлэн боловсруулж холбогдох яам, агентлагуудаас саналыг авч нэгтгэсэн. Тооллогын хүн амын үзүүлэлтүүдийг Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж-3, Хүн ам орон сууцны улсын тооллогын тухай хууль, Тогтвортой хөгжлийн зорилтууд, Мастер төлөвлөгөөтэй уялдуулан туршилтын тооллогын үзэл баримтлал, асуулга, тоологч, шалгагчийн гарын авлага, маягт нөхөх зааврыг боловсруулж батлуулсан.

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын үйл ажиллагаа, арга зүйг турших тооллогын нэгжийн зураглал, тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарилалт, байршлыг тодорхойлж боловсруулсан. Бүртгэлд суурилсан аргаар явуулах тооллогын нэгжийн хүрээг тодорхойлж, холбогдох 4 байгууллагын мэдээллийн эх үүсвэр, үзүүлэлтийн бэлэн байдлыг тодорхойлж, туршилтаар Чингэлтэй дүүргийн 182 орон сууцны мэдээллийг тулгав.

"Байшин, орон сууцны нэгдсэн тооллого-2019"-н бэлтгэл ажлын хүрээнд Хаягийн бүртгэлд суурилсан Байшин, орон сууцны тооллогын туршилтын судалгааны мэдээлэл цуглуулах арга, хэрэгслийг Collector for Arc-GIS программ болон веб аппликэшн ашиглан хэрэгжүүлэх шийдлийг тодорхойлж, МонМэп ХХК -тай хамтран ажилласан.

Туршилтын тооллогод ашиглагдах Collector for ArcGIS программыг Архангай аймгийн Эрдэнэбулган, Тамир сумд, Чингэлтэй дүүргийн 6,9,19-р хороодод туршсан.

Туршилтын тооллого явуулах урьдчилсан бүртгэлийг боловсруулж, сургалтыг сонгогдсон нэгжүүдэд хийсэн. Туршилтын тооллогыг Дорнод аймгийн Хэрлэн, Сэргэлэн сумдын 3 баг, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Баянзүрх дүүргийн 5-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 6-р хороо амжилттай зохион байгуулж, үр дүнг УСХ-ны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэв.

УСХ-нд хүн ам, өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих мэдээллийн урсгалын дагуу төвлөрүүлэн авсан мэдээллийг бусад мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгаж, боловсруулан статистикийн 1212.mn мэдээллийн санг мэдээллийн давтамж бүрээр жилийн турш тогтмол шинэчлэн баяжуулж байна.

Албан ёсны статистикийн мэдээллээр сар бүр “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн танилцуулга”, жил бүр “Статистикийн өврийн дэвтэр” болон “Монгол улсын статистикийн эмхэтгэл”-ийг англи, монгол хэлээр тус тус хэвлэн олон нийтэд хүргэж байна.

УСХ нь албан ёсны статистикийн мэдээ, тооллого, бүртгэл, судалгааны мэдээллийн үр дүнгээр статистикийн “Хүн ам, өрхийн мэдээллийн сан” болон “Бизнес регистрийн мэдээллийн сан”-г байгуулан ажилладаг. Эдгээр мэдээллийн сан нь хүн ам, өрх, нийгэм, эдийн засгийн статистикийн мэдээлэл цуглуулах түүврийн үндсэн хүрээ болж ашиглагддаг.

“Хүн ам, өрхийн мэдээллийн сан” болон “Бизнес регистрийн мэдээллийн сан” нь статистикийн уялдаа холбоо, чанарт шууд нөлөөлдөг тул бид олон улсын зөвлөмжид нийцүүлэн тоо мэдээллийн олон төрлийн эх үүсвэрээс тогтмол шинэчилдэг. УСХ-ноос 2018 онд мэдээллийн технологийг нэгдсэн системийг түлхүү ашиглаж эдгээр сангийн чанарыг эрс сайжруулж, шинэчилсэн.

3.2 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулах болон хэрэгжилтийн явцыг дүгнэхэд шаардлагатай эдийн засаг, нийгмийн болон хүрээлэн буй орчны талаарх мэдээллийн эх үүсвэрийг бий болгоход УСХ санаачилгатай ажиллаж, бодит үр дүнд хүрсэн.

Тогтвортой хөгжлийн зорилтын талаар мэдлэг, мэдээлэл өгөх, сурталчлан таниулах, явцыг хянах, үнэлэх зорилго бүхий хяналтын систем / dashboard/-ийг байгуулав. Хяналтын системийг ажиллуулснаар Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг нэгдсэн байдлаар тооцон тайлагнахад яам, төрийн байгууллагуудын үүрэг, оролцоо тодорхой болсон.

Монгол Улсад ADAPT буюу мэдээллийн төлөвлөлтийн дэвшилтэт арга хэрэгслийг боловсруулах платформыг хэрэгжүүлэх ажлыг “21-р зууны статистикийн хөгжлийн төлөөх түншлэл” (PARIS21) байгууллага болон Үндэсний хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан.

Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд мэдээллийн олон эх үүсвэрийг ашиглах нь” төслийг 2018 оны 7 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна. Холбогдох яамд, байгууллагын төлөөллийг оролцуулсан төслийн удирдах хороо, ажлын 5 хэсгийг байгуулсан. Төслийн хүрээнд Тогтвортой

хөгжлийн зорилтуудын 28 үзүүлэлтийн аргачлал, тэдгээрийг тооцох зөвлөмж боловсруулж, уламжлалт бус мэдээллийн эх үүсвэрийг ашиглах боломжийг судлан хэрэгжүүлж байна.

"Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030-ыг хэрэгжүүлэхэд хөгжиж буй орнуудын орон зайн мэдээллийн менежментийн чадавхыг бэхжүүлэх" төслийг Африк, Ази номхон далайн бүс нутгийн хөгжиж буй 6 улсыг сонгон 2021 он хүртэл 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр болсон. Эдгээр 6 улсын нэгээр манай улс сонгогдож, үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, орон зайн мэдээллийн хэрэглээг өргөжүүлэх юм.

Энэ төслийн хүрээнд орон зайн өгөгдлийн дэд бүтцийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг нийтэд таниулах, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх, арга замыг эрэлхийлэх, төрөөс орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар баримтлах бодлогын алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлох, тэргүүлэх чиглэлийг эрэмбэлэх, орон зайн мэдээллийн үндэсний хөгжлийн стратегийг дэлхийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах зэрэг асуудлаар "Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад орон зайн өгөгдлийн дэд бүтцийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол" сэдэвт олон улсын зөвлөгөөнийг 2 өдөр зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд НҮБ-ын Дэлхийн орон зайн мэдээллийн менежментийн зөвлөхүүдийн хороо, Ази номхон далайн бүсийн зөвлөхүүдийн хороо, Их Британи болон Умард Ирландын Нэгдсэн Вант Улс зэрэг өндөр хөгжилтэй орны их дээд сургуулиудын орон зайн мэдээлэл, судалгааны байгууллагууд болон төрийн байгууллагуудын төлөөлөл оролцож, орон зайн мэдээллийг боловсруулах ашиглах чиглэлийн ажилд дэвшил гарлаа.

ТХЗ-ын хэрэгжилтийн хүрээнд төрийн бусад байгууллагуудтай хамтран шалгуур үзүүлэлтийн тоон мэдээллийг гаргах боломжийг судалж, 2018 онд 4 дэх үнэлгээг хийсэн. Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллээс 2018 оны 1-р сард гарах боломжтой байсан 73 шалгуур үзүүлэлт дээр 45 үзүүлэлтийг шинээр нэмж тооцсон.

2018 оны 12-р сарын байдлаар нийт 118 үзүүлэлтийн мэдээллийг 2015-2017 оны гүйцэтгэлээр гаргаж, ТХЗ-ын веб хуудсанд байршуулан, тухай бүрд баяжилтыг хийж, хэрэглэгчдэд тархааж байна.

3.3 АНХАН ШАТНЫ МЭДЭЭНИЙ ЧАНАР, ШУУРХАЙ БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ

ҮСХ-ноос статистикийн үйл ажиллагааны бүх үе шатанд (түүвэр судалгааны төлөвлөлт болон судалгааны зохиомж\дизайн, мэдээлэл цуглуулалт, боловсруулалт, дүн шинжилгээ, тархаалт) дараах чиглэлээр чанарын хяналтыг тухай бүрд нь тогтмол ашиглаж байна. Тухайлбал статистикийн мэдээлэл нь:

- Хэрэглэгчдийн хэрэгцээг хангаж байгаа байдал.
- Мэдээ болон статистикийн тооцоолол нь зөв, бодит байдалд нийцсэн эсэх, мэдээллийн бусад эх үүсвэрүүдтэй уялдсан байдал,
- Мэдээллийг тодорхой, ойлгомжтой график болон зургаар харуулах зэргээр мэдээлэл танилцуулах аргыг ашиглаж боловсруулсан эсэх.
- Мэдээлэл нь цаг хугацаагаар, бүс нутгаар болон улс орнуудаар, мөн ижил үзүүлэлтээр харьцуулах боломжтой, уялдаатай байгаа эсэх, статистикийн өөр өөр салбарт хэрэглэх боломжтой байх.
- Мэдээлэл нь дагалдах хангалттай болон оновчтой мета мэдээлэлтэй байгаа эсэх, мэдээллийн чанарын талаарх мэдээлэл байгаа эсэх;
- Мэдээллийг шуурхай боловсруулж, цаг хугацаанд нь нийтэд тархаасан байдал
- Хэрэглэгчид мэдээллийг хүртээмжтэй, хялбар аргаар авч буй биет нөхцөл байдал

ҮСХ-ноос 2018 онд албан ёсны болон захиргааны мэдээллийг бодит байдалд нийцүүлэх зорилгоор анхан шатны мэдээллийг биечлэн үзэж шалгах болон мэдээллийн технологийг ашиглан мэдээллийг тулган шалгах гэсэн үндсэн 2 хэлбэрийн чанарын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулав.

Тайлант онд 114 статистикийн улсын байцаагч ажиллаж байгаа бөгөөд ҮСХ, яам, төрийн захиргааны бусад байгууллага, нийслэл хотод 17, дүүрэгт 15, 21 аймагт 82 улсын байцаагч тус тус ажиллаж байна.

Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн хяналтыг сайжруулахад статистикийн салбарт ажиллаж буй ажилтнуудын чанарын удирдлагын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлж ажилласан. Ялангуяа анхдагч мэдээллийг гаргах үе шатанд ажиллагчдын ажлын уялдааг хангах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор мэдээллийн чанарт тавих дотоодын хяналтыг хамтран хийв.

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яамтай хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, удирдамжийг 2017 онд баталсан билээ. Энэ ажлыг өнгөрсөн онд үргэлжлүүлж Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Хэнтий аймгийн 53 сум, 307 баг, 284 байгууллага, Нийслэлийн

Статистикийн газар, Налайх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн байгууллага, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн боловсролын байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

- Хэрэглээний үнэ, үйлдвэрлэгчийн үнэ, орон сууцны үнэ, бизнес регистр болон эдийн засгийн салбарын мэдээлэл цуглуулалт, боловсруулалт, динамик бүрдүүлэлтийг Дундговь, Өмнөговь, Төв, Баян-Өлгий, Увс, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Архангай, Булган аймаг болон Улаанбаатар хотын 6 дүүргийн статистикийн хэлтэст хянаж шалгасан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, нийтлэг гарч байгаа алдаа, тулгарч буй асуудлыг тодорхойлж, холбогдох ажилтан бүрд зөвлөмж, зааврыг болон хугацаатай үүрэг даалгаврыг албан бичгээр өгч, биелэлтэд хяналт тавьж байна.
- Эдийн засаг, үнийн статистик, бизнес регистрийн мэдээ, тайланг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, тархаах явцад өөрийн үнэлгээний судалгааг хариуцсан ажилтнууд болон багийн түвшинд хийж, үр дүнг гарган цаашид анхаарах асуудлуудыг тодорхойлсон. Тухайлбал эдийн засаг, үнэ, бизнес регистрийн сар, улирлын мэдээ, тайланд гарсан алдаа, түүнд хийсэн залруулга, хийгдсэн засвар, өөрчлөлт зэргийг багтаасан эдийн засаг, үнэ, бизнес регистрийн үйлдвэрлэгчийн тайлан, сар, улирал, жилийн мэдээний баримтжуулалтыг хийсэн.
  Эдийн засаг, үнэ, бизнес регистрийн сангийн мэдээ, тайлан, тооллогын чанарт хийсэн хяналт, мониторингийн ажлын үр дүнг тусгайлан хэлэлцэж, цаашид хийх үйл ажиллагааг тодорхойлж, 2019 оны төлөвлөгөөнд тусган ажиллахаар болсон.
- Малын хагас жилийн түүвэр судалгааны хяналт мониторингийн ажлыг Завхан, Сүхбаатар, Баянхонгор, Өвөрхангай, Төв аймагт зохион байгуулсан.
- Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын хяналтын ажлыг ХХААХҮЯ-тай хамтран 12 аймаг, нийслэлд зохион байгуулсан.
- УСХ-ноос баталсан “Хэрэглэгчийн болон үйлдвэрлэгчийн чанарын тайланг боловсруулах журам”-ын дагуу Эдийн засгийн статистикийн салбарууд, үнийн статистик, Бизнес регистрийн сангийн мэдээ, тайлангийн “Хэрэглэгчид зориулсан чанарын тайлан”-г боловсруулж, бэлтгэн гаргасан.
- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн чанарын тайланг дотоод хэрэгцээнд зориулан дэлгэрэнгүй байдлаар боловсруулсан.
- БОАЖЯ, ЗТХЯ, ХНХЯ, ЭМЯ, БСШУСЯ зэрэг яам, төрийн захиргааны байгууллагуудын статистикийн асуудалхариуцсан ажилтнуудтай тухайн салбарын статистикийн мэдээллийн чанарыг хэрхэн сайжруулах, мэдээллийн урсгалыг оновчтой болгох, мэдээллийн сан байгуулах, бусад мэдээллийн эх үүсвэрүүдтэй уялдуулах талаар уулзалт ярилцлага зохион байгуулав. Мөн статистикийн мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх талаар санал солилцож, заавар, зөвлөмж өгч, мэдээний график гарган батлуулж, үндсэн нэгжид хүргүүлэх, статистикийн мэдээллийг хариуцсан ажилтантай болох ажлыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэн ажилласан.
- ХЗДХЯ-ны харьяа байгууллагуудтай хамтран ажиллах ажлын удирдамжийн хүрээнд Хил хамгаалах ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт ажиллаж, анхан шатны мэдээллийн чанар, статистик мэдээлэл гаргахад тулгамдаж буй асуудалтай танилцах, мэргэжил арга, зүйн зөвлөгөө өгч ажиллав.
  УСХ-ноос 2018 онд мэдээллийн технологийг ашиглан төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн сангийн уялдаа холбоо сайжруулж, мэдээллийн зөрүүг арилгах ажлыг зохион байгуулсан. Энэ ажлын үр дүнд статистикийн зарим мэдээллийг мэдээлэл цуглуулах шат дамжлага цөөрч, мэдээллийн давхардалгүй болж, мэдээлэл боловсруулах хугацаа багасаж, мэдээллийн ашиглалт нэмэгдэж, мэдээллийн бодит байдал эрс сайжирч байна. **Тухайлбал:**
- Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас “Хуулийн этгээдийн тухай мэдээлэл, шинээр байгуулагдсан, татан буугдсан, өөрчлөгдөн зохион байгуулагдсан 4 төрлийн мэдээллийг хугацааны интервалаар авч ашиглах боломжийг бүрдүүлсэн.
- Хил хамгаалах ерөнхий газраас Монгол Улсын иргэдийн хил нэвтрэлтийн тухай мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн сервисийг Хил хамгаалах ерөнхий газар, Үндэсний дата төвтэй хамтран хийж, Гадаадад суугаа Монгол Улсын иргэдийн бүртгэлийн системд ашиглаж байна.
- Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн сарын мэдээг онлайн системээс файл серверээр дамжуулан авч байна.
- Эрүүл мэндийн даатгалын газартай хамтран өрхийн эмнэлгүүдэд тулгуурласан шинэ цахим системийг хөгжүүлж, хөнгөлөлттэй эм олгох мэдээллийн санг Хүн ам, өрхийн мэдээллийн сантай уялдуулан ашиглалтыг сайжруулсан.

- Эрүүл мэндийн яамнаас төрөлт, нас баралтын мэдээллийг хугацааны интервалын дагуу ашиглах боломжийг бүрдүүлж нууцлал, аюулгүй байдлыг ханган ашиглуулж байна.
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран мэдээллийн сантай холбогдсон нь орон зайн мэдээллийн сангийн чанарыг сайжруулахад төдийгүй мэдээллийн бусад сангийн бодит байдлыг эрс сайжруулж байна.
- УСХ, Эрүүл мэндийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар хамтран шинээр төрсөн хүүхдийг 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийслэлийн бүх шатлалын эмнэлэгт, 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс аймгийн төрөх эмнэлэгт цахимаар бүртгэж эхэлсэн. Ингэснээрээ Эрүүл мэндийн яамны бүртгэл болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын төрөлт, нас баралтын бүртгэлийн дунд нэг ч иргэн орхигдохгүй байх боломжийг бүрдүүлж байна. Ингэснээр хүн ам зүйн үндсэн үзүүлэлтээр гаргаж буй эрүүл мэндийн статистикийн үзүүлэлтийг өрхийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлттэй холбох, хүн амын ердийн хөдөлгөөний талаарх тоо мэдээг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргаж, олон улсын жишигт нийцсэн статистикийг шинээр бий болгох, төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн уялдаа холбоог сайжруулах, мэдээлэл харилцан солилцох, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах нөхцөл бүрдсэн.

УСХ-ны “Хүн ам, өрхийн мэдээллийн сан” (ХАӨМС)-гийн чанарыг сайжруулах, бусад мэдээллийн сантай уялдуулж, мэдээллийн зөрүүг арилгах зорилгоор дараах ажлыг хийв. Тухайлбал:

- ХАӨМС-ийн аймаг, нийслэлийн засаг захиргааны нэгжийн санд гарсан хүндрэлийг цаг тухай бүрд шийдвэрлэж, засварууд тусгаж мэдээллийн санг сайжруулж байна.
- Монгол Улсын 330 сумын Засаг даргад "Хүн ам, өрхийн мэдээллийн сан"-ын харах эрхийг үүсгэсэн.
- Нийгмийн даатгал, халамж үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн санг ХӨАМС-ийн мэдээллийн сантай тулгалт хийсэн.
- БСШУСЯ-ны мэдээллийн санг ХӨАМС-ийн мэдээллийн сантай тулгалт хийж сайжруулсан.
- Эрүүл мэндийн яамны төрөлт, нас баралтын мэдээллийг “Хүн ам, өрхийн мэдээллийн сан” (ХАӨМС)- тай тулган шалгасан.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын өрхийн мэдээллийн санг 2017 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын мэдээлэлтэй 3 удаагийн тулган шалгалт хийсэн.
- Байшин орон сууцны туршилтын тооллогын нэгжийн хаягийн мэдээллийг ГЗБГЗЗГ-аас хүлээн авч, шинэ хуучин хаягийн мэдээллийг давхцуулан, мэдээлэл цуглуулалтад ашиглан, туршилтын тооллогын үр дүнд үндэслэн хаягийн мэдээллийг ХАӨМС-ийн өрхтэй тулгах ажлыг гүйцэтгэсэн.

УСХ-ны “Бизнес регистрийн мэдээллийн сан”-гийн мэдээллийг дараах төрийн байгууллагуудын мэдээллийн сантай уялдуулж, мэдээллийн зөрүүг арилгасан. **Тухайлбал:**

- Сангийн яамны санхүүгийн тайлангийн 2014-2016 оны хөрөнгийн хуримтлалын мэдээлэл;
- Татварын ерөнхий газрын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын мэдээлэл;
- Эрүүл мэндийн яамны мэдээллийн санд бүртгэлтэй 1900 эрүүл мэндийн байгууллага;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны мэдээллийн санд бүртгэлтэй 2337 сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл;
- Төрийн өмчийн бодлогыг зохицуулах газрын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 104 хуулийн этгээдийн 2017 оны жилийн эцсийн мэдээлэл зэрэг багтаж байна.

УСХ-ноос англи, монгол хэлээр тархаадаг “Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал” сарын бюллетений мэдээлэл боловсруулах болон мэдээллийн хэвлэлийн эх бэлтгэлийн явцад дунджаар 16 бүлгийн 138 хүснэгт, 15 хуудас явцад байнгын хяналт тавьж ажилладаг. Сар бүр статистикийн мэдээлэл боловсруулсан ажилтнаас эхлээд мэдээллийг хянасан холбогдох нэгжийн ахлах мэргэжилтэн, хэлтэс, газрын дарга, УСХ-ны дэд дарга, УСХ-ны дарга гэсэн бүхий л шат дарааллын хяналтын хуудас, хянагдсан мэдээллийг жил бүрээр архив үүсгэн хадгалж байна.

Статистикийн нэгдсэн мэдээллийн сан www.1212.mn –д байршуулсан мэдээллийн баяжилтад тогтмол хяналт тавьж, уг санд байршуулсан сүүлийн 10 жилийн мэдээллийг хэрэглэгчдэд тархаасан статистикийн эмхэтгэл, сарын бюллетений мэдээлэл болон анхан шатны мэдээлэл, бусад эх үүсвэр, тооцоотой тулган шалгаж, илэрсэн алдаа, мэдээллийн зөрүүг арилгах ажлыг тухай бүрд нь шуурхай зохион байгуулж байна.

Open Data Watch олон улсын ТББ-ын статистикийн байгууллагын албан ёсны статистикийн ерөнхий 21 бүлгийн мэдээллийн нээлттэй байдалд хийсэн үнэлгээний аргачлалын дагуу УСХ-ны ажлын хэсэг

өөрийн тархааж буй бүх мэдээллийг задаргаа бүрээр нарийвчлан судалж, өөрийн үнэлгээг зохион байгуулсан. **Энэ ажлын хүрээнд:**

- УСХ-ны статистикийн нэгдсэн мэдээллийн сангаас 736 хүснэгтээр тархааж буй олон жилийн динамикийг цаашид 234 хүснэгтээр нэмж, аймаг, нийслэлийн түвшинд үзүүлэлтийг дэлгэрүүлж тооцох боломжийг тодорхойлсон. Энэ чиглэлээр УСХ-ноос захиргааны бүртгэл, мэдээллийг ашиглах боломжийг судалж, шинээр мэдээллийн эх үүсвэрийг бий болгох ажлыг хийж байна.
- Салбар бүрийн мэдээлэл хариуцсан мэргэжилтэнтэй 2-3 удаа хамтран мэдээллийг зохих ангиллын дагуу мэдээллийн нэгдсэн санд хугацаанд нь байршуулсан эсэхийг шалгав.
- Үзүүлэлтүүдийн мета мэдээллийн боловсруулалт болон УСХ-ны Мета мэдээллийн сангийн байдалд хяналт үнэлгээ хийсэн. УСХ-ны салбарын статистикийн мэдээлэл болон тооллого, түүвэр судалгаа хариуцсан ажилтан бүр холбогдох мета мэдээллийн дутуу үзүүлэлт, үзүүлэлтийн талбарыг англи, монгол хэл дээр нөхөж оруулах, мета мэдээллийн сан болон статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн уялдааг ханган ажиллаж байна.

Статистикийн тухай хууль, статистикийн чанарын удирдлагын зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээнд Үндэсний статистикийн хороонд нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтэс болон яам, газруудаас 2019 онд ирүүлэх албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тайлангийн жагсаалт, графикт хугацааг боловсруулан УСХ-ны даргын 2018 оны А\159 тоот тушаалаар батлав.

Олон улсын жишигт нийцүүлэн албан ёсны статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашиглах тохиолдолд залруулах, тайлбар хийх үйл ажиллагааг зохицуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй, нэгдсэн тайлбар бүхий хариу арга хэмжээг цаг алдалгүй, шуурхай авах зорилго бүхий “Статистикийн мэдээллийг урвуулан ашиглах, буруу, ташаа тайлбарлах тохиолдолд тайлбар хийж залруулах журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлан ажиллаж байна.

Статистикийн салбарын хэмжээнд цуглуулж, нэгтгэн боловсруулж, тархааж байгаа статистикийн мэдээ, тайлан, эцсийн бүтээгдэхүүнд гарч буй алдааг илрүүлэх, баримтжуулах, залруулах, алдааны төрөл, шалтгаанд дүн шинжилгээ хийх, статистикийн чанарын шалгууруудыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор “Статистикийн мэдээллийн алдааг илрүүлж, засвар, баримтжуулалт хийх журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлан мөрдөн ажиллаж байна.

3.4 АРГА АРГАЧЛАЛ, АНГИЛЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (GSBPM), удирдамж, гарын авлагыг нэвтрүүлэх хүрээнд хүн ам, нийгэм, эдийн засаг, үндэсний тооцооны 67 тооллого, судалгаа, мэдээлэл статистикийн үйл ажиллагааны загварыг боловсруулаа. Үүний үр дүнд статистикийн мэдээллийг бий болгох үйл ажиллагааны тогтолцоо, нөөцийг оновчтой тодорхойлж, уялдуулан зохион байгуулах асуудлаар илүү үр дүнтэй шийдвэр гаргах боломж улам бүр нэмэгдэж байна.

Олон улсын валютын сангийн сайжруулсан мэдээлэл тархаах ерөнхий стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Монгол банк, Сангийн яамтай хамтран Үндэсний нэгдсэн мэдээллийн цахим санг байгуулж нийгэм, эдийн засгийн 22 салбарын (бодит сектор, төсвийн сектор, санхүүгийн сектор) мэдээний баяжуулалтыг сар бүр шинэчлэн, салбаруудын мэдээллийг олон нийтэд тархааж байна.

Статистикийн шинжилгээ, судалгаанд өргөн ашиглагддаг STATA13, EView9 программ ашиглах гарын авлагыг боловсруулж, цахим хэлбэрээр 1212.mn цахим хуудсанд байршуулж, нийтэд тархаасан.

Олон улсад нийтлэг мөрдөгдөж буй нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистикийн арга зүйг судалж, үндэсний онцлогт тохируулсан арга зүйг боловсруулах ажлын хүрээнд нийт 39, үүнээс 18 аргачлал, арга зүй болон 21 багц маягт, нөхөх зааврыг шинээр болон шинэчлэн боловсруулан баталж, мөрдүүлсэн. (хавсралт 1) **Тухайлбал:**

- Ажил, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дутуу ашиглалтын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал,
- Материалын урсгалын дансыг байгуулах аргачлал,
- Эрчим хүчний биет урсгалын дансыг байгуулах аргачлал,
- Байгаль орчны татварын дансыг байгуулах аргачлал,
- Байгаль орчныг хамгаалах зардлын дансыг байгуулах аргачлал,
- Эдийн засаг, нийгмийн түүвэр судалгааны дизайн
- Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал
- Хаягт суурилсан Байшин, орон сууцны туршилтын тооллогын аргачлал
- Тарилгатай халдварт өвчний дархлал тогтоц, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийн судалгааны түүвэр хийх аргачлал,
- Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал,
- Залуучуудын статистикийн үзүүлэлтийн хүрээ

болон үзүүлэлт тооцох аргачлал,
- Нийслэлийн хөгжлийн индекс тооцох аргачлал
- Налайх дүүрэгт зохион байгуулж явуулах Зөвлөлдөх санал асуулгын судалгааны түүвэр хийх аргачлал гэх мэт.

Эдгээрээс 9 аргачлал, 19 багц маягт, нөхөх зааврыг шинээр боловсруулсан байна.

ҮСХ нь статистикийн мэдээлэгчдэд учрах ачааллыг багасгах, статистикийн дүн шинжилгээ, харилцаа холбоо, чанарын холбогдолтой үйл ажиллагаануудын хөрөнгө нөөцийг хэмнэх зорилгоор мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд эдийн засаг, бизнесийн статистикийн түүвэр судалгааны мэдээллийг түлхүү ашиглах, цаашид албан ёсны статистикийн үйл ажиллагаанд захиргааны тоо мэдээллийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр анхааран ажиллаж байна. Үүнтэй уялдан түүврийн оновчтой загварыг боловсруулах, статистикийн мэдээллийн маягт, нөхөх завар, мэдээлэл цуглуулах аргачлал, арга зүйг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах ажлыг эрчимжүүлж байна.

Олон улсын стандартад нийцүүлж статистикийн арга аргачлал, ангилал, түүврийн арга зүйг сайжруулан боловсруулснаар албан ёсны статистикийн тооллого, судалгаа, мэдээний хүрээ тэлж, хэрэглэгчдэд тархаах үзүүлэлтийн тоо өсөж, мэдээллийн шуурхай, хүртээмжтэй, үнэн зөв бодит байдал сайжирсан. Ялангуяа Тогтвортой хөгжлийн зорилгын гарах боломжгүй зарим үзүүлэлтүүдийг тооцож, хэрэгжилтийг үнэлэх боломж бүрдсэн.

3.5 ҮНДЭСНИЙ ТООЦООНЫ СИСТЕМ, ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА

Үндэсний статистикийн хороо 2018 онд үндэсний тооцооны системийг сайжруулах зорилгоор дараах тооцооллыг хийж гүйцэтгэв. Тухайлбал:

ДНБ-ийг тооцох ажлын хүрээнд:

- ДНБ-ий 2016 оны жинхэнэ гүйцэтгэл, 2017 оны урьдчилсан болон жинхэнэ гүйцэтгэлийн тооцоог улирлаар үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар тооцооллыг хийсэн.
- НАХ-ийн 2016 оны үр дүнд үндэслэн үндэсний тооцооны холбогдох үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцож, үндэсний тооцооны 2016 оны үр дүнг жинхэнэ гүйцэтгэлээр гаргасан.
- НАХ-ийн 2016 оны үр дүнд үндэслэн ДНБ, үндэсний тооцоо (УТ)-ны урсгал болон хөрөнгийн данснуудыг шинэчлэн байгуулсан.
- ДНБ-ий 2017 оны урьдчилсан гүйцэтгэлд үндэслэн ДНБ-ийг орлогын аргаар, бүс нутгаар, өмчийн хэлбэрээр тооцож, УТ-ны данснуудыг байгуулсан.
- ДНБ-ий 2017 оны бүтээгдэхүүний татварын урьдчилсан тооцоог салбар (ЭЗҮАСА- 2 оронгийн түвшинд), аймаг, өмчийн хэлбэрээр тооцсон.
- ХАА, аж үйлдвэр, барилга, тээвэр, зочид буудал, зоогийн газар, мал эмнэлэг, холбоо, аялал жуулчлал, худалдаа, мэргэжлийн түр сургалт, эрдэм шинжилгээ судалгааны ажил, чөлөөт цаг, соёл биеийн тамир, сүм хийд, орон сууц нийтийн аж ахуй, нийгэм бие хүнд үзүүлэх үйл ажиллагаа зэрэг 17 салбарын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгааны мэдээлэлд үндэслэн салбарын нэмэгдэл өртгийн тооцоог хийв.
- Татварын ерөнхий газраас татвар төлөлтийн 2017 оны мэдээллийг иргэн, ААНБ-аар авч, 57202 ААНБ-ийг статистикийн бизнес регистрийн мэдээлэлтэй холбож, боловсруулалт хийсэн.
- Жилийн эцсийн өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн байгууллагын хэрэглээний болон гадаад худалдааны мэдээллийн санд боловсруулалт, тооцоог хийж, 2017 оны матрицуудыг байгуулсан.
- Үйлдвэрлэлийн татвар, татаасны 2017 оны гүйцэтгэлийг тооцсон.
- Далд эдийн засгийн тооцооллын 2017 оны гүйцэтгэлийг 5 талбараар тооцож, ДНБ-ий гүйцэтгэлд оруулсан.

Жилийн Нөөц ашиглалтын хүснэгт (НАХ), Салбар хоорондын тэнцлийг (СХТ) байгуулах ажлын хүрээнд дараах тооцооллыг хийсэн. Үүнд:

- ААНБ-ын 2016 оны жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд суурилсан үйлдвэрлэл, орлогын аргын ДНБ-ий тооцоололд үндэслэн үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн матрицуудыг эдийн засгийн 5 секторoор, бүтээгдэхүүн, салбараар байгуулсан,
- Татварын мэдээлэлд үндэслэн бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн бусад татварын матрицыг татварын төрлөөр, бүтээгдэхүүн, салбараар байгуулсан,
- Эцсийн ашиглалтын аргын ДНБ-ий тооцоололд үндэслэн өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн байгууллагын хэрэглээ, ӨҮАББ-ын хэрэглээ, үндсэн хөрөнгийн нийт хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн матрицууд болон импорт, экспортын матрицуудыг бүтээгдэхүүн, салбараар байгуулсан.

- Нөөц болон ашиглалтын хүснэгтийн балансуулах ажлыг хийсэн.
- НАХ-д үндэслэн СХТ-ийг 2016 оны гүйцэтгэлээр импортын өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус төрлөөр байгуулсан.
- Нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг, татвар, хөрөнгийн хуримтлал, эцсийн хэрэглээ, импорт, экспортын матрицыг (2010 оны суурь НАХ-д үндэслэсэн) 2016 оны гүйцэтгэлээр байгуулсан.
- Хөрөнгийн хуримтлал, эцсийн хэрэглээ, импорт, экспортын матрицыг (2010 оны суурь НАХ-д үндэслэсэн) 2017 оны гүйцэтгэлээр байгуулсан.
- Жилийн НАХ, СХТ-ийг (2010 оны суурь НАХ-д үндэслэсэн) 2016 оны гүйцэтгэлээр нэгтгэн байгуулсан.
- СХТ-ийг 2016 оны гүйцэтгэлээр импортын өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус төрлөөр байгуулж, НАХ 2016 оны гүйцэтгэлд тодруулга хийж, эцэслэн балансуулсан.

Нөөц ашиглалтын хүснэгтийг 2000-2009 оноор байгуулах ажлын хүрээнд:

- ХАА-н салбарын 2005-2009 оны тооцоог 2010 оны ашиг шим, гарц, үнийн судалгааны үр дүнгээр шинэчлэн тооцсон.
- НАХ-ын 2010 оны үр дүнд үндэслэн далд эдийн 2005 оны матрицыг байгуулсан.
- Гадаад худалдааны баазын боловсруулалт хийж, 2005 оны экспорт, импортын матрицыг дэлгэрэнгүй, 2006-2009 экспорт, импортын матрицыг вектор хэлбэрээр байгуулсан.
- НАХ-ийг 2000-2009 онуудаар хураангуй байдлаар нэгтгэн байгуулсан.

Суурь 2015 оны Нөөц ашиглалтын хүснэгтийг байгуулах ажлын хүрээнд:

- Суурь НАХ-д зориулсан ААНБ-ын 2015 оны судалгааны тоо мэдээллийг дахин нягтлан хянаж, нэгтгэсэн.
- Хөдөө аж ахуйн 2015 оны ашиг шим, өртөг зардлыг судалгааны үр дүнд үндэслэн мал аж ахуй, газар тариалангийн салбарын нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртгийн тооцооллыг аймаг, нийслэлээр шинэчлэн тооцсон.
- Импорт болон экспортын матрицын 2015, 2016, 2017 оны үр дүнг төлбөрийн тэнцлийн 6-р аргачлалаар тооцсон үр дүнгээр шинэчилж бэлтгэсэн.

Байгаль орчин- эдийн засгийн дансыг нэвтрүүлэх ажлын хүрээнд:

- Эрчим хүчний биет урсгалын данс, байгаль орчны татварын дансыг байгуулах аргачлалыг шинээр, материалын урсгалын дансыг шинэчлэн байгуулах аргачлалыг боловсруулж батлав.
- Эрчим хүчний биет урсгалын данс, байгаль орчин татварын данс, материал урсгалын данс байгуулах чиглэлд олон улсын байгууллагын зөвлөхүүдтэй хамтран ажилласан. Эрчим хүчний дансыг 2015-2017 оны гүйцэтгэлээр байгуулж, танилцуулга бэлтгэсэн.
- Материалын урсгалын дансны "Дотоодод ашигласан олборлолт"-ын хэсгийг 2005-2014 оны гүйцэтгэлээр шинэчлэн тооцсон.
- Материалын урсгалын дансыг 2005-2017 оны гүйцэтгэлээр байгуулж, танилцуулга бэлтгэсэн.
- "Байгаль орчныг хамгаалах зардлын судалгаа - 2018" -ын бэлтгэл ажлын хүрээнд БОАЖЯ-ны холбогдох ажилтнуудтай уулзалт зохион байгуулж, өмнөх судалгааны арга зүй болон маягт, нөхөх зааварт санал авч тусгасан.
- Шинэчлэн боловсруулж байгаа БОАЖЯ-ны мэдээлэл /БОХ/-ийн маягтын төсөлд байгаль орчин-эдийн засгийн дансны үзүүлэлтүүдээс гаргах боломжтойг судалж, санал өгсөн.
- Байгаль орчны татварын дансыг 2017 оны гүйцэтгэлээр байгуулж, танилцуулга бэлтгэсэн.
- Усны болон газрын данс байгуулах арга зүйг судалж, үндсэн хүснэгтүүд болон тэдгээрийн мэдээллийн эх үүсвэрийн тухай танилцуулга бэлтгэсэн.
- БОЭЗДС-ийн ерөнхий зураглал (Roadmap of SEEA)-ыг боловсруулсан.
- Байгаль орчныг хамгаалах зардлын дансыг 2015-2017 оны гүйцэтгэлээр байгуулж, танилцуулга бэлтгэсэн.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан /www.1212.mn/-д БОЭЗД-ны бүлэг шинээр нэмж, холбогдох хүснэгт, судалгааны мэдээллүүдийг оруулсан.
- АХБ-ны техникийн туслалцаатайгаар хэрэгжсэн "Байгаль орчин-эдийн засгийн данс байгуулах чадавхыг бэхжүүлэх нь" семинарт УСХ-ны ажилтнууд “Эрчим хүчний биет урсгалын данс 2015-2016”, ‘’Байгаль орчин татварын данс 2015-2016”, “Материалын урсгалын данс 2015-2016”: Арга зүй, мэдээллийн эх үүсвэр, үр дүн, цаашид анхаарах асуудал” сэдвээр илтгэл тавьж оролцсон

УСХ-ноос 2018 онд нийт 12 сэдвээр нийгэм, эдийн засгийн олон жилийн динамик мэдээлэлд үндэслэн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, бодлогын түвшинд анхаарах асуудлыг хөндсөн тусгайлсан шинжилгээ, судалгааны ажил хийж, танилцуулга боловсруулж, хэрэглэгчдэд тархаасан. **Тухайлбал:**

- "Эдийн засгийн өсөлт, ажилгүйдэл, ядуурлын хамаарал" судалгаа"
  Судалгаанд ашиглах эконометрикийн загварыг боловсруулж, 5 удаа туршилт тооцоолол хийж, үр дүнг эдийн засгийн өсөлт, ядуурлын хамаарлын талаарх 20 гаруй судалгаатай харьцуулан судалсан.
- "Хэрэглээний үнийн индексийн жингийн өөрчлөлтийн нөлөөлөл"
  Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн Статистикийн хорооноос Швейцарын Женев хотод 2017 оны 5 сард зохион байгуулсан хэрэглээний үнийн индексийн экспертүүдийн хуралд УСХ-ноос "Хэрэглээний үнийн индексийн жингийн өөрчлөлтийн нөлөөлөл" буюу "The Impacts of Weight Changes on Consumer Price Index" судалгааг танилцуулсан. Судалгааг Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн Статистикийн хорооны цахим хуудаст байршуулж, нийтэд тархаасан.
- "Монгол Улсын малын тоо толгой, бэлчээрийн даац хүрэлцээ"
  Динамик мэдээллийг 1964-2017 оноор бэлтгэн шаардлагатай тооцооллуудыг хийсэн. УСХ-ноос мал сүргийн тоог бэлчээрийн даац нөхцөлтэй уялдуулан тогтоох талаар төслийн хэлэлцүүлгийг 4-р сард зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч, ХААИС-ийн Хөдөө аж ахуйн эдийн засаг, хөгжлийн судалгааны төв, ХАА-н шинжлэх ухааны академи, ХААИС-ийн эрдэмтэн багш нар, Бэлчээр судлалын төв, ХХААХҮЯ, Газрын харилцаа геодези, зураг зүйн газар зэрэг холбогдох байгууллагуудын төлөөлөл оролцож, бодлого төлөвлөлтөд шаардлагатай судалгааны үр дүнг танилцууллаа.
- "Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн харьцуулсан судалгаа"
  Хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг аймаг, бүс нутгаар харьцуулсан кластер шинжилгээг хийж, хэрэглэгчдэд хүргэлээ.
- "Хүний хөгжлийн индексийн олон улсын харьцуулсан судалгаа"
  Хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг (хүний хөгжлийн индекс, тэгш бус байдлаар засварласан ХХИ, жендэрийн хөгжлийн индекс, жендэрийн тэгш бус байдлын индекс) 2016 оны бодит гүйцэтгэл болон 2017 оны урьдчилсан байдлаар аймаг, нийслэл, бүсийн түвшинд тооцож, 2014-2015 он худалдан авах паритетын чадварын тооцооны шинэчлэгдсэн мэдээлэлд үндэслэн тооцооллыг тодотгож хийлээ.
- "Инфляц ба төсвийн алдагдлын хамаарал судалгаа"
- "Ахмад настны нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа"
- "Гаднын шалтгаант нас баралт, түүнээс амиа хорлолтын өнөөгийн байдал"
- Хүн ам, дундаж наслалтын өөрчлөлт, нийгмийн даатгалын сангийн өөрчлөлтийг уялдуулсан "Хүн амын өсөлт, өөрчлөлт, хандлага" насны бүтэц," танилцуулга
- "Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд" танилцуулга.
- "Төрийн албан хаагчдын тоо, бүтэц, өөрчлөлт" танилцуулга.
- "Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлага" судалгаа зэрэг судалгаа шинжилгээний ажлыг хийж, хэрэглэгчдэд хүргэлээ.

Дээрх судалгаанаас гадна дараах судалгааны тайлан, танилцуулга, тооцоо, гарын авлага, толь бичгийг хийж тархаасан. **Үүнд:**

- "Жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны үр дүнд үндэслэн хүчирхийлэлд өртөх эрсдэлийн шинжилгээ" судалгаа, шинжилгээний ажлыг хийсэн.
  НҮБ-ын Хүн амын сантай хамтран 2017 онд хийгдсэн жендерт суурилсан хүчирхийллийн тархалтын судалгааны тайлан, 2018 оны 6 сарын 14 өдөр танилцуулах, тархаах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан.
  Судалгаагаар манай улсад эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийн хэлбэр, тархалт, шалтгаан, үр дагаврыг тодорхойлж, Тогтвортой хөгжлийн зорилтууд, тэр дундаа жендэрийн тэгш байдлыг хангах 5 дугаар зорилтын шалгуур үзүүлэлт, үр дүнг тооцох, олон улсын түвшинд харьцуулагдахуйц чанарын болон тоон мэдээлэл цуглуулсан. Мөн жендерт суурилсан хүчирхийллийн талаар тоон болон чанарын цогц мэдээлэлтэй болж, энэ чиглэлийн үйлчилгээг сайжруулж, нийгэм дэх хандлага, байдлыг өөрчлөх ухуулга нөлөөлөл хийхэд судалгааны дүнг ашиглах, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч болон хэрэглэгч нарт танилцуулах, цаашид хамтран ажиллах, бодлогын зөвлөмжийг боловсруулсан.
- БСШУСЯ, Биеийн тамир, спортын газартай хамтран 2017 онд анх удаа зохион байгуулсан Биеийн тамир, спортын улсын үзлэг,

тооллогын нэгдсэн дүн спортын цол, зэрэгтэй тамирчин, дасгалжуулагч, шүүгч, спорт заал, гадна талбай зэрэг олон үзүүлэлтийг гаргасан тайланг 2018 онд нийтэд танилцуулсан.

- Үндэсний статистикийн хороо Азийн хөгжлийн банктай хамтран зохион байгуулсан “Хөрөнгийн эзэмшил, аж ахуй эрхлэлтийг жендерийн төлөв байдлаар тодорхойлох нь” туршилтын судалгааны үр дүнг танилцуулсан. Туршилтын судалгааг 3 үе шаттайгаар 3008 өрхийн 5592 гишүүнээс ярилцлага хэлбэрээр авсан бөгөөд хөрөнгө эзэмших, аж ахуй эрхлэлт нь жендерийн түвшинд ямар байгаа талаарх мэдээлэл бий болгосон.
- "Албан ёсны статистикт их өгөгдлийг ашиглах боломж ба сорилт" танилцуулгыг боловсруулав. Монгол Улсын албан ёсны статистикт их өгөгдлийг нэвтрүүлэхэд бэлтгэл болгох үүднээс их өгөгдлийн талаар дэлхий нийтийн санаачилга, одоогоор боловсруулаад байгаа ойлголт, арга зүй, их өгөгдлийг ашиглах одоогийн боломж болон сорилтыг харуулсан.
- “Хууль бус үйл ажиллагаа” судалгааны хүрээнд “Хар тамхи, мансууруулах бодисын худалдааны өнөөгийн нөхцөл байдал”, “Хүн худалдаалах гэмт хэрэг болон биеэ үнэлэх үйл ажиллагааны өнөөгийн байдал” сэдэвтэй цуврал хэлэлцүүлгийн холбогдох төрийн болон төрийн бус байгууллагыг оролцуулан зохион байгуулсан. Биеэ үнэлэгчдийн зорилтот бүлэгт хяналтын судалгааг зохион байгуулсан. ЦЕГ-ын ЭЦГ-аас авсан мэдээлэл болон Глобал сангаас явуулсан тандалтын судалгааны үр дүнд үндэслэн хууль бус үйл ажиллагааны нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртгийн тооцоолол хийж байна.
- Аж үйлдвэр, барилга, тээвэр, хөдөө аж ахуй, гадаад худалдаа, хэрэглээний үнэ, хүнсний аюулгүй байдал, зам тээврийн осол, худалдаа үйлчилгээний салбаруудын танилцуулгыг 2017 оноор хийж, хэрэглэгчдэд тархаасан.
- Ерөнхий боловсролын сургуулийн 1-11-р ангийн сурагчдын математик, статистикийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх зорилгоор математикийн багшийн “Статистикийн арга зүйн гарын авлага”-ыг Боловсролын хүрээлэнтэй хамтран боловсруулан хэвлүүлж ерөнхий боловсролын 798 сургуульд хүргүүлсэн.
- Статистикийн нэр томьёоны англи-монгол тайлбар толийг шинэчлэн боловсруулав. “Статистикийн нэр томьёоны англи-монгол тайлбар толь”-ийг анх 2008 онд нийт 907 үзүүлэлт оруулсан байсныг 1450 гаруй үзүүлэлт болгон шинэчлэн өргөтгөж, үг хэллэг, утга найруулга, орчуулгыг хянаж, засварласан.

3.6 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

ҮСХ нь 2018 онд мэдээллийн технологийн хөгжил дэвшлийн үр дүнг албан ёсны статистикийн үйл ажиллагаанд өргөнөөр нэвтрүүлсэн. Үүний үр дүнд зарим статистикийн мэдээллийн баазад ахиц гарч, эдгээр ажлын туршлагад тулгуурлан цаашид илүү эрчимтэй ажиллахаар төлөвлөн хэрэгжүүлж байна. Тухайлбал, яамд, төрийн захиргааны байгууллагуудын хадгалдаг мэдээллийн баазад шууд нэвтрэх боломжийг бүрдүүлэх ажлыг цаашид үргэлжлүүлэх, сүлжээг хөгжүүлэх, ҮСХ-ны техник тоног төхөөрөмжийг эрс сайжруулах хэрэгтэй юм.

Статистикийн тооллого, судалгаа болон албан ёсны статистикийн мэдээг цуглуулах, боловсруулах үйл ажиллагаанд мэдээллийн технологийг өргөнөөр ашиглаж байна.

Тайлант хугацаанд 2018 оны төлөвлөгөөний дагуу 14 программ шинээр, 19 программд нэмэлт, засвар өөрчлөлт хийсэн. Эдгээрээс 5 программыг таблет технологи дээр хийсэн. Тухайлбал:

Шинээр хийсэн программ:

- Мэдээ тайлан боловсруулалтын хяналтын программ
- Цахилгаан эрчим хүчний баланс (АҮ-2), Дулаан эрчим хүчний баланс (АҮ-3), Олборлосон нүүрсний баланс (АҮ-4)-ны программ
- ҮСХ-ны сургалтын мэдээллийн нэгдсэн сангийн программ
- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ (АҮҮ)-ний программ
- Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны программ
- Нөөц ашиглалтын хүснэгтийн судалгааны программын гарах хүснэгт
- Байшин, орон сууцны тооллогын туршилтын программ
- Эд хөрөнгийн тооллогын QR код уншдаг программ
- Гадаад худалдааны мэдээний программ
- Цаг уурын хүндрэлийн судалгааны мэдээлэл цуглуулалтын 2018 оны программ
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртөг, зардлын судалгааны программ
- Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын туршилтын программ
- Захиргааны мэдээ тайлангийн программ
- Дотоод үйл ажиллагааны интранэт систем

Таблет технологи:

- Байшин, орон сууцны тооллогын туршилтын программ
- Эд хөрөнгийн тооллогын QR код уншдаг программ

- Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны программ
- Ажиллах хүчний туршилтын судалгааны программ
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн туршилтын тооллогын программ

Нэмэлт засвар өөрчлөлт хийсэн программ:

- Аж ахуйн, нэгж байгууллагын жилийн эцсийн мэдээний программ (ААНБ1, ААНБ2)
- Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын улирлын мэдээний программ (ХО-1)
- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл борлуулалтын мэдээний программ (АҮ-1),
- Хүний нөөцийн мэдээллийн сангийн программ (HR)
- Төлөвлөгөө, тайлангийн программ
- Ажиллах хүчний судалгааны (АХС) программ
- Улирлын 14 мэдээний программ (BZU1, MTC1, NBHU1, OSNAA1, CX1, XY1, SBT1, SHKHIU1, ESHS1, ZB1, ZG1, AJ1, ME1, TBB1)
- Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээний программ (НЗҮ-1)
- Мөнгө зээлийн сарын мэдээний программ
- Төмөр зам, агаарын тээврийн дэд салбаруудын сарын мэдээний онлайн программ (T7, T9)
- Хэвлэлийн тайлан сонин сэтгүүлийн жилийн мэдээний программ (XT1, CC1)
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан / www.1212.mn/-ийн iOS апплейкшин
- Хэрэглээний үнийн программ
- Статистикийн мэдээллийн 1212.mn аппликейшин
- Хөдөө аж ахуйн мэдээний программ
- Холбооны салбарын улирлын мэдээний программ
- Бизнес регистрийн сангийн программ
- Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны боловсруулалтын программыг шинэчиллээ.

Үндэсний статистикийн хороо нь албан ёсны статистикийн улирлын мэдээний программын технологийг өөрчлөн веб технологи уруу шилжүүлэн ААНБ-аас шууд статистикийн мэдээллийг цуглуулах боломжтой болсон.

Статистик мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулснаар статистикийн мэдээлэгч цаасан хэлбэрээр буюу маягтаар мэдээ тайланг бөглөж, аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт биечлэн очиж өгөх шаардлагагүй болж мэдээллийн үнэн бодит байдлыг хангах, мэдээлэл цуглуулах цаг хугацаа, зардлыг хэмнэж, мэдээлэл цуглуулах энэ үе шатны ажлын ачааллыг бууруулах боломжтой болсон.

- Орон зайн мэдээлэл боловсруулах, тооллого судалгааны нэгжийн байршил тодорхойлоход ашиглах суурь орон зайн мэдээлэл ашиглах зорилгоор ГЗБГЗЗГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд хаягийн болон кадастрын мэдээлэл авч тооллого судалгаанд ашиглаж байна.
- ArcGIS Online болон ArcGISPortal ашиглан орон нутгийн түвшинд орон зайн тархаалт, веб газрын зураг боловсруулан тархаах нөхцөлийг БОСТ-2019 туршилтын тооллогын урьдчилсан бүртгэлийн хүрээнд Дорнод аймаг, Улаанбаатар хотын 3 дүүрэг дээр туршсан. Сервер дээр сайжруулалт тохиргоо хийн, суурь өгөгдлийг /аймаг, сумын хил зэрэг/ сервис байдлаар ашиглахад бэлтгэх ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 2019 оноос ашиглах боломжтой болсон.
- Дэлхийн зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг / WCS/ -тэй хамтран малчдын байршил, малын тоо толгойн мэдээллийг ашиглан бэлчээрийн даац, талхагдлын судалгааг хийлгэж байгаа бөгөөд үр дүнг хамтран ашиглахаар гэрээ байгуулан ажиллаж байна.

Төрийн мэдээлэл солилцооны систем буюу ХУР системд холбогдох гэрээг байгуулан, мэдээлэл солилцох хуудсыг шинэчлэн, төрийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан нууцлал хангасан техникийн тохиргоог хийсэн.

Төрийн байгууллагуудын мэдээллийн нээлттэй байдал, ялангуяа захиргааны бүртгэл, статистикийн мэдээллийг технологийн хөгжлөөр дамжуулан ашиглах боломж өсөж байна. Түүнчлэн мэдээллийн технологи нь хамгийн бага зардлаар мэдээллийг цуглуулах, тархаах боломжийг олгож байна. Энэ нөхцөл боломжийг УСХ-ноос өөрийн үйл ажиллагаанд олон чиглэлээр хэрхэн ашиглаж байгааг энэ тайлангийн 3.3, 3.6, 3.7 дугаар бүлэгт тодорхой дурдсан болно.

Статистикийн мэдээллийн нэгдсэн www.1212.mn санг 1921-2018 оныг хамарсан, жил, улирал, сарын давтамжтай, улс, бүс, аймаг, сум, багийн түвшний 36 салбарын 774 гаруй статистик үзүүлэлтийг хамарсан байдлаар тогтмол баяжуулж, монгол, англи хэлээр хэрэглэгчдэд тархааж байна.

Мэдээллийн хүснэгтийн бүтцийг хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар өөрчлөх, мэдээллийн сангийн баяжилтыг хийх ажил тогтмол явагдаж байна. Жилийн эцсийн байдлаар 8 салбарт 30 гаруй хүснэгтийг шинээр нэмж, салбар доторх хүснэгт задлах, нэгтгэх ажил хийсэн. Тус мэдээллийн нэгдсэн сангийн загвар дизайн болон технологийг шинэчлэх ажлын хүрээнд 2018 онд дараах ажлыг хийсэн. **Тухайлбал:**

- Хүснэгтийг жил, улирал болон сараар зэрэг шүүлт хийх болон харуулдаг болгож шинэчилсэн.
- Гарсан тоон үзүүлэлтэд тооцоолол хийж үр дүнг харуулдаг болгосон.

- Тоон үзүүлэлтийг JSON форматаар татах хэсгийг шинээр нэмсэн.
- Цахим хуудасны хандалтыг бүртгэж тайлан болгон харуулдаг хэсгийг хийсэн.
- ААНБ-ын ажиллагчдын цалин хөлсний мэдээгээр сонирхолтой статистик хийж байршуулсан.
- 1212.mn болон opendata.1212.mn цахим хуудсыг ашиглах нөхцөлийг боловсруулж цахим хуудсанд байршуулсан.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn -ны загвар дизайныг шинэчилж салбаруудын инфографикийг шинээр хийсэн.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн www.1212.mn сангийн файлын сан болон салбаруудын танилцуулгыг шинэчилсэн.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан / www.1212.mn/-ийн iOS аппликейшнд үзүүлэлт сонгохгүй харах товч дархад алдаатай гардаг байсныг засварласан. Мөн шүүлтэд үзүүлэлт олдохгүй бол алдааны мэдээллийг гаргадаг болгосон.
- 1212.mn хүснэгт нэгтгэх хэсгийн хүснэгтийн үзүүлэлтийг тулгаж тохирох үзүүлэлтийг ангиллын кодыг авдаг хэсгийг хийсэн.
- www.1212.mn-ын хэл солигдох технологийг сольж өгөгдлийн сангаас мэдээллээ авдаг болгож шинэчилсэн.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn-ний салбар бүрд салбарын танилцуулга хэсгийг шинээр хийсэн.
- Тооллого, судалгааны каталогт ӨНЭЗС, АХС-ны 2017 оны мэдээллээр баяжуулаад байна. Одоогийн байдлаар нийт 11 төрлийн 41 тооллого, түүвэр судалгааны мета мэдээлэл, тайлан, асуулга болон анхдагч мэдээллийн санг монгол, англи хэлээр хэрэглэгчдэд хүргэж байна.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн үзүүлэлтүүдийн нээлттэй мэдээллийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангаж ажилласан. Нээлттэй мэдээллийн зарим үзүүлэлтийг аймгаар бүлэглэн авах боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр нэг сервисээр тухайн хэрэглэгч нэг аймгийн багц мэдээллийг авах боломжтой.
- Мөн англи хувилбар болон шаардлагатай нэмэлт, засварыг оруулан шинэчилсэн. Одоогийн байдлаар 650 гаруй үзүүлэлтийг сервис хэлбэрээр тархааж байна.
- Мета дататай холбогдсон хүснэгтийн доор мета датаг нь харах линкийг байршуулж өгсөн.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn Үндэсний дата төв рүү шилжүүлэн байршуулж, системийн шилжилттэй холбоотой тохиргоо, өөрчлөлтийг хийсэн

Мета мэдээллийн системийг ашиглалтад оруулан байнгын хөгжүүлэлт, сайжруулалтыг хийж байна. Системийн англи хувилбарыг шинээр үүсгэн, мета мэдээллийн үзүүлэлт бүрийн тоон үзүүлэлтийг харах боломжтой байдлаар статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn -тэй холбосон. Хэрэглэгчдэд Excel болон PDF байдлаар татаж авах боломжтой болсон.

Мета мэдээллийн системд мэдээллийн оруулсан байдлыг хянах боломжтой хэсэг нэмж оруулсан. Ингэснээр тухайн үзүүлэлт, мэдээ, тооллого судалгааны маягт оруулсан, оруулаагүй байгааг харж болно. Жилийн эцсийн байдлаар 134 мэдээ, тооллого, судалгааны маягт, 647 үзүүлэлтийн мета мэдээлэл, 22 ангилал, код, 1368 нэр томьёоны тайлбар болон 56 арга, аргачлал тус системд ороод байна.

ОУВС-гийн Сайжруулсан мэдээлэл тархаах ерөнхий стандарт (e-GDDS)-ыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Монгол банк, Сангийн яамтай хамтран Үндэсний нэгдсэн мэдээллийн цахим санг (NSDP) байгуулсны дагуу нийгэм, эдийн засгийн 22 салбарын (бодит сектор, төсвийн сектор, санхүүгийн сектор) мэдээний баяжуулалтыг сар бүрэн шинэчлэн, салбаруудын мэдээллийг xml өргөтгөлөөр олон нийтэд тархааж, тогтмол баяжуулж байна. http://web.nso.mn/NSDP/

Байгууллагын буюу УСХ-ны цахим хуудсыг боловсронгуй болгож мэдээлэл тархаах ажлын хүрээнд дараах ажлыг 2018 онд хийсэн. **Үүнд:**

- 21 аймгийн цахим хуудасны загварыг сайжруулж нэг хэлбэрт оруулан танилцуулга, илтгэл, цэс, 7 хоногийн үнийн мэдээг харагдах хэлбэрийг илүү ойлгомжтой хялбар ижил болгов.
- Цахим хуудсыг сайжруулах зорилгоор тухай бүр засвар өөрчлөлтүүдийг хийж нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна.
- Англи хувилбарын үндсэн цэсийн орчуулгын ажил хийгдэж байгаа бөгөөд цаг үеийн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр шинэчилж байна.

УСХ болон түүний орон нутаг дахь салбар нэгжийн техник, тоног төхөөрөмж, сүлжээний тогтвортой ажиллагааг хангах ажлын хүрээнд 2018 онд дараах ажлыг гүйцэтгэв. **Тухайлбал:**

- Төвийн болон салбар орон нутгийн сүлжээний (интернэт болон VPN сүлжээ) хэвийн ажиллагаа, нууцлал аюулгүй байдлыг хангаж ажилласан. Орон нутгийн 30 VPN төхөөрөмж, утасгүй сүлжээний рутерүүд, төв газрын 8 сүлжээний аюулгүй байдлын төхөөрөмж, 13 үндсэн сүлжээний төхөөрөмжийн тохиргоо үйлчилгээг хийж ажилласан.
- УСХ-нд төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтад эрсдэлийн үнэлгээ хийх, төлөвлөгөөт хяналт шалгалт хийх ажлын хүрээнд 6 сарын 11-нээс 15-ны хооронд Тагнуулын ерөнхий газартай хамтран ажилласан.

- Мэдээлэл тархаах, цуглуулах, дотоод мэдээллийн сан болон системүүд ажиллах физик сервер, виртуал серверүүдийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Байгууллагын дотоод болон хэрэглэгчдэд үйлчилж буй гадаад мэдээллийн системүүд болох 1212.mn, ХАӨМС, мал тооллого, arcgis болон xaomc-report гэх мэт тогтмол улирлын чанартай бүх тооллого судалгаанд ашиглагддаг системүүд болон төрийн нэгдсэн сүлжээний холболтыг хянаж тасалдалгүй найдвартай ажиллах сервер болон сүлжээний орчныг бүрдүүлж ажилласан.
- Серверийн өрөөний сүлжээний кабель эмх цэгцтэй зохион байгуулах ажил хийсэн мөн тэжээлийн хуваарилалт, сервер, сүлжээний төхөөрөмжүүдийн ажиллагаа болон агааржуулагч зэргийг байнга хянаж ажилласан. Систем болон сүлжээ, сүлжээний тоног төхөөрөмж, серверүүдийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан.
- УСХ хэмжээнд 24 ширхэг физик сервер , 26 ширхэг Virtual server гэсэн нийт 50 сервер ажиллаж байна.
- 2018 онд шинээр нэмэгдсэн системүүд болох intranet, opendata, metadata зэрэг системүүдийн тасралтгүй найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.
- УСХ-ний Үндэсний дата төвд хостинг хийдэг байгууллагын и-мэйл серверийн ажиллагааг бүрэн хариуцан ажилласан. УСХ-ны 797 хэрэглэгчийн и-мэйл хаяг нэмэх, хасах, и-мэйлийн нууц үг шинээр үүсгэж өгөх, спам и-мэйл blacklist-д оруулах, дискийн хэмжээг тогтмол хянаж багасгах, гадаад дотоодоос хандах хандалтыг зохицуулан ажиллаж байсан. И-мэйл үйлчилгээг шуурхай, даргын зөвлөл, гадаад харилцаа зэрэг орон нутаг, газар хэлтсүүдийн дундын групп үүсгэн тусгай зориулалтаар ашиглаж, өдөр тутмын мэдээ мэдээллийг цаг алдалгүй солилцон ажилласан.
- Монгол улсын хэмжээнд бүх сумдын статистик хариуцсан ажилтнуудад төрийн албан и-мэйл нээн, нууц үг, ашиглах зааврыг орон нутгийн статистикийн хэлтсээр дамжуулан хүргүүлж ажилласан.
- УДТ-д байрлаж буй төрийн байгууллагуудын сервистэй холбогдон ажиллаж байна.
- УДТ-рүү www.1212.mn, www.1212.mn oracle database, ХАӨМС-н программ, ХАӨМС-ын веб сервис, бусад мэдээллийн сан байрласан 4 ширхэг физик серверийг зөөн байршуулсан.
- Нэгдсэн сүлжээний мониторинг хийх (Solarwinds) программын хэвийн ажиллагаанд тогтмол хяналт тавьж, шаардлагатай тохиргоо, үйлчилгээг хийж ажиллаж байна.
- Салбарын хэмжээнд албан хаагчдын ашиглаж буй суурин болон зөөврийн компьютер, принтер, дундын хавтас зэргийг нэгдсэн хяналтад оруулах, албан хаагчдын нэвтрэх нэрийг бүртгэн, нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, үйлдлийн системийн шинэчлэл, антивирусын программ хангамжийн шинэчлэлийг тогтмол хийх үүднээс домэйн системийн хэвийн тогтвортой ажиллагааг хангаж ажилласан. Нийт домэйн системд орон нутгийн 254, төв газрын 118-н зөөврийн болон суурин компьютерыг домэйн үйлчилгээгээр хангаж байна.
- DHCP, WSUS болон DNS серверүүдийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Дотоод сүлжээнд албан хаагчдын ашиглах зөвшөөрөлтэй суурин болон зөөврийн компьютер, тоног төхөөрөмжийн бүртгэл хийж зөвшөөрөлтэй төхөөрөмжийг сүлжээнд оруулах бодлогыг хэрэгжүүлж ажилласан.
- Дотоод мессенжерийн серверт хэрэглэгч нэмэх, хасах, групп шинэчлэх, домэйн сервертэй хэвийн холбогдож ажиллах гэх мэт хэвийн ажиллагааг хангаж, гарсан асуудлыг тухай бүрд шийдвэрлэн ажилласан.
- Файл серверийн хэвийн ажиллагааг хангаж, УСХ-ны газар, хэлтсийн ажилчдын файлын хавтастай холбоотой үйлчилгээг хийж, нөөцлөлтийг тогтмол хийж ажилласан.
- Антивирусны программын лицензийг серверүүд болон 21 аймаг, нийслэл, дүүрэг, төвийн албан хаагчдын компьютерт сунгасан. Мөн шаардлагатай касперски серверийн сайжруулалтыг хийн, программын шинэчлэл, вирус унших болон вирус илрүүлэх үйл явцыг автоматжуулсан бодлогыг хэрэгжүүлэн ажилласан.
- УСХ-ны техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, компьютер, принтер, хувилах машин, үйлдлийн систем, хэрэглээний программ хангамж, сүлжээ, телефон утасны засвар үйлчилгээ хийж, заавар зөвлөгөө өгч ажилласан. Мөн байгууллагын шинээр худалдаж авах тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, судалгааг хийсэн.
- Хаалга, цаг бүртгэлийн системийн сервер сүлжээний тохиргоог хийж хариуцан ажилласан. Нийслэлийн 8 дүүрэгт цаг бүртгэлийн системийг шинээр суурилуулан сүлжээний аюулгүй байдлыг ханган ажилласан.
-
- Орон нутгийн албад болон олон улсын сургалт семинарт онлайн хурал хийх “GoToMeeting” программ хангамжийн тохиргоо, үйлчилгээг хариуцан ажилласан.
- Шинээр авсан сервер болон ASA төхөөрөмжүүд, тог баригч дээр шаардлагатай тохиргоог хийн байршуулан ажилласан.
- Интернэтэд ажиллаж буй систем, сервисүүдэд ирж буй халдлага, аюулыг тухай бүр илрүүлж зогсоож байна. Сүлжээний тоног төхөөрөмжүүдийн лиценз дуусантай

холбоотой аюулгүй байдлын системүүдийн хэвийн ажиллагаа алдагдаж бүрэн хүчин чадлаар ажиллахгүй болсон. Интернэтийг цагийн хязгаартай хаах, олон нийтийн сүлжээ, онлайн тоглоом, видео сайтыг дотоод сүлжээнд цагийн хязгааргүй хаах зэрэг арга хэмжээ авч ажилласан.

- SDG болон мал тооллогын системд зориулан 2 ширхэг физик серверийг шинээр авч систем суулган тохиргоог хийн хэвийн ажиллагаанд оруулан ажилласан.
- ҮСХ болон орон нутгийн салбаруудын интернэт урсгалыг 2 дахин нэмэх ажлыг Мобинет компанитай хамтран хийж ҮСХ-нд 30Мб, Нийслэлийн статистикийн газарт 10Мб, Аймаг орон нутаг, дүүргийн статистикийн хэлтэст 4 Мб болгон нэмсэн
- Байгууллагын байранд засвар хийсэнтэй холбоотойгоор өрөөнүүдийн дотоод сүлжээ болон холбооны кабелийг шинээр татах болон өөрчлөх ажлуудыг хийсэн.

3.7 МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ

ҮСХ нь 2018 онд Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (GSBPM)-т нийцүүлэн албан ёсны статистикийн мэдээллийг тархаах үйл ажиллагааг олон нийтийн хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр зохион байгуулах, статистикийн хэрэглэгчдэд албан ёсны статистикийн мэдээллийн хэрэгцээ, ач холбогдол, мэдээллийг мэдлэг болгож ашиглах сургалтыг хийх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэж хариу өгөх, хэрэглэгчидтэй зөвлөлдөх ажлыг хэрэгжүүлэв.

ҮСХ нь мэдээллийн нууцлалын болон мэргэжлийн хараат бус, бие даасан байдлын зарчмыг баримтлан жил бүр мэдээлэл тархаалтын нэгдсэн хуваарийг боловсруулан баталж, түүний дагуу албан ёсны статистикийн мэдээллийг цаг хугацаанд нь шуурхай тархаадаг.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn, байгууллагын цахим хуудас www.nso.mn, 1900-1212 лавлах утас, электрон /information@nso.mn/ хаяг болон бусад хэлбэрээр хэрэглэгчдэд мэдээллээр үйлчилж байна.

Мэдээлэл тархаалтын систем буюу статистикийн мэдээллийн нэгдсэн сан, статистикийн аргачлал арга зүйн мэдээллийн сан, тооллого, судалгааны каталог, тооллогын мэдээллийн сан, хүн ам зүйн үндэсний атлас зэрэг системүүдийг ашиглан тархаалтын бүтээгдэхүүний бэлтгэх, хэрэглэгчдэд сурталчлан таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Тухайлбал:

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn цахим хуудасны файлын сан болон газарзүйн мэдээллийн сан гэсэн цэсийг сар бүр болон тухай бүрд баяжуулах, боловсронгуй болгосноор статистикийн мэдээллийн хэрэглээ ашиглалт 2018 онд өмнөх оноос нэмэгдсэн байна.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn цахим хуудасны дизайн, бүтцийг боловсронгуй болгон, шинэчилж 1921-2018 оноор жил, улирал, сарын давтамжтай, улс, бүс, аймаг, сум, багийн түвшний 36 салбарын 774 гаруй статистик үзүүлэлтийг хамарсан байдлаар монгол, англи хэлээр баяжуулснаар сайтын хандалт 612.5 мянга гаруй болж өнгөрсөн оныхоос 81.2 хувиар өссөн.

ҮСХ-ны фейсбүүк хуудсанд 2018 онд цаг үеийн үйл явдлын мэдээ болон видео шторк, инфографик зэрэг 464 мэдээллийг байршуулснаар мэдээлэл авагчдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 22.6 хувиар нэмэгдэж, хэрэглэгчийн хандалт 33.5 мянга болов. Твиттер хуудсанд 400 мэдээлэл байршуулсан нь үзсэн дагагчийн тоо 23.3 мянга болж, өнгөрсөн оныхоос 10.9 хувиар нэмэгдсэн.

ҮСХ нь хэрэглэгчидтэй харилцах харилцаагаа үр дүнтэй болгон улам сайжруулж байна. Ялангуяа хэрэглэгч статистикийн бүтээгдэхүүнийг хэрэглэхэд илүү хялбар болгох, статистикийн бүх бүтээгдэхүүнд зориулсан нэгдсэн загвар боловсруулан түүнийгээ ашиглахын зэрэгцээ хэрэглэгчдийн авч буй статистик мэдээллийг сайжруулах зорилгоор тэдэнд зориулсан семинар зохион байгуулсан зэрэг олон үйл ажиллагааг 2018 онд амжилттай хэрэгжүүлэв.

Статистикийн салбарын (ДНБ, төсөв, гадаад худалдаа, мөнгө, хүн ам, эрүүл мэнд, боловсрол, дундаж цалин, ажиллах хүч, гэмт хэрэг, тээвэр, аж үйлдвэр, өрхийн орлого зарлагын салбарын мэдээлэл) мэдээллээр сар бүр, тусгайлсан (Монгол улсын нийт зээлийн дансны тоо, Монголын цагаан сар, Монгол улсын 100 ба түүнээс дээш настан, Цусны донорууд статистикийн нүдээр, 2 сарын 14 ба гэрлэлтийн статистик, 3 сарын 8 ба Монгол эмэгтэйчүүд, 3 сарын 18 ба Монгол эрэгтэйчүүд, 6 сарын 1 ба Монгол хүүхдүүд, 7 сарын 11 ба Монгол наадам, 10 сарын 1 буюу Ахмадын баяр, 11 сарын 26-ны Улс тунхагласны өдөр гэх мэт) сэдвээр тухай бүр инфографик бэлтгэн тарааж байна. Хэрэглэгчдэд хамгийн өндөр хүрсэн нь 2018 оны 3 сарын 8-ны өдөр тархаасан “Монгол эмэгтэйчүүд” инфографикийг нийт 121.0 мянга гаруй хүн сонирхож, 444 хэрэглэгч татан авсан байв.

Статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүний нэгдсэн стандартыг боловсруулах, мөрдөж, хэрэглэгчдийн дунд явуулсан судалгаа, ирүүлсэн санал хүсэлтийн дагуу статистикийн сарын танилцуулга, өврийн дэвтэр, жилийн эмхэтгэл зэрэг хэвлэмэл бүтээгдэхүүний агуулга, чанар, тархаах хэлбэрийг 2018 онд өргөжүүлэн сайжруулав.

Статистикийн газар зүйн мэдээллийн санг баяжуулах, сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангаж, тооллого судалгааны үр дүнг газар зүйн мэдээллийн санд оруулж, бусад сантай байршлаар

холбон, газрын зургаар үр дүнг тархааж байгаа нь мэдээллийн бодит байдлыг сайжруулах хөшүүрэг болохоос гадна хэрэглэгчдийн хүрээг тэлж, тоог өсгөж байна. Энэ ажлын хүрээнд:

- Хөдөө аж ахуйн завсрын тооллогын үр дүнгээр мал аж ахуй, газар тариалангийн салбарын 661 газрын зургийг аймаг, сумын түвшинд боловсруулж, үр дүнг тархаасан.
- Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний 2018 оны болон сүүлийн 7 хоногийн үнийн мэдээг байршлаар, Шатахууны 2018 оны болон сүүлийн 7 хоногийн үнийн мэдээг байршлаар буюу орон зайн мэдээллийн тогтмол гаргадаг болсон.
- Цас зудтай байгаа сумдын мэдээллийг 2018 оны хаврын байдлаар нэг удаа боловсруулан тархаасан. 2018 оны сүүлээс эхлэн, малчдын байршил, малын тоог мал тооллогын үр дүнгээр, Монгол орны цасны зузааныг 10 хоног бүр тогтмол, зудын эрсдэлийн зураглалыг тухай бүр Цаг уур, орчны шинжилгээний газраас авч тархааж эхэлсэн.
- Байшин, орон сууцны туршилтын тооллогод газарзүйн мэдээллийн системийн ашиглаж, хаягт суурилсан хэлбэрээр байршилд суурилсан Collector for ArcGIS программ ашиглан мэдээллийг цуглуулж үр дүнг харах, хяналт мониторинг хийх аппликейшн боловсруулсан. Туршилтын тооллогын үр дүнг ХАӨМС-ийн өрхтэй тулгах ажлыг гүйцэтгэсэн. “БОСТ-2019”-ын туршилтын тооллогын үр дүнг бодит цаг хугацаагаар сууцны байршлаар тархаав.

“Монгол Улсын Статистикийн жилийн эмхэтгэл-2017” номыг 1990-2017 он хүртэл 28 жилийн үзүүлэлтээр бэлтгэж, бүлэг бүрийн үзүүлэлтийг тооцох аргачлал, нэр томьёоны тайлбар оруулж, тухайн салбарын онцлох үзүүлэлтийг инфографикаар харуулсан байдлаар 1500 ширхэг хэвлүүлж УИХ, холбогдох яам, агентлаг, орон нутгийн статистикийн газар нэгж, олон улсын байгууллагуудад хүргүүлсэн. Мөн эмхэтгэлд тухайн бүлгийн гол үзүүлэлтүүдийг аймаг тус бүрээр газрын зургаар харуулсан нь шинэлэг ажил болсон.

Өмнөх 2 жилээс эхлэн баримталж буй зарчмаар шинэ эмхэтгэл бэлтгэхийн өмнө буюу 2019 оны эхний сард “Монгол Улсын Статистикийн жилийн эмхэтгэл-2017” номыг цахим хэлбэрээр YCX-ны статистикийн нэгдсэн мэдээллийн санд байршуулав. Энэ нь хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэхээс гадна тэдний мэдээллийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн тархаалтын шийдэл болсон.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн сарын танилцуулга, бюллетенийг англи, монгол хэлээр 2760 ширхэг, нугалбарыг 2800 ширхэг, улирал бүрийн дундаж цалингийн инфографикийг 1200 ширхэг, “Статистикийн өврийн дэвтэр-2017” эмхэтгэлийг 1200 ширхэг тус тус хэвлэн олон нийтэд хүргэсэн.

“Статистикийн өврийн дэвтэр”-ийг жилийн эмхэтгэл гарахаас өмнө статистикийн үзүүлэлтүүдийг урьдчилсан гүйцэтгэлээр тооцож, англи, монгол хэлээр бэлтгэн боловсруулж, улсын түвшний мэдээллийн агуулгыг нэмж, бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшингээр задалж, үнэ төлбөргүй тархаасан нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцэж, тэдний тоо, хүрээг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.

YCX-ноос статистикийн мэдээллийг илүү өргөн хүрээнд тархаах зорилгоор сар бүр хэвлэл мэдээллийн байгууллагуудын дунд хэвлэлийн бага хурлыг тогтмол зохион байгуулж байгаа нь олон улсын статистикийн байгууллагуудын хувьд сайн туршлага болж байна.

Хэвлэлийн хуралд 30-35 хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл (10-14 телевиз, 6-8 сонин, мэдээллийн 8-10 вэбсайт) хүрэлцэн ирж мэдээлэл авдаг.

Хэвлэлийн бага хуралд оролцогчдын тоо төдийгүй тэдний оролцоог нэмэгдүүлж, хэрэглэгчидтэй ойр ажиллах уулзалт, хэлэлцүүлэг, хурал зохион байгуулснаар олон нийттэй нягт хамтран ажиллах нөхцөл боломж бүрдэж байна. Ингэснээр статистикийн хэрэглэгчдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэж хариу өгөх, хэрэглэгчидтэй зөвлөлдөх замаар хэрэглэгчидтэй харилцаж, цаашид статистикийн бүтээгдэхүүнийг улам бүр сайжруулах үйл ажиллагаагаа төлөвлөж байна.

Статистикийн зарим мэдээллээр YCX-ны ажилтнууд хэвлэл, мэдээллийнхэнд тодруулга, ярилцлага өгөх, телевизийн шууд нэвтрүүлэгт (MNB TV, Eagle TV, V TV, MNC, Эх орон TV) ажилтнуудыг оролцох зэргээр мэдээлэл тархаалтын боломжит бүх хэлбэрийг ашиглаж байна.

Монголын үндэсний телевизийн “Өглөө хөтөлбөр”-өөр YCX-ны дарга болон ажилтнууд статистикийн мэдээллийг тооцон гаргаж буй аргачлал, арга зүй түүнд оруулсан өөрчлөлтийг тухай бүр хэрэглэгчдэд тайлбарлах таниулах 15 цуврал нэвтрүүлгийг бэлтгэн тархаасан.

Олон улсын байгууллагуудад нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн мэдээллийг гаргаж, хүргүүлэх ажлын хүрээнд сар бүрийн хэвлэлийн хурлын дараа нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн мэдээллийг хэвлэмэл байдлаар тархаадаг. Мөн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын сан зэрэг байгууллагуудад нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн мэдээллийг тусгайлан бэлтгэж

сар бүр мэйл хаягаар илгээж ажилласан.

Хэрэглэгчдэд “масс и-мэйл” илгээж байнга шинэ мэдээллээр хангаж ажлын хүрээнд https://mailchimp.com/ тусламжтайгаар хэрэглэгчийн бүртгэлд бүртгүүлсэн нийт 7000 орчим бүртгэлтэй и-мэйл хаяг руу сар бүрийн сарын мэдээний танилцуулгыг, судалгааны үр дүнгийн тайланг тухай бүр хэрэглэгчдэд шуурхай илгээв.

Статистикийн тоо мэдээлэл авахаар байгууллагын information@nso.mn хаягаар 2018 онд ирүүлсэн 420 хүсэлтийн хариуг шууд өгч, шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийг холбогдох газар, нэгжүүдтэй холбох ажлыг зохион байгуулав.

УСХ-ны номын сангаар 2018 онд нэг өдөрт дунджаар 7 хүн үйлчлүүлсэн байна. 2018 онд номын санд хандсан статистикийн мэдээлэл хэрэглэгч 1800 хүнд хүссэн мэдээллийг нь боловсруулан өгөх, ном товхимлоор үйлчилсэн байна.

Статистикийн мэдээллийн лавлах 1900-1212 лавлах утсаар өдөрт дунджаар 10 хүнд үйлчилдэг бөгөөд 2018 онд лавлах утсанд хандсан 2500 хүнд статистик мэдээллийн үйлчилгээг үзүүлэв.

Онлайн чатыг шинэчилснээр 2018 онд 2500 гаруй хэрэглэгч мэдээлэл авсан бөгөөд масс и-мэйлд бүртгэлтэй 7000 гаруй хэрэглэгчдэд сар бүр статистикийн мэдээллийг тогтмол хүргүүлж байна.

Статистикийн мэдээлэл хэрэглэгчдийн бүртгэлийн сан байгуулж, бүртгэлтэй хэрэглэгчдэд сар бүр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын талаарх танилцуулга зэргийг цахим хэлбэрээр хүргэдэг.

УСХ-ноос статистикийн байгууллагын үйл ажиллагаа, тооллого, судалгааны явц, үр дүн, статистикийн бүтээгдэхүүний видео шторк сурталчилгааг 2018 онд дараах сэдвээр бэлтгэн олон нийтэд тархаасан. **Тухайлбал:**

- "Статистикийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх" төслийн хэрэгжилтийн үр дүнг танилцуулах хаалтын арга хэмжээ.
- "Математик, статистик загварчлалын улсын анхдугаар уралдаан"
- "Хэрэглээний үнийн судалгаа"
- "Хилээр орсон гарсан зорчигчид, тээврийн хэрэгсэл"
- "2018 оны 1,2 дугаар сарын хэвлэлийн бага хурал"
- "Богино хэмжээний буюу хэвлэлийн хурал болон байгууллагаас гаргаж байгаа нэвтрүүлгийн эхлэл төгсгөлд цацагдаж байх лого шторк"
- Мал, тэжээвэр амьтдын тооллогын тухай 3 төрлийн сурталчилгаа
- Монгол улсын эдийн засаг, нийгмийн сарын танилцуулга
- Монгол улсын эдийн засгийн салбарын сарын мэдээлэл
- Монгол улсын нийгмийн салбарын сарын мэдээлэл
- Гадаад худалдааны салбарын танилцуулга

УСХ-ноос 2018 онд зарим судалгаа, шинжилгээний ажил болон тайланг хэрэглэгчдэд тухай бүр сурталчлан таниулж, судалгаа хийхэд ашигласан мэдээллээр статистикийн нэгдсэн санг баяжуулж байна. Мөн олон улсын байгууллагуудад Монгол Улсын эдийн засаг, нийгмийн албан ёсны статистикийн үзүүлэлт, тооцоог боловсруулан хүргүүлж байна. **Тухайлбал:**

- Монгол Улсын нийгэм эдийн засгийн мэдээний дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тоймын 2017 оны 12-р сар, 2018 оны 1-11-р сарын танилцуулгыг бэлтгэн тархаасан.
- 21 аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг 2017 оноор баяжуулан шинэчилсэн.
- ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцооны 2010-2015 оны эцсийн гүйцэтгэлийн дүнг 155 бараа, үйлчилгээний түвшинд шалгаж, зарим засварлалт, тайлбар хийж АХБ-д хүргүүлсэн.
- ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцооны 2016 оны НАХ-ийн үр дүнгээрх гүйцэтгэлийн дүнг 155 бараа, үйлчилгээний бэлтгэж, 2011 оны түвшинтэй харьцуулж тайлбар хийж АХБ-д хүргүүлсэн.
- ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцооны 2017 оны үр дүнгээрх гүйцэтгэлийн дүнг 155 бараа, үйлчилгээний бэлтгэж, шинэчлэгдсэн ангиллын дагуу зарим барааг задалж, тайлбар бэлтгэж АХБ-д хүргүүлсэн.
- НАХ-ийг 2016 оноор эцэслэн балансуулж, үр дүнд үндэслэн холбогдох тооцооллыг хийж, үндэсний тооцооны холбогдох мэдээллийг ОУБ-д хүргүүлсэн.
- ДНБ-ий 2017 оны 4 дүгээр улирал болон 2018 оны эхний 9 сарын дүнг Дэлхийн банк, АХБ, ОУВС, сангийн яаманд хүргүүлсэн.
- Дэлхийн банканд WEO-д ордог Үндэсний тооцооны холбогдох мэдээллийн асуулгыг бөглөж хүргүүлсэн.
- АХБ-ны Key indicator –т Үндэсний тооцооны мэдээллийг бэлтгэж хүргүүлсэн.
- Үндэсний тооцооны дагавар данс БОЭЗДС-ны тухай 6 нүүр маягтыг нөхөж, UNECE-д хүргүүлсэн.
- Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд ДНБ-тэй холбоотой үзүүлэлтийг 2016-2017 оноор гаргасан.
- АХБ-д Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөрийн хүрээнд ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцооны 2010-2016 оны эцсийн гүйцэтгэлийн дүнг 155 бараа, үйлчилгээний түвшинд шалгаж, зарим засварлалт, 2011 оны түвшинтэй харьцуулалт, тайлбар хийж хүргүүлсэн.

- ОУВС-гийн цахим хуудаст байрлах Үндэсний нэгдсэн мэдээллийн цахим сан (NSDP)-д УСХ, Сангийн яам, Монголбанкны хариуцах 22 салбарын 2017 оны 12-р сар болон 2018 оны 1-11-р сарын мэдээг шалгаж SDMX программд хөрвүүлж, тогтмол баяжилт хийсэн.
- Олон Улсын Валютын Сангийн сайжруулсан мэдээлэл тархаах ерөнхий стандарт (e-GDDS) нэгдсэн системийг сайжруулах ажлын хүрээнд 2018 оны Үндэсний нэгдсэн мэдээллийн цахим санд оруулах мэдээний хуваарь болон мета дата мэдээллийн аргачлалыг шинэчлэн батлуулан ОУВС-д хүргүүлсэн.
- ОУ-ын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөрийн Орон сууц, ус, цахилгаан, түлш; Тээвэр; Амралт, соёл; Боловсролын бүлгийн нийт 150 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээний 2017 оны III-IV улирал, 2018 оны I улирлын мэдээллийг шалгаж, тодруулж, засварласан.
- НҮБ-ын Статистикийн хэлтэс, Дэлхийн банк, Азийн бүтээмжийн төв, Азийн хөгжлийн банк, ОУВС, Монголбанк, Сангийн яам зэрэг газарт холбогдох форматын дагуу мэдээллийг хүргүүлсэн.


УСХ-ны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хэвлэлийн мониторинг явуулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагыг сонгон шалгаруулж явуулах уламжлалт ажлыг үргэлжлүүлэн хөндлөнгийн байгууллагын үнэлгээ дүгнэлтийн мөрөөр ажлаа сайжруулах ажлыг үйл ажиллагааны жил, улирлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж хэвшсэн.

Статистикийн мэдээлэл хэрэглэгчдийн дунд “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа-2018”-ийг 2018 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр “Хөгжил зууч ХХК”-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу 2018 оны 9 дүгээр сарын 15-аас 10 дүгээр сарын 15-ны хооронд 30 хоногийн турш Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийн ерөнхий боловсролын багш сурагчид болон их дээд сургуулийн багш оюутан, төрийн албан хаагчид, олон улсын байгууллагын ажилтан, албан хаагчдаас нийт 600 хэрэглэгчийг сонгон уламжлалт буюу цаасан хэлбэрээр судалгаанд хамруулж өргөн цар хүрээг хамарсан судалгаа болж чадсан.

Олон улсад нэр хүнд бүхий Open data watch ашгийн бус, төрийн бус байгууллага нь дэлхийн улс орнуудын албан ёсны статистикийн мэдээллийн хамрах хүрээ, нээлттэй байдалд үнэлгээг хийдэг. Энэхүү үнэлгээний гол зорилго нь улс орнуудын үндэсний статистикийн байгууллагууд болон мэдээлэл хэрэглэгчдийн хоорондын харилцааг дэмжих, статистикийн мэдээлэлд нэвтрэх нээлттэй байдлыг хангах, мэдээллийн зөрүүг тодорхойлох болон мэдээллийн нээлттэй бодлогыг дэмжихэд чиглэдэг.

Open Data Watch (http://odin.opendatawatch.com/report/rankings) байгууллагын дэлхийн 178 улс орны статистикийн байгууллагуудын 2018 оны мэдээллийн хүртээмж болон нээлттэй байдлыг үнэлгээгээр Монгол Улс нийт 100 онооноос 75.6 оноог авч, Зүүн Өмнөд Азийн бүсийн хэмжээнд 1 дүгээр байрт, Дэлхийн хэмжээнд 11 дүгээр байрыг тус тус эзэлсэн.

Country	Region	Overall ▲	Coverage	Openness
1 Singapore	South-Eastern Asia	85	67	100
2 Denmark	Northern Europe	84	70	96
3 Netherlands	Western Europe	82	67	96
4 Poland	Eastern Europe	81	75	85
5 Slovenia	Southern Europe	78	64	91
6 Finland	Northern Europe	78	70	85
7 Germany	Western Europe	77	63	89
7 Sweden	Northern Europe	77	69	85
9 Canada	North America	77	74	80



3.8 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үндэсний статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн анхдугаар хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн хурлаас гаргасан санал зөвлөмжийг статистикийн салбарын төв, орон нутгийн газар, хэлтсийн үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна.

Статистикийн хууль эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн уялдааг хангаж, хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг хөгжүүлэх хүрээнд 6 зорилго, 25 зорилт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 онд бүрэн хэрэгжүүлэв.

Үндэсний статистикийн хорооны 2017 оны үйл ажиллагааны тайланг дэлгэрэнгүй болон хураангуй байдлаар бэлтгэн системчилсэн үнэлгээний хамт Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж амжилттай дүгнүүлсэн.

УИХ-ын ЭЗБХ-ны 2018 оны 4-р сарын 25-ны өдрийн 8 дугаар тогтоолоор өгсөн үүргийг хэрэгжүүлэх тусгайлсан төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлсэн.

Улсын Их Хурлын 2018 оны 7 дугаар тогтоолоор Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулав.

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу энэ зөвлөл нь ҮСХ-ны статистикийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, өргөн барих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үндсэн үүргийн зэрэгцээ үндэсний статистикийн системийн зохицуулалтын үйл ажиллагааны түвшинг дүгнэх, системийн үр дүнтэй, ашигтай үйл ажиллагааг үнэлэх, мэдээлэгчийн ачаалалд үнэлгээ өгөх бүрэн эрхтэй байдаг. ҮСХ-ны дарга нь статистикийн зөвлөлийг удирдаж ажилладаг.

Энэ зөвлөлийн гишүүнээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх, Монголбанкны дэд ерөнхийлөгч, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндэсний хөгжлийн газрын дарга, Шинжлэх ухааны академийн тэргүүн дэд ерөнхийлөгч нар томилогдон ажиллаж байна. Тус зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн анхдугаар хурлаар Зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан.

Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит улсын тооллогыг зохион байгуулах Улсын комиссын анхдугаар хурлаар “Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит улсын тооллогыг зохион байгуулж явуулах үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Аймаг, нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай” тогтоолуудыг батлуулсан. Энэ удаагийн тооллогыг 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс 9-нд шилжих шөнийн 00:00 цагаас эхлэн 7 хоногийн турших явуулах товыг батлуулав.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний статистикийн хорооны 2018 онытөлөвлөгөөг11зорилтынхүрээндболовсруулан хэрэгжүүллээ. Үндэсний статистикийн хороо болон нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн 157 албан хаагчийн 2017 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын мэдээллийн санд бүрэн, үнэн зөв оруулж, тайланг тогтоосон хугацаанд гарган Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Мөн ажлын байрны чиг үүрэг өөрчлөгдсөн, албан тушаал дэвшсэн, шинээр томилогдохоор нэр дэвшсэн 27 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах ажлыг зохион байгуулсан.

Үндэсний статистикийн хорооны Даргын зөвлөл 14 удаа хуралдаж 50 асуудлыг, Арга зүйн байнгын зөвлөл 19 удаа хуралдаж 39 аргачлал, арга зүй, маягт зааврыг хэлэлцэн баталсан. Удирдлагын шуурхай хурал 20 удаа хуралдаж, цаг үеийн ажилтай холбоотой 184 үүрэг өгч, биелэлтэд хяналт тавьж ажилласан. ҮСХ-ны даргын 172, Тамгын газрын даргын 343 тушаал тус тус гарсан байна.

Статистикийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, статистикийн мэдээллийн өнөөгийн байдал, анхан шатны мэдээ, мэдээний чанар, түвшин, уламжлалт бус мэдээлэл түүний хэрэглээ ашиглалт, статистикийн мэдээлэл цуглуулах, тархаах, мэдээллийн технологи сэдвээр мэдээлэл хийж, цаашид хэрэгжүүлэх ажлаа тодорхойлсон.

Үндэсний статистикийн хорооны дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын дарга нартай 2018 оны үр дүнгийн гурвалсан гэрээ байгуулж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан.

Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үр дүнг үнэлж, үнэлгээг УСХ-ны Даргын зөвлөлийн хурлаар батлуулсан. Жилийн ажлын үр дүнгээр Увс, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн статистикийн хэлтсүүд эхний 3 байрт шалгарсан.

Манай улсын статистикийн системд хийгдсэн олон улсын цогц үнэлгээний багийн дүгнэлт, зөвлөмж болон хуулийн төслийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаагаар үндэсний хэмжээнд албан ёсны статистикийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэхэд Статистикийн тухай хуулийг боловсронгуй болгох, хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

“Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”, “Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан” зэргийг боловсруулсны үндсэн дээр Статистикийн тухай хуулийг шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэн УСХ-ны нийт ажилтнууд, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн дарга нарыг оролцуулан уулзалт зохион байгуулж, саналыг авч тусгасан.

Тайлант хугацаанд УСХ-нд 1227 албан бичиг ирүүлснээс хариутай 878 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, Төрийн болон албаны нууцад хамаарах 36 албан бичгийг хүлээн авч, 18 албан бичгийг бусад байгууллага руу шилжүүлсэн.

УСХ 2018 онд олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд 250 албан захидал хүлээн авч, 150 албан захидал илгээсэн бөгөөд 2000 гаруй цахим захидал харилцан илгээж хамтран ажилласан. НҮБ түүний төрөлжсөн байгууллагууд, хамтын ажиллагаатай олон улсын байгууллагуудаас ирүүлсэн 42 асуулгыг бөглөн хүргүүллээ.

Үндэсний статистикийн хорооноос 965 албан бичиг явуулж, иргэд, өөрийн албан хаагчдаас 125 өргөдөл хүлээн авч, шийдвэрлэсэн.

УСХ нь холбогдох дүрэм, журмын дагуу албан бичиг хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг төв болон 21 аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрыг хамруулан зохион байгуулж ажилласан. УСХ-ны 2017 оны 230 хадгаламжийн нэгж, бусад оны нийт 185 хадгаламжийн нэгжийг архивд хүлээн авч төвлөрүүлсэн.

Албан ёсны статистикийн мэдээ, тайлан болон сар бүрийн нийгэм эдийн засгийн танилцуулга, статистикийн жилийн эмхэтгэл, цахим сэтгүүлүүд, инфографикууд гэх мэт бүтээгдэхүүнүүдийг CD, DVD-нд хуулж цаасан болон цахим архивын баримт үүсгэн хадгалдаг.

3.9 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

УСХ нь 2018 онд хоёр талт болон олон талт гадаад харилцаа, хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрийг зохицуулах, донор болон хөгжлийн байгууллагуудын дэмжлэг, туслалцааг статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглүүлж ажиллав. **Тухайлбал:**

- НҮБ-ын Статистикийн комиссын 49-р чуулганд УСХ-ны дарга тэргүүтэй төлөөлөгчид оролцож, Монгол-Австралийн хамтран санаачилсан "Байгалийн нөөцөд суурилсан эдийн засгийн статистикийн Улаанбаатар хотын бүлгийн" боловсруулсан гарын авлагыг НҮБСК-ын 49 дугаар чуулганаар эцэслэн батлуулав. Монгол улсын УСХ нь энэ гарын авлагыг олон улсад хэрэгжүүлэхэд зөвлөхөөр ажиллах болсон. Энэ чуулганы үеэр Монгол улсын УСХ-ны төлөөлөгчид НҮБ-ын статистикийн хорооны дэд комиссын гишүүнээр болон НҮБ-ын зөвлөх группийн ТХЗ-ын мониторингийн хүрээнд хийгдэх ажлын хэсэгт орж ажиллав.

Америк, Ази, Номхон Далайн орнуудын Үндэсний тооллого, Статистикийн байгууллагын дарга нарын нийгэмлэг /ANCSDAAP/ 2018 оны 7 дугаар сарын 11-нээс 13-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Да Нанг хотноо Хүн амын тооллогын 29 дүгээр бага хурлыг зохион байгуулсан. Тус хурлын үеэр нийгэмлэгийн Удирдах зөвлөл ANCSDAAP-н Ерөнхийлөгчөөр УСХ-ны дарга сонгогдсон.

АНДОЭЗНК-ийн эдийн засгийн статистикийн удирдах хурал болон зохицуулах хорооны, мөн нийгмийн статистикийн асуудлаарх техникийн зөвлөх багийн гишүүний үүрэгт ажлыг УСХ-ны газрын дарга нар гүйцэтгэж байна.

2020 онд Хүн амын тооллогын 30 дугаар бага хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулахаар

болсон бөгөөд бага хурлын товыг ANCSDAAP-н нарийн бичгийн даргатай харилцан тохиролцсон.

- ҮСХ нь "21-р зууны Статистикийн Хөгжлийн Төлөөх Түншлэл" Консорциумын (ПАРИС21) Удирдах зөвлөлд гишүүнээр сонгогдон ажиллаж байна. ҮСХ олон улсын болон бүс нутгийн байгууллагууд (НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, ДБ, ОУВС, АХБ)-тай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр идэвхтэй ажилласан.
- Япон Улсын Статистикийн товчоо болон СИНФОНИКА байгууллагатай байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд ҮСХ болон аймаг, нийслэлийн статистикийн 6 ажилтан Япон Улсын Статистикийн товчоо, Япон Улсын Үндэсний статистикийн төв, Синфоника зэрэг байгууллагын үйл ажиллагааны систем, хүн амын онлайн тооллогын систем, албан ёсны статистикийн портал веб сайт(e-Stat), газарзүйн мэдээллийн систем (GIS), статистикийн мэдээллийн хэрэглээ, статистикийн тайлангийн систем (Statistic Dashboard), статистик мэдээллийн хоёрдогч хэрэглээ, Мэдээлэл харилцаа холбооны технологийн статистикийн үйл ажиллагаанд ашиглах, газарзүйн мэдээллийн систем болон албан ёсны статистикийн портал сайт чиглэлээр танилцсан. Цаашид зөвхөн туршлага солилцож, суралцахаас гадна хамтран бодитой ажил төлөвлөн хийх, ҮСХ-ны ажилтнуудыг тусгайлсан сэдвээр ажлын байран дээр нарийн мэргэшүүлэн сургах зэрэг бодит үр дүнтэй ажил төлөвлөн хийх болсон.
- СИНФОНИКА-тай шинээр байгуулсан гэрээний хүрээнд "Албан ёсны статистикийн бичил тоон мэдээллийн дүн шинжилгээ" сэдэвт 10 дахь удаагийн олон улсын семинарт ҮСХ-ны 2 албан хаагчийг хамруулсан.
- Унгарын статистикийн төв газрын ерөнхийлөгч хатагтай Габрейла Вукович нар 2018 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ХОСБ-ийг үзэглэв. ХОСБ-т гарын үсэг зурснаар зөвлөх үйлчилгээ авах, танилцах айлчлал хийх, харилцан туршлага солилцох замаар хамтран ажиллаж байна. 2019 оны 5 дугаар сард Унгарын статистикийн төв байгууллагын ерөнхийлөгчөөр ахлуулсан төлөөлөгчдийг хүлээн авах дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.
- БНСУ-ын Статистикийн газартай байгуулсан ХОСБ-ын хүрээнд хөдөө аж ахуйн статистик болон өрхийн орлого, зарлагын судалгааны хүрээнд харилцан туршлага судалсан болно.
- Финланд Улсын Статистикийн газартай 2017 онд байгуулсан ХОСБ-ын хүрээнд Финландад туршлага солилцох удирдлагын түвшний уулзалт, сургалтыг хийх санал солилцож, хүсэлтээ албан тоотоор хүргүүлж ажиллаж байна. Түүнчлэн ХОСБ-ын хүрээнд тогтмол хэвлэмэл бүтээгдэхүүн харилцан солилцож туршлага солилцож байна.
- ҮСХ болон Швейцар Улсын Холбооны статистикийн газартай хоёр талт хамтын ажиллагааг эхлүүлж, статистикийн бизнес регистрийг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах хүсэлтийг Швейцар Улсын Хамтын ажиллагаа, хөгжлийн агентлагт хүргүүлэх ажлыг зохион байгуулав.
- АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Тооллогын товчоотой CSPro-ийн хүрээнд хамтран ажиллах төслийн саналыг Олон улсын хөгжлийн агентлагийн суурин төлөөлөгчийн газарт илгээж, харилцан ажиллав. Дэлхийн банкны Ухаалаг засаг төслийн санхүүжилтээр АНУ-ын Тооллогын товчооноос 2018 оны 11 дүгээр сарын 26-наас 12 дугаар сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулсан "Тооллого, судалгаа боловсруулах андройд систем (CSPro)-ийн дунд түвшний хэрэглэгчдэд зориулсан сургалт"-д ҮСХ-ны Мэдээллийн технологийн газрын шинжээч хамрагдсан.
- Европын Эдийн засгийн комиссоос Статистикийн чиглэлээр 2018 онд зохион байгуулж буй зарим сургалтуудад Европын Чөлөөт Худалдааны Нийгэмлэгийн Статистикийн хэлтсээс дэмжлэг хүсэх ажлыг зохион байгуулж, харилцаж нийт 5 сургалтад оролцох санхүүжилтийг шийдвэрлүүлэв.
- ҮСХ-нд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд олон улсын зөвлөхүүдийн 20 гаруй удирдлагын уулзалт болж хамтран ажилласан байна.

3.10 ХҮНИЙ НӨӨЦ, СТАТИСТИКИЙН СУРГАЛТ

ҮСХ-ны хүний нөөцийн хөгжлийн бодлого нь боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэгдсэн байдаг.

Статистикийн төв орон нутгийн байгууллагад нийт 320 албан хаагч ажиллаж байгаагаас Үндэсний статистикийн хороонд 122, аймгийн статистикийн хэлтэст 129, нийслэл, дүүргийн Статистикийн хэлтэст 69 албан хаагч ажиллаж байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог нөөцөөс нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөл болон холбогдох салбар зөвлөлүүдэд хүргүүлж, мэргэшлийн шалгалтад тэнцсэн 15 иргэнийг ажлын байранд томилох, Төрийн албан хаагчийн

тангараг өргүүлэх ажлыг зохион байгуулсан.

Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн Статистикийн газар, хэлтсийн даргын сул ажлын байранд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан 18 албан хаагчдаас сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, удирдах албан тушаалтны дүгнэлт гарган, нэр дэвшүүлж уг албан тушаалд томилсон.

УСХ нь 2018 оны сургалтын хөтөлбөрийг үндэсний статистикийн салбарын төв болон орон нутгийн статистикийн байгууллагуудад болон төрийн захиргааны бусад байгууллагуудад зориулсан, статистикийн мэдээлэгч, хэрэглэгчид төдийгүй ерөнхий боловсролын сургуулийн сурагч, их дээд сургуулийн оюутанд гэсэн олон төрлийн түвшин, модулиудыг дотроо агуулсан байдлаар боловсруулсан. Тухайлбал:

- Монгол Улсын Статистикийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд 2012 оноос 4 шатлалт сургалтыг зохион байгуулж ирсэн. Сургалтаар статистикийн онолын болон нийгэм, эдийн засгийн салбарын статистик, эконометрик, статистикийн программ хангамж, үндэсний тооцоо, түүврийн дизайн, салбарын хууль, эрх зүйн мэдлэгийг олгодог. Төв, орон нутгийн статистикийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулдаг дөрвөн шатлалт сургалтад 2018 онд нийт 81 ажилтан суралцсан. Эдгээр ажилтны 12.3 хувь буюу 10 нь нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ажилтнууд байна.
- Төрийн албаны зөвлөлтэй хамтран УСХ, аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын нийт 129 ажилтнуудад төрийн албан хаагчийн эрх, үүрэг, ёс зүй, сахилга хариуцлагын талаар холбогдох сургалтуудыг зохион байгуулав.
- УСХ, нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн 70 мэргэжилтэнд зориулсан "Статистик мэдээллийн хэрэглээ болон дүн шинжилгээ хийх арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулав. Сургалтаар өрхөд суурилсан судалгааны мэдээлэлд кластерын шинжилгээ, компонентын шинжилгээ, дискриминантын шинжилгээ, ложистик регрессийн шинжилгээ зэргийг хийх онол, практик хосолсон мэдлэгийг олгосон.
- "Статистикийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх", "Өрхөд суурилсан судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх" "Анхан шатны баримт бүрдүүлэлт, өмчийн бүртгэл, ашиглалт", "Архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын арга зүй, зохион байгуулалт", "Статистикийн мэдээллээр инфографик хийх, статистикийн SPSS, E-Views, MS-Excel, MS-Access программын, "Орон нутгийн салбарын мэдээллийн технологи хариуцсан ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх" зэрэг сургалтыг салбарын төв, орон нутгийн албан хаагчдад тус тус зохион байгуулсан.
- Статистикийн тухай хууль тогтоомж, статистикийн мэдээ тайлангийн анхан шатны бүртгэлийг хөтлөх, www.1212.mn цахим хуудсыг ашиглах талаар сургалтад хамрагдахыг хүссэн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч, сум, аймгийн ЗДТГ, хэрэгжүүлэгч агентлагийн удирдах болон гүйцэтгэх түвшний болон аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн нийт 1050 ажилтныг хамруулсан сургалтуудыг зохион байгуулсан.
- Статистикийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг өргөн нэвтрүүлэх, ашиглах, статистикийн мэдээллийн нэгдсэн санг төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбон, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, орон нутагт ажиллаж буй албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулав. Энэ сургалтад нийт 31 албан хаагчид дотоод, гадаад сүлжээний тоног төхөөрөмжтэй хэрхэн ажиллах, албан цахим шууданг зөв зохистой ашиглах, аюулгүй байдлыг хангах, тоон гарын үсгийг ашиглах, статистикийн мэдээллийн нэгдсэн сан, системийн мэдээллийг хэрхэн удирдах, тооллого, судалгааны программ, системийг хэрхэн ашиглах талаарх шинэ мэдлэг олгосноос гадна мэдээллийн технологийн чиг хандлага, хиймэл оюун ухаан, статистикийн үйл ажиллагаанд шинэ технологи ашиглах шаардлага, ач холбогдлын талаар өргөн хүрээний мэдээлэл өгч, Үндэсний дата төв, Мобиком ХХК-ийн үйл ажиллагаатай танилцуулж практик мэдлэг олгосон байна.
- "ДНБ-ийг тооцох арга зүй, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны жилийн эцсийн тайланг ашиглах нь" сэдэвт сургалт зохион байгуулж, нийслэл, дүүргийн 54 албан хаагчдад аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны жилийн эцсийн тайланг хэрхэн хүлээн авах, шалгах талаарх практик мэдлэг олгосон байна.
- ArcGIS Online болон ArcGISPortal ашиглан орон нутгийн түвшинд орон зайн тархаалт, веб газрын зураг боловсруулах сургалтыг Дорнод аймгийн статистикийн хэлтсийн ажилтнуудад амжилттай зохион байгуулсан. ArcGIS сервертэй холбоотой тохиргоо, суурь орон зайн мэдээллийн бэлтгэх ажилтай холбоотой 2019 онд нийт орон нутагт ашиглахаар болсон.

- Олон улс болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан 72 удаагийн сургалт, семинар, арга хэмжээнд 67 (давхардсан тоогоор 111) албан хаагчид оролцож мэдлэг чадвараа дээшлүүлж бусад улс орноос холбогдох сэдвийн хүрээнд туршлага судаллаа.
- “Ухаалаг засаг” төслийн хүрээнд 3 удаагийн гадаад сургалтад УСХ-ны 4 ажилтан, 7 удаагийн дотоодын сургалтад нийт 1900 гаруй статистикийн салбарын болон холбогдох яам агентлагийн албан хаагч, баг хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч нар хамрагдаж статистикийн мэдлэг чадвараа дээшлүүлсэн болно.
- БНХАУ-ын Засгийн Газраас 2018 онд хөгжиж буй орнуудад зориулсан сургалт, семинаруудыг судалж, албан хаагчдаа хамруулах саналаа уламжилсны дагуу 2018 оны 10 сард зохион байгуулагдсан сургалтад УСХ-ны 3 албан хаагч, НСГ-ын 2 албан хаагч нийт 5 албан хаагчийг “Бизнес дата цуглуулах, шинжилгээ хийх” сэдэвт хөгжиж буй орнуудад зориулсан сургалтад хамруулж мэдлэг чадварыг дээшлүүллээ.
- Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу “Мал, тэжээвэр амьтдын тооллого”, “Малын хашаа, худгийн тооллого”, “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого”, “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”, “Байшин, орон сууцны тооллого”, Ажиллах хүчний судалгаа, Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид зохион байгуулж, мэдээлэл цуглуулах талаар 330 сум, 1613 баг, 152 хорооны Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч, Засаг даргын Тамгын газар, Цэргийн штаб, Онцгой байдлын газар, Статистикийн хэлтсийн ажилтнуудыг хамруулсан сургалтуудыг УСХ, аймаг, нийслэлийн Статистикийн газар, хэлтсийн ажилтнууд тухай бүр хийсэн.
- Таван жил тутам явагддаг "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа"-ны 150 судлаачдын сургалтыг Улаанбаатар хотод тус тус зохион байгуулсан. "НҮТС-2018"-ын судлаач, багийн ахлагчид сургалтын зардлын тооцоо, төлөвлөгөөг гаргаж батлуулан, 2018 оны 8 сарын 20-ны өдрөөс 9 сарын 21-ны өдрүүдэд нийт 130 хүнийг хамруулан сургалт зохион байгуулсан. Сургалтын явцад 2 удаагийн дадлага ажил зохион байгууллаа.
- УСХ нь яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад статистикийн мэдээлэл хариуцан ажилладаг албан хаагчдын чадавхыг бэхжүүлэхэд анхаарч ажилладаг бөгөөд 4 шатлалт сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2 албан хаагч сургалтад хамрагдсан бол 5 удаагийн гадаад сургалт, семинарт Монгол банк, БОАЖЯ, БСШУСЯ, УБЕГ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын холбогдох ажилтнуудыг оролцуулсан байна. Эдгээр албан хаагчид үндэсний тооцоо, ТХЗ-ын усны экосистемийн зорилгуудын хэрэгжилтэд мониторинг хийхэд дэлхийн ажиглалтын системийг ашиглах, ТХЗ-ын боловсролын холбогдох үзүүлэлтүүдийг тооцох, хөгжлийн бэрхшээлийн болон ердийн хөдөлгөөний статистикийн чиглэлээр мэдлэгээ дээшлүүлсэн байна.
- Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд мэдээллийн олон эх үүсвэрийг ашиглах нь” төслийг 2018 оны 7 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна. Холбогдох яамд, байгууллагын төлөөллийг оролцуулсан төслийн удирдах хороо, ажлын 5 хэсгийг байгуулж, семинарыг 2018 оны 11 дүгээр сард зохион байгуулсан.
- Монгол Улсад ADAPT буюу мэдээллийн төлөвлөлтийн дэвшилтэт арга хэрэгслийг боловсруулах платформыг хэрэгжүүлэх ажлыг “21-р зууны статистикийн хөгжлийн төлөөх түншлэл” (PARIS21) байгууллага болон Үндэсний хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан. ADAPT-ын шинэчилсэн хувилбар v1.1-ийг танилцуулах чиглэлээр яамд, төрийн бусад байгууллагын ажилтнуудад зориулсан 2 дахь удаагийн сургалтыг зохион байгуулсан.
- Нийслэл, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн тоо бүртгэл хариуцсан ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Анхдагч мэдээллийн бодит байдал ба статистикийн арга, аргачлал” сэдэвт сургалтыг зохион байгуулж гэмт хэргийн анхан шатны бүртгэлийг сайжруулах, энэ салбарын статистик мэдээллийг шинжлэх ухааны арга зүйгээр тооцох талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.
- Монгол Улсын ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг дүгнэх үзүүлэлтүүдийн талаар мэдээлэл хүргэх, мэдлэг олгох, тооцох арга зүйг танилцуулах, ногоон ажлын байрны төлөв байдлыг тодорхойлох, судалгааны үр дүнг хүргэх зорилгоор УСХ, яам, төрийн төв байгууллагын 70 ажилтанд зориулсан "Ногоон хөгжлийн үзүүлэлт, ногоон ажлын байр" сургалтыг 2018 оны 3-р сарын 15, 16-нд зохион байгуулав.
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ХЗДХЯ-тай хамтран "Тогтвортой хөгжлийн хэрэгжилт, төсөл" сэдэвт сургалтыг Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн Хууль зүйн салбарын удирдах ажилтнуудад Хэнтий аймагт зохион байгуулсан.

- “Түүврийн дизайн-судалгааны арга зүй” “Нөөц ашиглалтын хүснэгт тооцох аргачлал” сэдвээр, “Аж үйлдвэрийн статистикийн үзүүлэлтийг тооцох арга зүй” сэдвээр ХХААХҮЯ-ны статистикийн асуудал хариуцсан ажилтнуудад, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран "Хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт, хэрэглээний данс, хүнсний тэнцэл” сэдэвт сургалтыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Шинжлэх ухаан, техникийн их сургуулийн үйлдвэрлэлийн технологийн их сургууль, Төрийн бус байгууллагын төлөөлөлд зохион байгуулсан.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан хаагчдад “Нээлттэй мэдээллийг бий болгох чадавхыг бэхжүүлэх” сэдэвт сургалт, бусад яамдын албан хаагчдад “Мэдээлэл боловсруулах арга зүй” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан.
- Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлсэн “Байгаль орчин, эдийн засгийн данс байгуулах чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хаалтын семинар зохион байгуулсан.
- Семинарт БОАЖЯ, ЭХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний эдийн Улаанбаатар цахилгаан сүлжээ зэрэг байгууллагын мэдээллийн төвийн төлөөллийг хамруулсан.
- Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын яам, Японы Хамтын ажиллагааны нийгэмлэг ЖАЙКА, Улаанбаатар хот дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөлтэй хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ангиллыг илүү боловсронгуй болгох, анхдагч тоон мэдээллийн сан байгуулах улсын үзлэг, тооллогын ажлын суурь статистик мэдээллийн сургалт зохион байгуулсан.
- Үндэсний статистикийн хороо Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн, Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн хамтран Үндэсний тооцооны системийг нэвтрүүлэгч, оролцогч, хэрэглэгчдийг нэг дор цуглуулж, хэрэгжилт, ашиглалт, хэрэглээний талаарх мэдлэг, мэдээллээ солилцох “Үндэсний тооцооны систем-2018” хурлыг зохион байгуулсан.
- Нийслэлийн 9 дүүргийн 152 хорооны Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт зориулсан “Нээлттэй мэдээллийг бий болгох чадавхыг бэхжүүлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулж 1530 албан хаагчид хамрагдсан.
- Статистикийн мэдээллийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор “Статистик-хэрэглээ” сургалтыг зохион байгуулж Монгол Улсад суугаа Элчин сайд, Элчин зөвлөх, нарийн бичгийн дарга нар, Атташе, Консул, Эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан хэлтсийн дарга, хөгжлийн хөтөлбөр хариуцсан ажилтан зэрэг төлөөлөгчид оролцуулсан. Сургалтаар “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn)-ийн бүтэц, түүний хэрэглээ”, статистикийн мэдээлэл тархаалтын төрлүүдийн талаар танилцуулсан.
- Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг хамруулсан нийт 40 орчим хүнд хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтыг Ухаалаг засаг төслийн тусламжтайгаар амжилттай зохион байгуулав.
- Үндэсний статистикийн хороо нь МУИС, ХААИС, АНУ-ын Алабама Их сургуулиудтай хамтран “Орчин үеийн статистикийн арга техник” сэдэвт сургалтыг багш, оюутнуудад, “Статистикийн боловсролыг сайжруулах нь” сэдэвт сургалтыг хэвлэл мэдээллийн ажилтнуудад зохион байгуулсан.
- МУИС, СЭЗИС, Отгонтэнгэр их сургуулийн оюутнуудад “Статистикийн мэдээллийн ач холбогдлыг таниулах, түүнийг ашиглах мэдлэг, чадварыг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг хийсэн.
- Статистикийн боловсрол нь манай үндэсний хэрэгцээ тул жил бүр статистикийн өдрийг тохиолдуулан улс даяар статистикийн байгууллага, мэргэжлийг сурталчилсан танилцуулах хичээлийг ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад заадаг уламжлал тогтсон.
- ҮСХ-ны болон аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын ажилтнууд 2018 онд ерөнхий боловсролын нийт 62 сургуулийн 3688 сурагчдад (нийслэлийн 21 сургуулийн 1279 сурагчдад, 21 аймгийн 41 сургуулийн 2409 сурагчдад) нэг цагийн “Статистикийн боловсрол” сэдэвт хичээлийг заав.
- Статистикийн мэдээллийн сан www.1212.mn цахим хуудаснаас хэрэгцээтэй мэдээллээ хэрхэн авах сургалтыг 19 аймгийн их, дээд сургуулийн болон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн нийт 1250 гаруй оюутанд тухайн аймгийн статистикийн хэлтсийн ажилтнууд нь зохион байгуулсан.
- ҮСХ, Боловсролын хүрээлэнтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн 1-11-р ангийн сурагчдын математик, статистикийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх зорилгоор математикийн багшийн “Статистикийн арга зүйн гарын авлага”-ыг боловсруулан 8000 хувь хэвлүүлж, ерөнхий боловсролын 798 сургуульд хүргүүлсэн.
- Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт Багшийн боловсрол дээшлүүлэх институттэй

хамтран сургалт зохион байгуулсан.

- Монгол Улсад дээд боловсролтой Статистикийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 50 жилийн ойг тохиолдуулан МУИС-ийн Шинжлэх Ухааны сургууль-тай хамтран Статистикийн улсын олимпиадыг, Мандах Их сургуультай хамтран Статистикийн улсын II олимпиадыг бизнес удирдлагын чиглэлээр суралцдаг, статистикийн үндэс түвшний хичээл судалж буй их, дээд сургуулийн I, II дамжааны оюутнуудын дунд 4 дүгээр сард тус тус амжилттай зохион байгуулсан.
- Монголын Математикийн багш нарын академитай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Тогтвортой хөгжлийн зорилго-2030 ба хуванцар хог хаягдлын аюул" сэдэвт улсын анхдугаар уралдааныг зохион байгуулж 740 сурагч оролцсон.

3.11 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үндэсний статистикийн хорооны 2018 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсөв 9487.7 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд төрийн сангаас 96.3 хувь буюу 9133.4 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Тайлант хугацаанд статистикийн чадавхыг бэхжүүлэх төслийн арилжааны банк дахь үлдэгдэл болон ном товхимол борлуулж 74.5 сая төгрөгийн өөрийн орлоготой ажиллав.

Төсвийн урсгал зардлыг эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл: Ажиллагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 3906.0 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 223.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 4214.8 сая төгрөг, бараа үйлчилгээний зардалд 227.2 сая төгрөг нийт 8571,3 сая төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулагдаагүй хөрөнгийн үлдэгдэл 636.1 сая төгрөгийг Сангийн яамны төрийн санд буцааж төвлөрүүлсэн болно.

Төсөл хөтөлбөрийн хүрээнд Олон улсын байгууллагаас 1435.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, батлагдсан төсөв төлөвлөгөөний дагуу зарцуулж ажилласан.

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн "е"-д "нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг 5 жил тутам" зохион байгуулж явуулахаар хуульчилсан. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны мэдээлэл цуглуулах үе шатанд нийт 116 багийн ахлагч, судлаач нартай гэрээ байгуулсан бөгөөд гэрээний дагуу цалин хөлс, албан томилолт, унаа, хөтөч зэрэг холбогдох зардлыг нягтлан тухай бүр тооцон олгосон.

Аймгийн Статистикийн хэлтсийн дарга, жолооч болон судлаач нийт 132 хүнийг 11.5 сая төгрөгөөр гэнэтийн ослын даатгалд, "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018" судалгааны багийн 116 ахлагч, судлаачийг 1.1 сая төгрөгөөр гэнэтийн ослын даатгалд, 29 нэр төрлийн 278 ширхэг тоног төхөөрөмжийг 4.7 сая төгрөгөөр эд хөрөнгийн даатгалд, 3 тээврийн хэрэгслийг 1.6 сая төгрөгөөр тээврийн хэрэгслийн даатгалд тус тус хамруулсан.

Эд хөрөнгийн 2017 оны жилийн эцсийн тооллогын ажлыг зохион байгуулсан. Төрийн өмчийн хорооноос ирүүлсэн маягтын дагуу 2017 оны Үндэсний статистикийн хороонд бүртгэлтэй эд хөрөнгийн судалгааг гарган хүргүүлж, 2017 оны гэрээгээ дүгнүүлсэн. НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Статистикийн чадавхыг бэхжүүлэх төсөл болон бусад тооллого судалгааны зардлаар 41 нэр төрлийн 283 ширхэг 361.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр авч бүртгэлд тусгасан.

Өндөр насны тэтгэвэрт гарсан 3 хүнд 74.3 сая төгрөг, 12 хүнд 5.8 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 47 хүнд 8.4 сая төгрөгийн шагнал урамшуулал, шинээр мэндэлсэн 5 хүүхдэд 0.5 сая төгрөг, шинээр гэр бүл болсон нэг албан хаагчид 0.5 сая төгрөгийн тусламж дэмжлэгийг тус тус олгосон байна.

Үндэсний статистикийн хорооны 31 өрөөнд иж бүрэн засвар хийлгэж, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулсан.

Хэвлэх цех нь ХАНСГ, ЭЗСГ-ын мэдээний маягт, хагас жилийн мал тооллого, НҮТС-2018 судалгааны маягт зааврууд, нийгэм эдийн засгийн байдлын танилцуулга, мэдээ гаалийн мэдээ болон бусад сургалтын материал гарын авлага, илтгэлүүд, урилга, хөтөлбөр, албан бичгийн хуудас зэрэг нийт 6.4 сая хэвлэлийн даралтат хуудас материал хэвлэсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн баримт, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан зэрэг төслүүдийн 2017 оны санхүүгийн баримтад аудит хийлгэж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн дүнгээр зөрчилгүй дүгнэлттэй гарсан.

Орхон, Булган, Дархан-Уул, Дундговь, Төв, Баян-Өлгий, Завхан аймаг, Нийслэлийн статистикийн газарт санхүүгийн шалгалт хийж шалгалтын явцад гарсан алдаа дутагдлыг дарга нягтлан бодогч нарыг байлцуулан дор бүр нь танилцуулж, заавар зөвлөгөө өгч ажилласан.

Шилэн дансанд мэдээлэл байршуулах график төлөвлөгөө гарган 13 үзүүлэлтийн дагуу 180 мэдээлэл байршуулахаас давхардсан тоогоор YCX-ны болон төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны сайтад 180 мэдээлэл байршуулан ажиллаж байна.

Төсвийн тухай хуульд заасны дагуу YCX, аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс газраас 2019 оны төсвийн төсөл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн саналыг авч, нэгтгэн боловсруулж, 2019 оны төсвийг 10.2 тэрбум төгрөгөөр батлуулсан.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН САЛБАРЫН 2019 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Үндэсний статистикийн хороо 2018 оны үйл ажиллагааны зорилго, зорилтоо бүрэн хэрэгжүүлж, албан ёсны статистикийн мэдээллийн хүрээг тэлж, бодит байдалд нийцүүлэн, тархаалтыг нэмэгдүүлсэн зэргээр ажлын нэлээд ахиц дэвшилтэй ажиллалаа.

УСХ-ноос тархааж буй мэдээлэл бүрд чанарын хяналт хийх боломжгүй, зарим мэдээлэлд дүн шинжилгээ хийх цаг хомс тул тархааж буй мэдээлэлд тайлбар дутагдсан хэвээр байна. Энэ нь УСХ-ны ажилтнуудын өдөр тутмын ажлын ихэнх цаг нь тоо мэдээлэл цуглуулж нэгтгэх, боловсруулахад зарцуулагдаж, харин чанарын хяналт хийх, дүн шинжилгээ хийх, хариуцсан салбарын мэдээллээр судалгаа, шинжилгээ хийх цаг нь хомс байгаатай холбоотой юм. Иймд статистикийн ажиллагсдын тоог ялангуяа УСХ-ны ажилтнуудын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн статистикийн үйлдвэрлэлийн чанар, үр ашиг, өгөөжийг хангах үүднээс УСХ-ны дарга нь статистикийн төв болон орон нутгийн байгууллагуудын дунд хүний нөөцийг дахин хуваарилах удирдлагын хангалттай эрх мэдэлтэй байх хэрэгтэй байна.

УСХ нь үйл ажиллагааны зардлыг оновчтой буюу хэмнэлттэй ашиглах зорилгоор эдийн засгийн болон бизнесийн статистикийн мэдээллийг цуглуулахад түүвэр судалгааг өргөнөөр ашиглаж эхэлсэн. Цаашид захиргааны мэдээллийг ашиглан албан ёсны статистикийн мэдээллийг гаргах боломжийг судалж байна.

Энэ ажлын хүрээнд мэдээлэл болон харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглаж, байгууллага болон мэдээллийн сан хооронд мэдээлэл дамжуулах боломжтой юм. Үүнтэй холбогдуулан нутаг дэвсгэрийн түвшинд мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах, бизнесийн статистикийн судалгааг онлайн хэлбэрээр авах нь цаасан хэлбэрээр авч байсан уламжлалт аргыг халах төдийгүй статистикийн чанарт эерэг үр нөлөө үзүүлэх болно.

Мэдээлэл боловсруулах болон түүнийг шалгах үйл ажиллагааг аажмаар илүү төвлөрсөн байдлаар гүйцэтгэн байнгын мэдээ цуглуулах болон нэгтгэх ажлаас хүний нөөцийг чөлөөлөх боломжтойг бусад улс орны туршлагаас харж болно.

Энэ тохиолдолд илүү хүний нөөцийг мэдээлэлд шинжилгээ хийх, статистикийн мэдээллийг тайлбарлах, тархаах, чанарын шалгалт хийх ажилд шилжүүлэх боломжтой.

Мөн УСХ болон аймаг, нийслэлийн статистикийн албадын техник, тоног төхөөрөмж, мэдээлэл солилцох сүлжээний технологийг шинэчлэн сайжруулах нь зайлшгүй болж байна.

Албан ёсны статистикийн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд үр дүнтэй удирдан зохион байгуулахад юуны түрүүн дээр дурдсан тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх эрх зүйн үндэслэлийг Монгол Улсын Статистикийн тухай хуульд тусгах нь зүйтэй юм.

“Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлэхэд УСХ-ны үйл ажиллагааны төсвийг нэмэгдүүлэх нь шууд нөлөөлөх болно.

Үндэсний статистикийн хороо Монгол Улсын статистикийн салбарын 2019 оны зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго: Статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах, хэрэглээ ашиглалтыг нэмэгдүүлэх, орон нутгийн статистикийн нэгжийн чадавхыг бэхжүүлэх;

Зорилт:

1. Статистикийн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулж, статистикийн ерөнхий үйл ажиллагааны стандарт нэвтрүүлэх бэлтгэлийг хангах;
2. Үндэсний тооцооны системийн ашиглалтыг нэмэгдүүлэх, олон жилийн динамик мэдээлэлд үндэслэн шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх;
3. Статистикийн мэдээллийн чанар, шуурхай байдлыг сайжруулах, төрийн байгууллагуудын статистикийн мэдээллийн сангийн уялдааг хангаж, албан ёсны статистикийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх;
4. Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг бий болгох, тооцох аргачлал арга зүйг нутагшуулах, статистикийн мета мэдээллийн системийн баяжилтыг сайжруулах;
5. Хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, донор болон хөгжлийн байгууллагуудын дэмжлэг, туслалцааг статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглүүлэх;

---oOo---

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ НЭР:

Анхан шатны нэгжийн үйл ажиллагаа, хүний нөөцийн хэрэгцээнд хийсэн системчилсэн үнэлгээ

1. КОД:

СҮ-1902

2. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН БАГ

Бямбаагийн Саранчимэг
ҮСХ-ны Дотоод Аудит, Мониторингийн Хэлтсийн дарга
Утас: 261560
Цахим хаяг: saranchimeg@nso.mn

Норолхойжавын Болормаа
Ахлах Референт
Утас: 261560
Цахим хаяг: bolormaa.n@nso.mn

Дамбийжанцангийн Энхзаяа
Ахлах Референт
Утас: 261560
Цахим хаяг: enkhzaya@nso.mn

Дугарбаатарын Нямсүрэн
Референт
Утас: 261560
Цахим хаяг: nyamsuren@nso.mn

Үндэсний статистикийн хороо
Засгийн газрын III байр
Бага тойруу 44, Сүхбаатар дүүрэг
14200 Улаанбаатар, Монгол Улс

УДИРТГАЛ

1.1 УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолд УИХ-ын харьяа байгууллагууд уг тогтоолд заасан дөрвөн сэдвээр жил бүр үйл ажиллагааны системчилсэн үнэлгээ хийж, УИХ-д тайлагнаж байхаар заасны дагуу энэхүү системчилсэн үнэлгээг хийлээ.

1.2 "Статистикийн тухай" хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх, стратегийн зорилгодоо хүрэхэд анхан шатны нэгжүүдийн мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа, ажилтны ачаалал, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлоход энэхүү системчилсэн үнэлгээний зорилго оршино.

1.3 Системчилсэн үнэлгээг хийхдээ Хууль зүйн яамнаас 2013 онд боловсруулсан аргачлалын дагуу "Баримт бичиг судлах", "Ажиглалт хийх", "Санал асуулга авах" аргуудыг ашиглав. Түүнчлэн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан "Хөдөлмөр эрхлэлтийг оношлох шинжилгээ: Арга зүйн зөвлөмж (Employment diagnostic analysis: A methodological guide)"-ийг ашиглалаа.

1.4 Анхан шатны мэдээлэл цуглуулах ажлыг хариуцдаг ажилтнуудын 2018 оны үйл ажиллагааны тайлан, чиг үүрэгт үндэслэн үйл ажиллагааны дараах чиглэлүүдэд үнэлгээ хийлээ. Үүнд:

1.4.1 – Анхан шатны нэгжид ажиллаж байгаа хүний нөөцийн хуваарилалт

1.4.2 – Ажлын ачаалал, шагнал урамшуулал

1.4.3 - Хүний нөөцийн чадавх бэхжүүлэх, давтан сургах үйл ажиллагаа, хүний нөөцийн хэрэгцээ

1.4.4 Албан хаагчдын ажлын ачаалал, хүний нөөцийн хэрэгцээ

1.5 Системчилсэн үнэлгээний зорилго, зорилттой холбогдуулан дараах эрх зүйн актыг шалгуур болгов. Үүнд:

1. УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоол,
2. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам";
3. УСХ-ны даргын 2017 оны 200 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний статистикийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам",
4. Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 55 дугаар тушаалаар батлагдсан системчилсэн үнэлгээ хийх аргачлал.

ХУРААНГУЙ

Үндэсний статистикийн хороо нь 2018 онд "Статистикийн хууль эрх, зүйн орчинг төгөлдөржүүлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн уялдааг хангаж, хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх" үндсэн зорилгыг дэвшүүлэн эдгээрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах 8 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1) Статистикийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
2) Анхан шатны мэдээллийн хяналт шалгалтыг өргөжүүлэх, мэдээллийн чанарт ахиц дэвшил гаргах, үнэн бодит байдлыг дээшлүүлэх;
3) Статистикийн үйл ажиллагааны ерөнхий стандарт загварыг нэвтрүүлж эхлэх;
4) Статистикийн салбарт хяналтын үр нөлөөтэй тогтолцоог бэхжүүлэх
5) Статистикийн дүн шинжилгээний чадавхыг бэхжүүлэх, шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх;
6) Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, статистикийн мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах;
7) Статистикийн салбарын чадавхыг бэхжүүлэх, төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг сайжруулах;
8) Монгол Улсын статистикийн салбарын олон болон хоёр талт хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхээр 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлыг хийж гүйцэтгэсний дотор "Анхан шатны мэдээллийн хяналт шалгалтыг өргөжүүлэх, мэдээллийн чанарт ахиц дэвшил гаргах, үнэн бодит байдлыг дээшлүүлэх", "Статистикийн салбарын чадавхыг бэхжүүлэх, төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг сайжруулах" зорилтуудын хүрээнд дараах дэвшилтэт, шинэлэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна:

1. Статистикийн байгууллагын бие даасан хараат бус байдал, төсөв санхүүг бэхжүүлэх, анхан шатны мэдээллийн

үнэн бодит, шуурхай байдал, хамралт, чанарын түвшинг сайжруулах, эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хүрээнд “Статистикийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалыг боловсруулсан байна.

2. ҮСХ, БСШУСЯ, ЭМЯ-тай хамтран 11 аймгийн 52 сум, нийслэлийн 4 дүүрэг, 302 баг, 430 байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөн тусалж ажилласан нь анхан шатнаас цуглуулж байгаа болон тооллого, судалгааны анхдагч мэдээллийн чанарт тавих нэгжийн дотоод хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх, арга зүйн нэгдмэл байдлыг хангах, статистикийн төв, орон нутгийн байгууллага болон албан ёсны статистикийн анхдагч мэдээллийг гаргадаг анхан шатны нэгжийн хамтын ажиллагаа, эргэх холбоог улам сайжруулах ач холбогдолтой ажил болжээ.

3. Түүнчлэн 10 аймаг, 6 дүүрэгт хэрэглээний үнэ, үйлдвэрлэгчийн үнэ, орон сууцны үнэ, бизнес регистрийн болон эдийн засгийн салбаруудын мэдээлэл цуглуулалт, мэдээллийн чанар, динамик бүрдүүлэлт, мэдээлэл боловсруулалтад хяналт хийж, зөвлөмж заавар өгч ажилласан нь сар, улирал, жилийн давтамжтай анхдагч мэдээллийн чанарыг хангахад чухал үйл ажиллагаа болсон байна. 2018 оны 6 дугаар сарын 4-11-ний өдрүүдэд зохион байгуулсан хагас жилийн малын түүвэр судалгааны хяналтыг 4 аймагт, жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын явцын хяналтыг 2018 оны 12 дугаар сарын 7-17-ны хооронд 5 аймаг, 2 дүүрэгт тус тус зохион байгуулсан байна.

4. Мөн ҮСХ, ЭМЯ, УБЕГ-ын хамтран шинээр төрсөн хүүхдийг 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийслэл, улаанбаатар хотын бүх шатлалын эмнэлэгт, 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс аймгийн төрөх эмнэлэгт цахимаар бүртгэж эхэлснээрээ ЭМЯ-ны төрөлтийн бүртгэл болон УБЕГ-ын төрөлт, нас баралтын бүртгэлийн дунд нэг ч иргэн орхигдохгүй байх боломжийг бүрдүүлсэн төдийгүй иргэдэд төрийн үйлчилгээг шат дамжлага багатай, улам ойроос хүргэх нэг шинэ алхам болсон байна.

5. ТХЗ-ын хэрэгжилтийн хүрээнд төрийн бусад байгууллагуудтай хамтран шалгуур үзүүлэлтийн тоон мэдээллийг гаргах боломжийг судалж, 2018 онд 4 дэх дахин үнэлгээг хийж, 2018 оны 12-р сарын байдлаар, албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллээс нийт 118 үзүүлэлтийн мэдээллийг 2015, 2016, 2017 болон боломжит оны гүйцэтгэлээр гаргаж, ТХЗ-ын веб хуудсанд байршуулан, тухай бүрд баяжилтыг хийж, хэрэглэгчдэд тархааж байна.

6. Статистикийн төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд болон бусад чиглэлээр зохион байгуулсан сургалтад 21 аймаг, нийслэл, дүүргийн болон төрийн байгууллагуудын статистикийн мэдээлэл хариуцан ажиллаж байгаа ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлагад үндэслэн 2018 онд нийт 120 албан хаагчдыг сургалтад хамруулаа. Сургалтаар статистикийн салбарын хууль эрх зүйн тогтолцоо, мэдээллийн нэгдсэн сан, статистикийн мэдээ тайлан гаргах, анхаарах асуудал, дотоодын нийт бүтээгдэхүүн тооцох арга зүй, удирдлагын манлайлал, мэдээллийн технологийн хэрэглээ, тоон гарын үсэг ашиглах заавар сэдвээр мэдлэг олгосон байна.


7. Тооллого, судалгаа, мэдээ цуглуулах үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлж, цаг хугацаа, хүн хүч, төсөв санхүүг хэмнэхэд онцгойлон анхаарч, ҮСХ-ны 2018 оны жилийн төлөвлөгөөний дагуу 14 программ шинээр хийж, 19 программд нэмэлт, засвар өөрчлөлт хийсэн бөгөөд 5 программыг таблетаар мэдээлэл цуглуулахад зориулан хийсэн байна.

1. АНХАН ШАТНЫ НЭГЖЭЭС ЦУГЛУУЛЖ БУЙ МЭДЭЭ, ТАЙЛАН

“Статистикийн тухай” хуульд заасанчлан, үндэсний статистикийн тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрддэг бөгөөд суманд статистикийн үйл ажиллагааг сумын Засаг даргын Тамгын газрын уг ажлыг хариуцсан ажилтан, баг, хороонд тэдгээрийн Засаг дарга эрхлэн гүйцэтгэж байна. Анхан шатны нэгжид 330 төрийн сангийн мэргэжилтэн, 1615 багийн Засаг дарга, 165 хорооны Засаг

дарга нар ажиллаж “Статистикийн тухай” хуулийн 5.3-т заасны дагуу албан ёсны статистикийн мэдээллийг цуглуулах, тооллого, судалгаа явуулахад, баг, хорооны Засаг дарга нар, сумын статистик хариуцсан ажилтнууд[1] анхдагч мэдээллийг цуглуулж, аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн газар хэлтсүүд нэгтгэн, боловсруулахаас гадна том аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн газар хэлтсүүд шууд авч нэгтгэн боловсруулж, ҮСХ-нд ирүүлдэг.

Зураг 1. Үндэсний статистикийн байгууллагын тогтолцоо



Орон нутгийн газар, хэлтсүүд нийгэм, эдийн засгийн 53 төрлийн мэдээ, тайланг сар, улирал, жилийн давтамжтайгаар сум, баг, хорооноос 270 удаа авч нэгтгэдгээс гадна доор дурдсан 8 судалгаа, 8 тооллогыг тогтсон хугацаанд, бүрэн хамралттайгаар зохион байгуулж байна. “Статистикийн тухай” хуульд заасан эдгээр судалгаа, тооллогыг орон нутагт зохион байгуулах ажлыг аймаг, нийслэл, дүүргийн статистикийн хэлтэс, газрууд хариуцан, мэргэшсэн судлаач нартай хамтран мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэдэг:

a. **Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн судалгаа** – 21 аймаг, нийслэлийн 6 дүүрэг, 112 сумын 1000 гаруй цэгээс 6000 гаруй үнэ, тарифыг сар бүрийн 25-28-ны хооронд аймаг, нийслэлд нийт 28 үнэ цуглуулагч, суманд сумын статистик хариуцсан ажилтнууд цуглуулдаг бөгөөд статистикийн хэлтэс, газрууд хэрэглээний үнийн индекс тооцдог. Энэхүү судалгаа нь инфляцын түвшинг тодорхойлох зорилготой.

b. **Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа** – судалгааны мэдээллийг сар бүр цуглуулж, үр дүнг улирлаар гаргадаг. Сар бүр 21 аймаг, 9 дүүргийн нийт 1374 өрх, улиралд 4122 өрх, жилдээ 16488 өрхөөс аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын 75 судлаач мэдээлэл цуглуулж, анхдагч мэдээллийн чанарт аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын дарга нар хяналт тавьж ажилладаг. Энэхүү судалгаагаар хүн амын амьжиргаа, ядуурал, хэрэглээний талаарх мэдээллийг улсын хэмжээнд болон бус нутаг, аймаг, нийслэлийн түвшинд гаргадаг.

c. **Ажиллах хүчний судалгаа** - судалгааны мэдээллийг сар бүр цуглуулж, үр дүнг улирлаар гаргадаг. Сар бүр 21 аймаг, 9 дүүргийн нийт 1068 өрх, улиралд 3204 өрх, жилдээ 12816 өрхөөс аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын 75 судлаач мэдээлэл цуглуулж, анхдагч мэдээллийн чанарт аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын дарга нар хяналт тавьж ажилладаг. Энэ судалгаагаар хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн талаарх мэдээллийг улсын хэмжээнд болон бус нутаг, аймаг, нийслэлийн түвшинд гаргадаг.

d. **Барилгын өртгийн индекс тооцох судалгаа** – барилга, байгууламжийн өртгийн индекс тооцох, ДНБ-ийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэх тооцоонд ашиглах, барилгын салбарын өртгийн болон үнийн өсөлтийг харьцуулах зорилгоор улирал бүр 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж буй барилга, түүнийг гүйцэтгэж буй ААНБ-аас мэдээлэл цуглуулдаг.

e. **Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын улирлын судалгаа** – ДНБ-ий улирлын тооцоог хийх зорилгоор улирал бүр ААНБ-уудаас хөрөнгө, хөрөнгө оруулалтын мэдээллийг цуглуулдаг.

[1] Төрийн сангийн ажилтан

f. **Цаг ашиглалтын түүвэр судалгаа** - Өрх, гэр бүлийн доторх хөдөлмөрийн хуваарилалт, хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт хүн амын зарцуулж байгаа цагийг гаргахаас гадна хүн амын амьдралын хэв маягийг тодорхойлох зорилгоор 4 жил тутам явуулдаг бөгөөд 21 аймаг, 9 дүүргийн нийт 4000 өрхөөс аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын 75 судлаач улирал бүр мэдээлэл цуглуулдаг. Анхан шатны мэдээлэл цуглуулалт, цуглуулсан мэдээллийн чанарт аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн дарга нар хяналт тавьдаг. Энэ судалгаа нь өрхийн 12 ба түүнээс дээш насны гишүүдээр хоногийн 24 цагт хийсэн ажил болон тэдгээрт зарцуулсан хугацааг 10 минут тутамд бичиж тэмдэглүүлдэг онцлогтой.

g. **Нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгаа** – 5 жил тутам, 21 аймаг, 9 дүүргийн нийт 15500 өрхөөс тусгай бэлтгэсэн 20 ахлагч, 100 судлаач мэдээлэл цуглуулж ажилладаг. Анхан шатны мэдээлэл цуглуулалт, цуглуулсан мэдээллийн чанарт аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн дарга нар хяналт тавьдаг. Тогтвортой хөгжлийн зорилт, Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал, НҮБ-ын ерөнхий Ассамблейн ХДХВ/ДОХ-ын асуудлаар тусгай чуулганы тунхаглал болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр зэрэг үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийн тоо мэдээллийн санг бүрдүүлэх үндсэн зорилготой.

h. **Салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг байгуулах** - улс орны эдийн засгийг илүү дэлгэрэнгүй тодорхойлох, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бараа, үйлчилгээний ашиглалт болон тухайн үйлдвэрлэл дэх орлого бүрдэлтийг нэгдсэн байдлаар харуулах, эдийн засаг дахь эрэлт, нийлүүлэлтийн тэнцэл буюу хэрэглэгчид, үйлдвэрлэгчдийн хоорондын худалдан авалт, борлуулалтыг нэгдсэн байдлаар харуулах зорилгоор 5 жилд нэг удаа энэ судалгааг явуулж, статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй 150 гаруй мянган аж ахуйн нэгжээс судалгаа авдаг. Статистикийн төв, орон нутгийн байгууллагын ажилтнууд мэдээлэл цуглуулалтыг хариуцан гүйцэтгэдэг.

i. **Мал, тэжээвэр амьтдын тооллого** - мал, амьтдын өсөлт, бууралт, сүргийн бүтцэд гарч байгаа өөрчлөлтийг улсын хэмжээгээр болон бүс нутаг, засаг захиргааны нэгжийн хуваарийн дагуу мал, амьтдыг төрөл тус бүрээр нарийвчлан гаргаж, тухайн нэг жилийн доторхи мал сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үр дүнгийн холбогдох бүх мэдээллийг үнэн зөв тодорхойлох зорилгоор жил бүр мал тооллогыг явуулдаг.

j. **Малын хагас жилийн тооллого** - даатгалын нөхөн төлбөр олгоход суурь мэдээлэл болгох зорилгоор энэхүү тооллогыг түүврийн аргаар 3000 гаруй өрхөд явуулдаг.

k. **Хашаа, худаг, тэжээлийн тооллого** – мал ахуйн үйлдвэрлэлд ашиглагдаж буй хашаа, худаг, тэдгээрийн ашиглалт, хангамж, бэлтгэсэн тэжээл, тэжээлийн хангамжийг тодорхойлох зорилгоор 3 жил тутам энэхүү тооллогыг мал тооллоготой хамтатган зохион байгуулдаг.

l. **Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого** - аж ахуйн нэгж, байгууллагын талаар дэлгэрэнгүй мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, статистикийн мэдээлэлд бүрэн хамруулах, тэдний эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл, байршил, улс орны эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодорхойлох, эдийн засаг-статистикийн судалгаа, түүвэр ажиглалтын хамрах хүрээг бүрэн тогтоох зорилгоор 5 жилд нэг удаа энэхүү тооллогыг явуулдаг.


m. **ХАА-н тооллого** - хөдөө аж ахуйн салбарын хамрах хүрээг бүхэлд нь тогтоож, олон улсын стандартад нийцсэн, харьцуулахуйц тоон үзүүлэлт, мэдээллийн системийг бүрдүүлж, хүнсний аюулгүй байдал, хангамжийг хянах, үнэлэх, дүн шинжилгээ хийх зэргээр хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага, салбарын бодлого боловсруулахад шаардагдах тоон мэдээллийг бий болгох зорилгоор 10 жил тутам зохион байгуулдаг.

n. **ХАА-н завсрын тооллого** - хөдөө аж ахуйн салбарын хөгжил болон хүнсний аюулгүй байдал, хангамжийг үнэлэх гол үзүүлэлтүүдийг шинэчлэх зорилгоор 5 жил тутам явуулдаг.

o. **Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллого** - Хүн ам зүйн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, хэтийн төлөвлөлт хийх, түүхийн үнэт лавлагаа болох дэлгэрэнгүй мэдээллийг бүрдүүлдэг энэхүү тооллогыг 10 жил тутам явуулдаг.

p. **Хүн ам, орон сууцны завсрын тооллого** - хүн амын тоо, нас хүйсийн бүтэц, угсаатны бүрэлдэхүүн, байршил, орон сууцны төрөл, нөхцөл зэрэг нийгэм, эдийн засгийн чухал тоо баримтыг богино хугацаанд шинэчлэх зорилгоор 5 жил тутам явуулдаг.

Зураг 2. Төрийн захиргааны төв байгууллагуудаас ирүүлж буй мэдээний төрөл, хувиар



Төрийн захиргааны төв байгууллагууд (27)-д статистикийн мэдээлэл хариуцан ажилладаг ажилтнууд 2018 онд 206 төрлийн мэдээг сар, улирал, жилийн давтамжаар нийт 608 удаа анхан шатны нэгжээс авч нэгтгэн тус хороонд ирүүлсэн байна.

Анхан шатны нэгжээс цуглуулан авч байгаа мэдээллийг Үндэсний статистикийн хорооны ажилтнууд хүлээн авч, шалгаж нэгтгэн хэвлэмэл, цахим гэсэн хоёр төрлийн мэдээллийг ашиглахад хялбар, ойлгомжтой хэлбэрүүдээр хэрэглэгчид тархааж байна. Аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар мөн суманд статистикийн мэдээлэл хариуцаж буй ажилтнууд, багийн Засаг дарга нар орон нутгийн хэрэглэгчдэд хэвлэмэл, цахим мэдээллийг тогтмол тархааж ажиллаж байна.

2. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ, ДАВТАН СУРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭ

Сургалт нь албан хаагч ялангуяа анхан шатны нэгжийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, мэргэшлийн бэлтгэл, ур чадвартай болгоход чухал ач холбогдолтой үйл явц юм. Монгол Улсын Статистикийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд 2012 оноос 4 шатлалт сургалтыг зохион байгуулж ирсэн бөгөөд сургалтаар статистикийн онол, нийгэм, эдийн засгийн салбарын статистик, эконометрик, статистикийн програм хангамж, үндэсний тооцоо, түүврийн дизайн, салбарын хууль, эрх зүйн мэдлэг олгодог байна. Тус хорооноос зохион байгуулдаг төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулдаг дөрвөн шатны сургалтад 2018 онд нийт 81 албан хаагч хамрагдсаны 12.3 хувь буюу 10 нь нийслэл, дүүргийн албан хаагчид байна. Түүнчлэн орон нутагт ажиллаж байгаа ажилтнуудын дүн шинжилгээ хийх чадварыг улам сайжруулах, хэрэглэгчдэд тархааж буй мэдээллийн төрөл, хэлбэр, ашиглалтыг нэмэгдүүлэх үүднээс SPSS, E-VIEWS программын сургалт зохион байгуулж, аймгуудын статистикийн хэлтэст ажиллаж буй 21 албан хаагчдад эдгээр программуудыг ашиглан цуглуулсан мэдээлэлдээ хэрхэн дүн шинжилгээ хийх талаар мэдлэг олгосон байна.

УСХ нь статистикийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг өргөн нэвтрүүлэх, ашиглах, статистикийн мэдээллийн нэгдсэн санг төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбон, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад ихээхэн анхаарч ажилласан бөгөөд орон нутагт ажиллаж буй албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулж, нийт 31 албан хаагчид дотоод, гадаад сүлжээний тоног төхөөрөмжтэй хэрхэн ажиллах, албан цахим шууданг зөв зохистой ашиглах, аюулгүй байдлыг хангах, тоон гарын үсгийг ашиглах, статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn, системийн мэдээллийг хэрхэн удирдах, тооллого, судалгааны программ, системийг хэрхэн ашиглах талаарх шинэ мэдлэг олгосноос гадна мэдээллийн технологийн чиг хандлага, хиймэл оюун ухаан, статистикийн үйл ажиллагаанд шинэ технологи ашиглах шаардлага, ач холбогдлын талаар өргөн хүрээний мэдээлэл өгч, Үндэсний дата төв, Мобиком ХХК-ийн үйл ажиллагаатай танилцуулж практик мэдлэг олгосон байна. Мөн “ДНБ-ийг тооцох арга зүй, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны жилийн эцсийн тайланг ашиглах нь” сэдэвт сургалт зохион байгуулж, нийслэл, дүүргийн 54 албан хаагчдад аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны жилийн эцсийн тайланг хэрхэн хүлээн авах, шалгах талаарх практик мэдлэг олгосон байна.


Дотооддоо зохион байгуулсан сургалтаар дамжуулан шинэ мэдлэг, мэдээлэл, ажлын ур чадвар олгохоос гадна гадаадад урт, богино хугацааны сургалтад хамруулж мэргэшүүлэх арга хэмжээ авч байна. Олон улс болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан 72 удаагийн сургалт, семинар, арга хэмжээнд 67 (давхардсан тоогоор 111) албан хаагчид оролцож мэдлэг чадвараа дээшлүүлж бусад улс орноос холбогдох сэдвийн хүрээнд туршлага судаллаа.

“Статистикийн тухай” хуулийн 11.6-д “Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ. Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна” гэж заасан байна. Энэхүү заалт нь яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад жигд хэрэгжээгүй ч 2018 оны байдлаар төрийн 26 байгууллагаас тус

хороонд мэдээ, тайлан ирүүлснээс Монгол банк (Судалгаа, статистикийн газар), Гаалийн ерөнхий газар (Статистикийн хэлтэс), Татварын ерөнхий газар (Мэдээлэл, технологи, статистикийн төв), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Эрүүл мэндийн мэдээллийн алба), Цагдаагийн ерөнхий газар (Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба), Авилгатай тэмцэх газар (Судалгаа шинжилгээний алба), Шүүхийн ерөнхий зөвлөл (Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн) зэрэг байгууллагууд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна. Бусад байгууллагуудын хувьд 1-2 ажилтан статистикийн мэдээлэл хариуцан ажиллаж байна.


УСХ нь яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад статистикийн мэдээлэл хариуцан ажилладаг албан хаагчдын чадавхыг бэхжүүлэхэд анхаарч ажилладаг бөгөөд 4 шатлалт сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2 албан хаагч сургалтад хамрагдсан бол 5 удаагийн гадаад сургалт, семинарт Монгол банк, БОАЖЯ, БСШУСЯ, УБЕГ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын холбогдох ажилтнуудыг оролцуулсан байна. Эдгээр албан хаагчид үндэсний тооцоо, ТХЗ-ын усны экосистемийн зорилгуудын хэрэгжилтэд мониторинг хийхэд дэлхийн ажиглалтын системийг ашиглах, ТХЗ-ын боловсролын холбогдох үзүүлэлтүүдийг тооцох, хөгжлийн бэрхшээлийн болон ердийн хөдөлгөөний статистикийн чиглэлээр мэдлэгээ дээшлүүлсэн байна.

Зураг 3. Суманд статистикийн мэдээлэл хариуцдаг албан хаагчдын бүтэц, хувиар




Системчилсэн үнэлгээ хийх аргачлалын дагуу анхан шатны нэгжид ажилладаг 145 албан хаагчаас санал асуулга авсан бөгөөд суманд төрийн сангийн мэргэжилтэн статистикийн мэдээлэл хариуцдаг гэж тэдний 78.6 хувь нь хариулжээ.

Зураг 4. Сумын төрийн сангийн ажилтан, санхүүгийн албаны дарга статистикийн мэдээлэл хариуцах нь оновчтой эсэх, хариулагчийн хариултаар



Санал асуулгад хариулсан албан хаагчдын талаас илүү нь буюу 58.6 хувь нь “Сумын төрийн сангийн ажилтан юм уу санхүүгийн албаны дарга статистикийн мэдээлэл хариуцах нь оновчгүй байна” гэсэн хариулт өгсөн бол 25.5 хувь нь “Сумын түвшин дэх арай дээр сонголт, өөр сонголт байхгүй” гэж хариулжээ. Хариулагчдын олонх нь сумын төрийн сангийн ажилтан юм уу санхүүгийн албаны дарга статистикийн мэдээлэл хариуцах нь оновчгүй байна гэж үзсэн нь “Статистикийн тухай” хуулийн 11.3-т “Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн болон сумын статистикийн асуудал хариуцсан ажилтан нь төрийн захиргааны албан тушаалтан байна” гэсэн заасан байдаг боловч одоо статистик хариуцан ажиллаж байгаа сумын төрийн сангийн мэргэжилтэн нь төрийн үйлчилгээний албан тушаалтан байгаатай холбоотой. Түүнчлэн санал асуулгад хариулт өгсөн албан хаагчдын 81.4 хувь нь суманд статистикийн мэдээлэл хариуцсан орон тооны ажилтан байх шаардлагатай гэж үзсэн байна.

Зураг 5. Суманд орон тооны ажилтан шаардлагатай эсэх, хариулагчийн хариултаар



Санал асуулгад “Тийм” гэж хариулсан албан хаагчид суманд статистикийн мэдээлэл хариуцсан орон тооны ажилтантай болох шаардлага нь дараах шалтгаанаас үүдэн гарч байгааг тодорхойлжээ. **Үүнд:**

1. “Статистикийн тухай” хуульд заасан учраас;
2. Статистикийн ажил нь өдөр тутам их ачаалалтай, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнээс холбогдох мэдээг сар, улирал бүр тогтмол мэдээлэл цуглуулах шаардлага байнга гардаг, багийн Засаг дарга нарын цуглуулсан мэдээллийг хүлээн авч, шалгах, нэгтгэн дамжуулж, хэрэглэгчдийг мэдээллээр ханган ажилладаг;
3. Санхүүгийн тайлан мэдээнүүдийн хугацаа, статистикийн мэдээлэл гаргах хугацаа бүгд давхацдаг учир хүндрэлтэй байдгаас аль аль ажил нь хугацаа хоцрох, алдаа гарах эрсдэл их байдаг, ялангуяа жилийн эцэст мал тооллогын ажил, санхүүгийн болон статистикийн мэдээ тайлангуудаа гаргах хугацаа бүгд давхцаад үнэхээр хүнд байдаг;
4. Нэг хүн дагнан хариуцвал мэдээ мэдээлэл илүү үнэн бодитой, түргэн шуурхай, хамралт сайтай болно;
5. Суманд мэргэжилтэнтэй болсноор анхан шатны мэдээнд тавих хяналт сайжирч, мэдээний үнэн бодит байдал нэмэгдэнэ;
6. Суманд статистикийн ажлыг төрийн сангийн төсвийн мэргэжилтэн хавсарч хийж байгаа нь төрийн сангийн мэдээний хугацаатай манай статистикийн мэдээний хугацаа давхцаж, үндсэн ажилдаа илүү анхаарч статистикийн ажлыг хойш тавих, суманд хяналтгүй мэдээлэл ирүүлэх эрсдэлтэй;
7. Багийн дарга нар сонгуульт ажилтан учир 4,4 жилээр солигдож, мэдлэг боловсрол, компьютерт ажиллах чадвар нь харьцангуй өөр өөр түвшний хүмүүс сонгогддог нь статистикийн анхан шатны мэдээлэлд алдаа гарах магадлал үүсгэж, сумын мэргэжилтэн маш их цаг гаргаж, заавал шалгах хэрэгтэй болдог;
8. Сум, багаар задарсан мэдээллийн бааз бүрдүүлэх шаардлага тулгарч буй өнөө үед суманд нэг мэргэжилтэнтэй байж, үнэн зөв мэдээллийг нэгтгэж, алдаа гарвал хариуцдаг байх тогтолцоо зайлшгүй шаардлагатай байна. Мэдээ нь анхан шатнаасаа үнэн зөв гарч байж, цаашдын бодлого төлөвлөлт үнэн зөв гарна.

ДҮГНЭЛТ

1. Үндэсний статистикийн хороо нь Монгол Улсын “Статистикийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн, сайн явуулж, албан ёсны статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээ түүний дотор анхан шатны мэдээллийн чанарыг хангаж, чанартай, бодитой мэдээллээр бүх түвшний хэрэглэгчдийг ижил тэгш, шуурхай хангахад анхаарч статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг өргөн ашигласнаар мэдээллийн нээлттэй байдал нэмэгдэж, хэрэглэгчид статистикийн мэдээллийг орон зайнаас үл хамааран цаг алдалгүй авах боломжийг бүрдүүлсэн байна гэж дүгнэж байна. Учир нь Open Data Watch байгууллагаас дэлхийн 178 улс орны статистикийн байгууллагуудын мэдээллийн хүртээмж болон нээлттэй байдлыг үнэлсэн судалгааны үр дүнгээр Монгол Улс Азийн бүсэд тэргүүлж, дэлхийд 11 дүгээрт жагссан байна.
2. Анхан шатны нэгжээс цуглуулж байгаа мэдээ, тайлан болон тооллого, судалгааны анхдагч мэдээллийн чанарт тавих нэгжийн дотоод хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх, арга зүйн нэгдмэл байдлыг хангах, статистикийн төв, орон нутгийн байгууллага болон албан ёсны статистикийн мэдээлэл гаргахад оролцогч талууд түүний дотор анхдагч мэдээллийг гаргадаг анхан шатны нэгжийн хамтын ажиллагаа, эргэх холбоог улам сайжруулах үүднээс төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран ажиллаж, хамтын ажиллагааны олон хэлбэрийг хэрэгжүүлж байгаа нь бусдадаа үлгэр жишээ болохуйц санаачилга гэж үзэж сайшааж байна.
3. Цаашид дээр дурдсан амжилтуудаа ахиулах, бататгахад цуглуулсан мэдээлэлд хийж буй анализ шинжилгээ болон хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж буй мэдээллийн хэрэгцээтэй уялдуулан тархааж буй мэдээлэлд шинжлэх ухааны ойлголт, томьёоллыг хялбаршуулсан ойлгомжтой тайлбарыг нэмэгдүүлэх, орон нутгийн ажилтнуудын энэ чиглэлийн чадавхыг бэхжүүлэх зайлшгүй шаардлага гарч байна. Үүнтэй холбоотойгоор төв, орон нутагт түүний дотор анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилтнуудыг чадавхжуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж дадлагажуулах, салбар бүрийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх цагийг нэмэгдүүлэх үүднээс УСХ-ны орон тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх шаардлагатай нь харагдаж байна.
4. Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ын нийт 244 үзүүлэлтүүдээс Монгол Улсад

хамааралтай 233 шалгуур үзүүлэлтүүд байгаагаас 115 үзүүлэлт нь мэдээллийн эх үүсвэр тодорхойгүй, тооцох боломжгүй байна. Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ын шалгуур үзүүлэлтүүд тооцох эх үүсвэр тогтвортой, найдвартай, тогтмол баяжуулах боломжтой байх шаардлагатай бөгөөд энэ шаардлагаас үүдэн, нөгөө талаас “Статистикийн тухай” хуулийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс яамд бүтцэдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй, суманд статистикийн мэдээлэл хариуцсан орон тооны ажилтантай болох зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

5. Түүнчлэн засаг захиргааны анхан шатанд статистик мэдээлэл хариуцан ажиллаж байгаа албан хаагчид, багийн Засаг дарга нарыг байнга сургах, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч “Статистикийн тухай” хуулийн 17.4-т заасан “албан ёсны статистикийн мэдээллийг боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэхэд олон улсын байгууллага, гадаад орнуудын төсөл хэрэгжүүлэх” албан ёсны статистикийн үйл ажиллагааны талаарх Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газар, УИХ-ын ЭЗБХ болон холбогдох бусад байгууллагуудын дэмжлэгийг авах шаардлагатай байна. Статистикийн үйл ажиллагаанд төдийгүй төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд цахим мэдээллийг өргөнөөр ашиглаж буй өнөө үед анхан шатны нэгж буюу сум, баг, хороонд ажиллаж буй ажилтнуудын компьютер, тоног төхөөрөмж, мэдээлэл солилцох сүлжээний технологийн асуудлыг ч мөн Засгийн газар, УИХ-ын ЭЗБХ болон холбогдох бусад байгууллагуудын дэмжлэгийг авах нь зайлшгүй чухал байна.

6. УИХ-аас батлагдсан “Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг баяжуулах, улам сайжруулах, статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг илүү өргөн хүрээнд ашиглах, төв, орон нутгийн статистикийн байгууллагуудын технологийн чадавхыг сайжруулахад статистикийн байгууллагын төсөв, санхүүгийн асуудал чухал үүрэгтэй юм.

7. Статистикийн үйл ажиллагааны тайланд тусгагдсан тоо, баримт, ажиглалт зэрэгт үндэслэн цаашид дадлага туршлагатай, хөрвөх чадвар бүхий ажилтнуудын залгамж халааг бэлтгэх, ажилтнуудын нийгмийн асуудлыг тодорхой үе шатаар шийдвэрлэхэд анхаарч ажиллах, энэ чиглэлээр УИХ-ын ЭЗБХ болон холбогдох бусад байгууллагуудын дэмжлэгийг авах шаардлагатай гэсэн дүгнэлтийг хийж байна.

ХАВСРАЛТ. УСХ-ноос 2018 онд шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлсэн аргачлал, маягт, асуулга, нөхөх зааврын жагсаалт

№	Аргачлал, маягт, асуулга, нөхөх зааврын нэр
1	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын “Ашигт малтмалын хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны 20... тайлан”-ын маягт, нөхөх заавар
2	2018 онд мөрдөх “Хүн амын амьжиргааны доод түвшин”
3	Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны статистикийн маягт, заавар
4	Бүх шатны шүүхийн Эрүүгийн хэрэг, зөрчлийн хэргийн албан ёсны статистикийн мэдээллийн 5 маягт, заавар
	Бүх шатны шүүхийн Эрүүгийн хэрэг, зөрчлийн хэргийн захиргааны мэдээллийн 11 маягт, заавар
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн салбарын статистикийн маягт, заавар
6	Ажиллах хүчний судалгааны түүврийн дизайн
7	Ажиллах хүчний судалгаа (Туршилт 2018)-ын асуулга,түүнийг нөхөх заавар
8	Ажил, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дутуу ашиглалтын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал
9	Соёл, урлагийн салбарын албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн маягт, заавар
10	Авлигын статистикийн маягт, заавар
11	Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн БР-1 маягт, заавар
12	"Материалын урсгалын дансыг байгуулах аргачлал"
	"Эрчим хүчний биет урсгалын дансыг байгуулах аргачлал"
	"Байгаль орчны татварын дансыг байгуулах аргачлал”
13	Налайх дүүрэгт зохион байгуулж явуулах Зөвлөлдөх санал асуулгын судалгааны түүвэр хийх аргачлал
14	Тарилгатай халдварт өвчний дархлал тогтоц, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийн судалгааны түүвэр хийх аргачлал
15	“Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018”-ын үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар
16	Цэргийн дүйцүүлэх албаны маягт, заавар
17	Нийслэлийн хөгжлийн индекс тооцох аргачлал
18	"Засаглал ба хэрэглэгчийн төлөв байдлыг тодорхойлох судалгаа"-ны асуулга, заавар
19	Хаягт суурилсан Байшин, орон сууцны туршилтын тооллогын аргачилсан заавар
20	“Өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөх гэнэтийн хүндрэл, бэрхшээлийн судалгаа”-ны асуулга, түүнийг нөхөх заавар
21	Нийгмийн зарим үзүүлэлтийн маягт, түүнийг нөхөх заавар
22	Биеийн тамир, спортын салбарын маягт, түүнийг нөхөх заавар
23	Байгаль орчныг хамгаалах зардлын дансыг байгуулах аргачлал
24	“Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа – 2018”-ийн асуулга, түүнийг нөхөх заавар
25	Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал
26	Нийгмийн халамж, даатгалын салбарын маягт, түүнийг нөхөх заавар
27	Авто тээвэр, төмөр замын тээвэр, агаарын тээврийн маягт, түүнийг нөхөх заавар
28	Барилга байгууламж, объектын улирлын мэдээ (ББО-1) - ний маягт, түүнийг нөхөх заавар
29	Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал

№	Аргачлал, маягт, асуулга, нөхөх зааврын нэр
30	Хүн амын ердийн хөдөлгөөн, шилжих хөдөлгөөний болон суурин хүн амын мэдээний маягт
31	Гэр бүлийн статистик үзүүлэлт тооцох аргачлал
32	Гадаад улс орнуудаас хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажиллагч, мэргэжилтний 20.... оны ...улирлын мэдээний маягт, түүнийг нөхөх заавар
33	Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн сарын мэдээний албан ёсны маягт, нөхөх заавар
34	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал
35	Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын туршилтын тооллогын үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар
36	Орон сууцны үнийн индекс тооцох аргачлал
37	Залуучуудын статистик үзүүлэлтийн хүрээ болон үзүүлэлт тооцох аргачлал
38	Оюуны өмчийн салбарын статистикийн маягт, түүнийг нөхөх заавар
39	Эрүүл мэндийн даатгалын статистик мэдээний маягт, нөхөх заавар